



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



“Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл

ДОТОР МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Судалгааны тайлан



2024 он



ДОТОР МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгааны тайланг Европын Холбооны санхүүжилтэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ: Энэхүү судалгааны тайлан нь Европын Холбооны санхүүжилтээр боловсруулагдсан бөгөөд төрийн бодлого, төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцогчдод зориулсан. Судалгааны тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хариуцлага хүлээхгүй болно. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

Судалгааны ажлын тайлан бичсэн:

Доктор (Ph.D), профессор Р.Батмэнд
Доктор (Ph.D), профессор П.Мөнхтуяа
Магистр Б.Болдбаатар МЭЕГ
Магистр Б.Мөнхзаяа ММХ, Преком ХХК
Магистр А.Доржпалам ММХ
Бакалавр И.Баттогтох ММХ

Тайланг нэгтгэж, хянан тохиолдуулсан:

Багийн ахлагч Н.Батсуурь, Доктор (Ph.D)
Монголын Махны Холбооны Гүйцэтгэх Захирал

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН ХАМАРСАН ХҮРЭЭ	8
ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ	9
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ	11
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ	13
2.1 Судалгааны зорилго	14
2.2. Судалгааны зорилт	14
2.3. Судалгааны объект	14
2.4. Судалгааны арга зүй	14
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, ТААМАГЛАЛ: ЭХ ҮҮСВЭРЭЭР	18
3.1. Монгол Улсын дотор мах, дайвар түүхий эдийн нөөц	18
3.2. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн зах зээлийн өөрчлөлт	21
3.3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн өртгийн сүлжээний шинжилгээ	22
3.4. Дотор мах, дайвар түүхий эдийн зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйлийн шинжилгээ	23
3.5. Хүнсний голлох дотор мах, дайварын зах зээлийн нэвтрэлт ба өсөлтийн төлөв	24
БҮЛЭГ 4. МАЛЫН ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ГАРЦ, НӨӨЦ	25
4.1. Дотор мах, дайвар түүхий эдийн гарц тодорхойлох	25
4.2. Монгол Улсын дотор мах, дайвар түүхий эдийн нөөц	29
4.3. Дотор мах, дайвар түүхий эдийн гарц тогтоох хэмжилтийг сайжруулах асуудал	34
БҮЛЭГ 5. ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА	35
5.1. Дотор мах, дайвар түүхий эдийн ашиглалт, боловсруулалт	35
5.2. Дотор мах, дайварын дотоод зах зээл дээрх борлуулалтын байдал	40
5.3. Нийтийн хоол үйлдвэрлэлийн талаарх судалгааны тойм	43
5.4. Хэрэглэгчийн зан төлөв, хандлагын судалгаа	44
БҮЛЭГ 6. ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА	51
6.1. Олон улсын зах зээлийн тойм	51
6.2. Хүнсний дотор мах, дайварын бүс нутгийн зах зээл: Гол баримтууд	52

6.3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын экспорт, импортын өнөөгийн байдал	54
6.4. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын экспортыг нэмэгдүүлэх гарц, боломж	56
6.5. Хүнсний дотор мах, дайврын экспортод гарч байгаа шинэ хандлага, туршлага	57
6.6. Дотор мах, дайвар түүхий эдийг ашиглах бусад чиглэл	57
6.7. Гэрийн тэжээвэр амьтны хоол, мал, амьтны тэжээлийн бэлдэц (HS Code 2309)	57
6.8. Монгол малын дотор махны өрсөлдөх чадвар	60
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ИДЭВХТ ХҮНСНИЙ НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТОЙМ	61
7.1. Олон улсын зах зээл дээрх биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний хэрэглээ	61
7.2. БНХАУ-ын биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээл	62
7.3. Өмнөд Солонгосын биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээл	63
7.4. Монгол Улсын биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний хэрэглээ	63
БҮЛЭГ 8. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН PESTLE ШИНЖИЛГЭЭ	65
8.1. Давуу талууд	65
8.2. Сул тал	66
8.3. Гадаад орчны хүчин зүйлийн талаарх дүн шинжилгээ	67
БҮЛЭГ 9. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ҮР ДҮН, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	70
9.1. Судалгаанаас гарсан үр дүн	70
9.2. Дүгнэлт	76
9.3. Зөвлөмж	78
БҮЛЭГ 10. МОНГОЛ УЛСЫН ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАГВАР	81
10.1. Зах зээлийн хүрээ (сегментчилэл)	81
10.2. Дотор мах, дайврын нийлүүлэлт, ашиглалт, хэрэглээний ерөнхий зураглал	82
10.3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын гадаад болон дотоод зах зээл, өртгийн сүлжээг хөгжүүлэх дунд хугацааны стратегийн төлөвлөгөө	83

ТАЙЛАНГИЙН ДОТОРХ ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1. Хүн амын хүнсний хэрэглээнд шаардагдах тураг мах, дотор мах, дайвар.....	11
түүхий эдийн биет хэмжээ, тонноор.....	11
Хүснэгт 2. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн	11
нөөцийн хэмжээ, 2019-2023 оны биет жин, тонноор	11
Хүснэгт 3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий.....	12
эдийн зах зээлийн сегментчилэл ба хамрах хүрээ	12
Хүснэгт 4. Зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйлийн үнэлгээ	23
Хүснэгт 5. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн адууны дотор мах, дайвар түүхий эдийн үнэмлэхүй жин болон харьцангуй дундаж гарц.....	26
Хүснэгт 6. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн үхрийн дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	26
Хүснэгт 7. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ямааны дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	27
Хүснэгт 8. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хонины дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	27
Хүснэгт 9. Уламжлалт аргаар бэлтгэсэн адууны дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	28
Хүснэгт 10. Уламжлалт аргаар бэлтгэсэн үхрийн дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	28
Хүснэгт 11. Уламжлалт аргаар бэлтгэсэн ямааны дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	28
Хүснэгт 12. Уламжлалт аргаар бэлтгэсэн хонины дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ	29
Хүснэгт 13. Үйлдвэрт болон уламжлалт аргаар орон нутагт төхөөрсөн малын гулуузны жин, кг-аар	29
Хүснэгт 14. Адууны дотор мах, дайвар түүхий эдийн гарц, кг-аар.....	30
Хүснэгт 15. Үхрийн дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ, кг-аар.....	31
Хүснэгт 16. Хонины дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ, кг-аар.....	32
Хүснэгт 17. Ямааны дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ, кг-аар	33
Хүснэгт 18. Монгол Улсын 2019-2023 онд хэрэгцээлсэн малын тоо, малын төрлөөр	34
Хүснэгт 19. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын нөөц: малын төрлөөр,	34
биет жин: тн-оор (2019-2023 онд хэрэгцээлсэн малын тоонд үндэслэн тооцсон).....	34
Хүснэгт 20. Үйлдвэрүүдийн бэлтгэсэн дотор мах, дайвар түүхий эдийн борлуулалт, ашиглалтын байдал, малын төрөл болон борлуулалтын хувиар	36
Хүснэгт 21. Мал төхөөрөх үйлдвэрлэлээс шууд хаягдалд тооцдог дотор мах, дайврын судалгаа (үйлдвэрүүдийн өгсөн хариулт, хувиар)	37
Хүснэгт 22. Дотор мах, дайврыг боловсруулахад учирч буй гол бэрхшээл	37
Хүснэгт 23. Дотор мах, дайврыг боловсруулахад технологийн талаас учирч буй бэрхшээл	38
Хүснэгт 24. Дотор мах, дайвар боловсруулж зах зээлд гаргахад учирч буй бэрхшээл.....	38
Хүснэгт 25. Дотор мах, дайврын борлуулалтыг идэвхжүүлэх арга зам	39

Хүснэгт 26. Малын дотор мах, дайвраар бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг гол компаниудын бүтээгдэхүүний нэр төрөл, худалдааны суваг.....	39
Хүснэгт 27. Үхрийн дотор мах, дайвар түүхий эдийн зах зээл, борлуулалтын судалгаа (2024 оны 1 дүгээр сар)	41
Хүснэгт 28. Адууны дотор мах, дайвар түүхий эдийн зах зээл, борлуулалтын судалгаа /2024 оны 1 дүгээр сар.....	41
Хүснэгт 29. Богийн дотор мах, дайвар түүхий эдийн зах зээл, борлуулалтын судалгаа /2024 оны 1 дүгээр сар/	42
Хүснэгт 30. Улаанбаатар хотын зах, худалдааны төвүүд дээр борлуулагдаж буй дотор мах, дайвар бүтээгдэхүүний хэмжээ, тн-оор	42
Хүснэгт 31. Нийслэл хотод хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгаа (2024 оны 4 сарын 15-ны байдлаар).....	43
Хүснэгт 32. Нийслэл дэх нийтийн хоолны газруудын дотор мах, дайврын нийт ашиглалтын хэмжээ	44
Хүснэгт 33. Хэрэглэгчдийн асуумж судалгааны дүн	45
Хүснэгт 34. Малын дотор мах хүнсэндээ хэрэглэдэг хэрэглэгчийн ерөнхий шинжийг тогтоох шугаман загварын үнэлгээ	46
Хүснэгт 35. Малын дотор мах хүнсэндээ хэрэглэдэг хэрэглэгчийн ерөнхий шинжийг тогтоох шугаман бус хамаарлын үнэлгээ.....	46
Хүснэгт 36. Ахиу нөлөөг 3 загвараар тооцоолсон харьцуулалт	47
Хүснэгт 37. Бог малын дотор махны хэрэглээний давтамжид нөлөөлж буй олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ.....	47
Хүснэгт 38. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан дотор мах авдаг эсэх талаарх регрессийн шинжилгээний дүн.....	48
Хүснэгт 39. Малчид зах зээлд мал, махаа хэрхэн нийлүүлдэг эсэхэд нөлөөлдөг хүчин зүйлийн шугаман загварын шинжилгээ.....	48
Хүснэгт 40. Зах зээлд нийлүүлж буй малын тоо малчны мал малласан жил болоод малын тооноос хэрхэн хамаарч байгааг харуулсан олон хүчин зүйлийн регрессийн загвар.....	49
Хүснэгт 41. Дотор мах, дайвар түүхий эд хамгийн их экспортлогч болон импортлогч 5 орны жагсаалт....	52
Хүснэгт 42. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврыг бүс нутгийн зах зээлд нийлүүлэх газар зүйн байршил: Улсаар.....	52
Хүснэгт 43. БНХАУ-ын 2020-2022 онд импортоор авсан дотор махны үнийн дүн /сая ам. доллар/, дотор махны импортод эзлэх хувь, экспортлогч орны нэрээр	53
Хүснэгт 44. БНСУ-ын 2020-2022 онд импортоор авсан дотор махны үнийн дүн /сая ам. доллар/, дотор махны импортод эзлэх хувь, экспортлогч орны нэрээр	53
Хүснэгт 45. Персийн булангийн болон бусад сонирхож байгаа орнуудын 2020-2022 онд импортоор авсан дотор махны үнийн дүн /сая ам. доллар/, экспортлогч орнуудын нэрс	54
Хүснэгт 46. Монгол Улсаас 2020-2023 онд экспортолсон дотор мах дайвар бүтээгдэхүүний үнэ, мян. ам. доллар; хэмжээ, тонн.....	54
Хүснэгт 47. Монгол Улсад 2020-2023 онд импортолсон дотор мах, дайвар бүтээгдэхүүний үнэ /мян. ам.доллар/; хэмжээ /тонн/.....	55

Хүснэгт 48. Малын дотор мах, дайврын экспорт хийдэг компаний нэр, бүтээгдэхүүний нэр төрөл, импортлогч улс	55
Хүснэгт 49. Мал төхөөрөх үйлдвэрээс гарч байгаа дайвар бүтээгдэхүүн, түүнийг ашиглах чиглэлээр нь ангилсан байдал (олон улсын)	56
Хүснэгт 50. Гэрийн тэжээвэр амьтадын хоол тэжээлийн бэлдэц хамгийн ихээр экспортолсон болон импортолсон 5 улсын жагсаалт	58
Хүснэгт 51. Япон Улсын ГТА-ны хоолны импорт болон дотоодын үйлдвэрлэл төрлөөр (2019 оны санхүүгийн жил) Хэмжих нэгж: тонноор	58
Хүснэгт 52. Япон Улсын ГТА-ны хоолны импортын болон дотоодын үйлдвэрлэл, хоолны ангилалаар (2019 оны санхүүгийн жил) хэмжих нэгж: тонноор	59
Хүснэгт 53. БНХАУ-ын гэрийн тэжээвэр амьтны хоолны импортын тоо хэмжээ (2016-2021) Хэмжих нэгж: тонноор	59
Хүснэгт 54. БНХАУ-ын гэрийн тэжээвэр амьтны хоолны импортын үнийн дүн (2017-2022 эхний 11 сар) Хэмжих нэгж: сая ам.доллараар	60
Хүснэгт 55. Монгол Улсад импортлогдсон БИБ-ийн хэмжээ /тн/, үнийн дүн /мян.ам.доллар/	63
Хүснэгт 56. Монгол Улсаас экспортлогдсон БИБ-ий хэмжээ/кг/, үнийн дүн /ам.доллар/	64
Хүснэгт 57. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийн PESTLE шинжилгээгээр гарсан давуу талын үнэлэмж	65
Хүснэгт 58. PESTLE шинжилгээний үр дүнгээр гарсан сул талын үнэлэмж	66
Хүснэгт 59. Монгол улсын дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээлийн SWOT/PESTLE шинжилгээний нэгдсэн дүн	69
Хүснэгт 60. Монгол Улсын дотор мах, дайврын зах зээлийн сегментчиллийг бүлэглэсэн бүдүүвч	81
Хүснэгт 61. Эх үүсвэрээр ангилсан дотор мах, дайврын ашиглах нөөцийн хэмжээ, 2024-2030 оны төсөөлөл (биет жин тн; үнэ мян.ам.долл)	81
Хүснэгт 62. Боловсруулах боломжит дотор мах, дайврын хэмжээний талаарх төсөөлөл, биет жин: тн-оор	81
Хүснэгт 63. Монгол Улсын дотор мах, дайврын хэрэглээний хүрээн дэх бүлэглэл ба зах зээлд нийлүүлэх дотор мах, дайврын тоо хэмжээний талаарх төсөөлөл	82
Хүснэгт 64. Түгээлтийн сувгууд дахь борлуулалтын орлогын талаарх төсөөлөл (мян. ам.долл.)	82











ДҮРСЭЛЖ ХАРУУЛСАН ЗУРГИЙН ТАЙЛБАР

Дүрслэл 1. Судалгааны аргачлал	15
Дүрслэл 2. Дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны хүрээ	17
Дүрслэл 3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын өртгийн сүлжээний ерөнхий бүтэц	22
Дүрслэл 4. Дотор мах, дайврын нийлүүлэлт, ашиглалтын хэлхээний ерөнхий бүдүүвч	83

ГРАФИКААР ХАРУУЛСАН ЗУРГУУДЫН ТАЙЛБАР

График 1. Хүнсний дотор мах, дайврын зах зээлийн нэг агшны зураглал – гол баримтууд.....	12
График 2. Дөрвөн төрлийн малын дотор мах, дайвар түүхий эд тус бүрийн зах зээлд эзлэх хувь хэмжээ, %-иар /2023-2030 он/.....	18
График 3. Монгол үхрийн хүнсний дотор мах, дайврын зах зээлийн 2019-2023 оны байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ:мян. Ам. Доллар).....	19
График 4. Монгол адууны хүнсний дотор мах, дайврын 2019-2023 он хүртэлх зах зээлийн байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ: мян. Ам. Доллар).....	19
График 5. Монгол хонины хүнсний дотор мах, дайврын 2019-2023 он хүртэлх зах зээлийн байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ:мян. Ам. Доллар).....	20
График 6. Монгол ямааны хүнсний дотор мах, дайврын 2019-2023 оны зах зээлийн байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал, (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ:мян. Ам. Доллар).....	21
График 7. Монгол улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийн өөрчлөлт, хэрэглээний ангилалаар ..	21
График 8. Зах зээлд борлогдож байгаа зарим нэрийн дотор мах, дайврын нөөцийн хэмжээ.....	24
График 9. Хүнсний дотор мах, дайврын шинэ зах зээлд нэвтрэх боломж ба өсөлтийн хэтийн төлөвийн зураглал.....	25
График 10. Дотор мах, дайвар зарж борлуулж байгаа захын тоо (дотор мах, дайврын нэр төрлөөр).....	25
График 11. Дэлхийн биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ.....	61
График 12. Ази номхон далайн орнуудын хоол тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ ..	62

ТАЙЛАНГИЙН ХАМАРСАН ХҮРЭЭ

Дотор мах, дайврын зах зээлийн үр дүнд нөлөөлөгч хүчин зүйлүүд			Дотор мах, дайврын зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйлүүд	
				
Гүйцэтгэлийн хэмжилтүүд	Шинэ боломжууд	Хэрэглэгчийн зан төлөв, эрэлт хэрэгцээ	Өөрчлөлтийн шаардлага	Өрсөлдөх чадвар
-Нөөцийн хэмжээ -Нөөцийн ашиглалт, чиг хандлага -Нийлүүлэлтийн сүлжээ -Өртгийн сүлжээ -Боловсруулалт -Зах зээл дэх бүтээгдэхүүний түгээлт	-Засгийн газрын бодлогын өөрчлөлт -Маркетингийн стратеги	-Хэрэглээний хэв маяг -Хэрэглэгчийн боловсрол -Маркетингийн сурталчилгаа	-Эрэлтийг өсгөх -Зах зээлийн идэвхжүүлэлт -Салбарын өсөлтийн хурд -Технологийн шинэчлэл -Хөрөнгө оруулалт, -Менежментийн сайжруулалт	-Шинэ зах зээлд нэвтрэх -Одоо байгаа зах зээл дээр байр сууриа бэхжүүлэх -Төрөлжих, дагнах -Бүтээгдэхүүний хөгжүүлэлт, бренд бий болгох -Кластерийн хөгжил
				
Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл	Аюул занал	Бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал	Алдагдсан боломжууд	Инноваци, технологийн хөгжил
-Улс төр -Эдийн засаг -Нийгэм -Технологи -Хууль эрх зүй -Хүрээлэн буй орчин	-Улс төрийн -Эдийн засгийн -Нийгмийн -Технологийн -Хууль эрх зүйн -Хүрээлэн буй орчны	-Гарал үүсэл, эргэн мөшгөх тогтолцоо -Чанар, аюулгүй байдлын хяналт, баталгаажуулалт -Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	-Ашиглагдаагүй нөөц -Нийлүүлэлтийг дэмжих, урамшуулах механизм -ДХБ-ын зохицуулалтын хүрээнд хийгдэх гэрээ хэлэлцээр, протокол, тохиролцоо	-Түүхий эд бэлтгэлийн тогтолцоо - хүнсний дотор мах, дайврын цэвэр, аюулгүй байдлын баталгаа. -Боловсруулалт, хадгалалтын хугацаа -Хэрэглэхэд хялбар байдал
Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийн үр ашигт сөрөг нөлөөлж буй хүчин зүйлүүд				
Үр ашиг буурах гол нөхцөл	Гүйцэтгэлийг хэмжихэд тулгарч буй бэрхшээл	Гаднын хүчин зүйлийн учруулж буй бэрхшээл	Өрсөлдөх чадварт нөлөөлж буй хүчин зүйлс	Салбарын хөгжилд нөлөөлж буй зүйлс
-Нөөцийн хаягдал -Өртөг шингээлт	-Нийлүүлэлтийн сүлжээ албан бус, институци байхгүй -Өртгийн сүлжээний хөгжил сул	-Малын халдварт өвчин -Зах зээлийн тогтворгүй байдал -Хотжилт -Уур амьсгалын өөрчлөлт	-Улирлын чанартай, бага хэмжээтэй нийлүүлэлт -Тээвэр, логистикийн сүл хөгжил -Транзит тээврийн асуудал	- Төрөөс баримтлах бодлогын уялдаа холбоо -Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилт -Судалгаа, мэдээлэл

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Тайлангийн бүтэц	Тайланд дотор мах, дайврын зах зээлийн чиг хандлагын шинжилгээнээс эхлээд зах зээлийн тооцоо, таамаглал хүртэлх зах зээлийн өгөгдлийн боломжит тоо баримт, тооцоолол, жишээг багтаасан болно Энэ хүснэгт нь тайлангийн бүтэц болон тайлан хэрхэн харагдахыг ойлгоход тусална
Агуулгын жагсаалт	Энэ хэсэг нь тайлангийн бүтэц, судалгааны цар хүрээг нарийвчлан судалж үзэхэд тусална Тайлангийн өгөгдөл болон дүн шинжилгээ, зөвлөмжийг шүүн үзэж, тэдгээрийг өөрийн шаардлагад нийцүүлэн зураглах боломжтой. Тайланг өөрийн шаардлагад нийцүүлэн тохируулах боломжтой
Судалгааны арга зүй	Дотор мах, дайврын зах зээлийн судалгаа явуулах арга зүйн дэлгэрэнгүй танилцуулга Шинжээчийн дүгнэлт, тооцоололд үндэслэсэн тогтолцоонд хандах боломж олгоно. Тайлан гаргах үйл явцтай холбоотой бүх асуудлыг ил тодоор харах болно.
Тайлангийн үндсэн бичвэр	Тайлан нийт 10 бүлэгтэй. Бүлэг тус бүрийн холбогдох мэдээллийг энгийн бичвэр, хүснэгт, график, дүрслэлээр харуулсан. Энэ тайлан нь Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ болон зах зээл дэх тэдгээрийн нийлүүлэлт, ашиглалтын өнөөгийн байдлын талаарх мэдээллийг агуулсны зэрэгцээ 2030 он хүртэлх хугацааны ерөнхий төлөв, чиг хандлагын талаар судалгааны багаас гаргасан таамаглалыг харуулахыг зорьсон. Түүнчлэн: <ul style="list-style-type: none"> • 4 төрлийн малаас гарах дотор мах, дайвар түүхий эдийн гарцыг хэмжих, нэгтгэн тооцох талаар гүйцэтгэсэн ажлын үр дүн; • эцсийн хэрэглэгчид болон бизнесийн салбарын худалдан авагч нарын эрэлт хэрэгцээ, зан төлөвийн талаарх судалгааны дүн; • Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийг өргөжүүлэх боломж болон зорилтот зах зээлийн орнуудын хүнсний дотор мах, дайврын импорт, эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн сүвгийн талаарх судалгаа, мэдээлэл; • Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийг өргөжүүлэх, идэвхжүүлэх, зах зээл дээрх эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх талаар цаашид анхаарах асуудлуудыг нэгтгэн дүгнэж, төслийн багаас гаргасан санал, зөвлөмжийг тусгасан. Тайлангийн холбогдох бүлгүүдэд зориулж багийн гишүүд-шинжээчдийн боловсруулсан судалгааны үр дүн, тайланг хавсралт тайлан байдлаар тус тусад нь гарган танилцуулж байна. Тайланд тусгагдсан тодорхой асуудлыг нарийвчлан тодруулах шаардлага гарвал та холбогдох хавсралт тайланг лавлагаа болгон ашиглах боломжтой.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АНУ	Америкийн нэгдсэн улс
БИБ	Биологийн идэвхт бүтээгдэхүүн
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ГТА	Гэрийн тэжээвэр амьтан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МБҮ	Мах боловсруулах үйлдвэр
МЭС	Мал эмнэлгийн сургууль
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
СХД	Сонгино Хайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУТ	Шинжлэх ухаан технологи
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан
ЭШАА	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Монгол Улсын мал сүргийн тоо 2023 оны байдлаар 70 сая орчим бөгөөд мал аж ахуй, махны үйлдвэрлэл нь хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80, ДНБ-ий 13 орчим хувийг бүрдүүлдэг.

Оны эхний нийт малын дунджаар 22.2%-ийг, үүнээс үхрийн 21.2%, хонины 27.4%, ямааны 18.4%, адууны 13.7%, тэмээний 11.7%-ийг хүнсэнд төхөөрдөг бөгөөд бэлтгэж буй махны 25-30 хувийг үхрийн, 35-40 хувийг хонины, 10-15 хувийг ямааны, 15-20 орчим хувийг адууны мах эзэлдэг байна.

Жил тутам хүнсэнд бэлтгэж байгаа махыг дагалдан ихээхэн хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гардаг. Дотоодын зах зээл дээр хүнсний дотор мах, дайвар түүхий эд илүү хямд байгаа тул өрхийн төсөвт дарамт болохгүйгээр уургийн хэрэгцээгээ хангахыг хүсэж буй хэрэглэгчдэд тааламжтай сонголт болох юм. Түүнээс гадна уламжлалын дагуу хүн амын 95-аас дээш хувь нь дотор махыг хүнсэнд ямар нэг хэмжээгээр хэрэглэдэг болох нь бидний судалгаагаар харагдсан болно.

Монгол Улсын хүнсний дотор мах, дайварын нийт нөөц 2023 оны үнээр тооцвол 167.3 сая ам.доллараар үнэлэгдэж байгаа бөгөөд үүний 9.4 хувь буюу 14.1 сая ам.долларын үнэ бүхий дотор мах, дайвар түүхий эдийг дотоодын зах зээлд борлуулах багтаамжтай байна. Дотоод зах зээлийн хэрэгцээ 2030 он хүртэлх хугацаанд 10.5 %-иар өсөх боломжтой байна. Үүнийг тооцож гаргахдаа 2023 оны жишсэн дундаж хүн амын тоог 2778499, түүний хэрэглэх нийт махны 20%-ийг дотор мах, дайвар түүхий эд байхаар (24339 тн) тооцов.

Хүснэгт 1. Хүн амын хүнсний хэрэглээнд шаардагдах тураг мах, дотор мах, дайвар түүхий эдийн хэмжээ, тонн

Хүн ам	Улсын хэмжээнд		
	2020 он	2025 он	2030 он
Нийт хүн ам	3225152	3525834	3767314
Жишсэн хүн ам	2628499	2873555	3070361
Жишсэн нэг хүний жилийн махны дундаж норм	43.8	43.8	43.8
Жишсэн хүн амд жилд шаардагдах нийт махны хэмжээ, тн	115128.3	125861.7	134481.8
Хүн амын хүнсэнд хэрэглэх дотор махны хэмжээ (10%)	11512.8	12586.2	13448.2
Хүн амын хүнсэнд хэрэглэх дотор махны хэмжээ (15%)	17269.2	18879.3	20172.3
Хүн амын хүнсэнд хэрэглэх дотор махны хэмжээ (20%)	23025.7	25172.3	26896.4

Тайлбар: Жишсэн хүн амын жилийн хэрэгцээт махны нийт дүнд хүнсний дотор мах, дайварын эзлэх хувийг 10, 15, 20% байх 3 хувилбараар тооцов.

Хэрэв жишсэн дундаж хүн амын хэрэгцээт махны 10% нь хүнсний дотор мах, дайвар түүхий эд байхаар тооцвол энэ нь 2025 онд 12.6 мянган тн, 2030 онд 13.5 мянган тонн болно. 15 хувиар тооцвол энэ тоо 18.9; 20.2 мян.тн болох ба бүр 20%-иар авч үзвэл 25.2; 26.9 мян. тонн байхаар байна. Өөрөөр хэлбэл, манай дотоодын зах зээлийн хэмжээ ойролцоогоор 13.0-27.0 мянган тонн байх боломжтой. Бид цаашдын тооцоонд энэ 20%-ийн хэрэглээг суурь нөхцөл болгон авсан болно.

Манай улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн нийт нөөцийн хэмжээг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн нөөц, 2019-2023 оны биет жин, тонноор

Он	2019	2020	2021	2022	2023	
Дотор мах, дайвар түүхий эдийн биет хэмжээ, тн	Адууны	9974.5	15041.3	8982.2	10316.3	8530.2
	Үхэр	42277.8	59109.1	40,293	49432.3	47116.2
	Хонь	118928.7	154099.8	102212.9	129739.5	132088.9
	Ямаа	65709.4	96048.3	70981.1	84698.2	72045.9
Нийт дүн	236890.4	324298.5	222469.3	274186.3	259781.2	

Сүүлийн таван жилд манай улс таван төрлийн малын дунджаар 260 мянган тн дотор мах үйлдвэрлэснээс 205 мянган тонн буюу 80 хувь нь бог малынх байна. 2025 он хүртэл өсөх жишсэн хүн амын махны хэрэгцээний 20 хувийг дотор махаар хангана гэж үзвэл энэ нь 25 мянган тонн болно (хүснэгт 1). Өөрөөр хэлбэл жилд үйлдвэрлэж байгаа дотор махны 10 орчим хувийг л дотоодын зах зээл шингээх боломжтой дүр зураг харагдаж байна. Иймд үлдэх 90 орчим хувиас боловсруулж ашиглах хэмжээг нэмэгдүүлэх, өөр зах зээлд борлуулах зэрэг арга замыг хайх шаардлагатай юм.

Одоогийн байдлаар дөрвөн төрлийн малын дотор махыг боловсруулаагүй, ямар нэгэн түвшинд боловсруулсан хэлбэрээр ахуйд болон нийтийн хоол үйлдвэрлэлд нийлүүлж, бага хэмжээгээр экспортод гаргаж байна.


Хүснэгт 3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн зах зээлийн сегментчилэл ба хамрах хүрээ

Эх үүсвэрээр	Хэрэглээний ангиллаар	Түгээлтийн сувгуудаар
<ul style="list-style-type: none"> ❖ үхрийн ❖ адууны ❖ Хонины ❖ Ямааны 	<ul style="list-style-type: none"> ❖ Шинэ <ul style="list-style-type: none"> o Хүнсэнд o Амьтны хоол, тэжээлд o Бусад ❖ Боловсруулсан <ul style="list-style-type: none"> o Лаазалсан/Давсалж хадгалсан o Хөлдөөсөн o Хиам/Ууталж савласан o Бусад 	<ul style="list-style-type: none"> ❖ Нийтийн хоол ❖ Жижиглэн худалдаа ❖ Экспорт
Шинж байдал		Хамрах хугацааны нарийвчлал
Зах зээлийн тооцоололд ашигласан суурь он		2023
Түүхчилсэн шинжилгээ		2019, 2020, 2021, 2022 оны бодит тоо баримт
Прогноз		2024 оноос 2030 оныг хамарсан.

Хүснэгт 3-т хүнсний дотор мах, дайварын зах зээлийн сегментчиллийг харуулсан бөгөөд судалгаа, тооцоололд 2023 оны үзүүлэлтийг суурь болгосон ба 2019-2022 оны тоо, баримтад түүхэн шинжилгээ хийж, улмаар 2024-2030 оны төлөвийг гаргаж харуулахыг зорьсон.

2023 оны байдлаар дотор мах, дайвар түүхий эдийн нийт нөөцийн 50.8%-ийг хонины, 27.7%-ийг ямааны, 18.1%-ийг үхрийн, 3.3%-ийг адууны дотор мах, дайвар эзэлж байна. Нийт нөөцийн 11.3%-ийг 2023 онд үйлдвэрийн аргаар, 14.3%-ийг уламжлалт аргаар бэлтгэж зах зээлд нийлүүлсэн бол үлдэх 74.4%-ийг ямар нэг байдлаар ашиглаагүй/хаягдал болгожээ (график 1).

График 1. Хүнсний дотор мах, дайварын зах зээлийн нэг агшны зураглал – гол баримтууд



Зах зээлийн сектор: эх үүсвэрээр (2023)	Өлөн гэдсийг үйлдвэрт боловсруулан экспортод гаргаж байна. Бог малын өлөнгөөс бусад дотор махыг дотоодын зах зээлд уламжлалт аргаар боловсруулж хэрэглэдэг. Үхрийн элэг, гүзээ, зүрх, хэлийг үйлдвэрт боловсруулж төрөл бүрийн бүтээгдэхүүн хийхийн зэрэгцээ нийтийн хоолны газруудад хоол хийж үйлчилж байна. Зарим үйлдвэр дотор мах, дайвраар амьтны тэжээл үйлдвэрлэж байна. Нийт дотор мах, дайвар түүхий эдийн 70-80% боловсруулалтгүй хаягдаж байна.
Хонины дотор мах, дайвар: 50,8%	
Ямааны дотор мах, дайвар: 27.7%	
Үхрийн дотор мах, дайвар: 18.1%	
Адууны дотор мах, дайвар: 3.3%	

Хүнсэнд бэлтгэж байгаа малын 10 орчим хувийг мах боловсруулах үйлдвэр, цехэд үйлдвэрийн аргаар төхөөрч, дотор маханд тодорхой боловсруулалт хийн дотоод, гадаадын зах зах зээлд нийлүүлдэг, үлдэх 90 хувийг уламжлалт аргаар төхөөрдөг ба дотор махыг бүрэн ашиглаж чадахгүй хаягдал болгож байгаа тухай мэдээллийг Улаанбаатар хотын Эмээлт болон Налайх дүүрэг орчмын гар аргаар мал төхөөрдөг цехийн (төхөөрч байгаа малын 60%) ажилчид, аймаг, суманд хээрийн бой хийж байгаа ченжүүд, малчид (30 %) батлан хэлж байна.

Монгол Улсын хэмжээнд жил бүр дотор махны хэдий хэмжээний хүнсний болон экспортын нөөц хаягдал болж байгаа, түүний шалтгаан, дотор махны нийлүүлэлт, ашиглалт, хэрэглээ, борлуулалт зэрэг асуудал тодорхой бус байна. Иймд дотор махны боловсруулалт, ашиглалтыг төрөлжүүлэх, холбогдох талуудыг үнэн зөв мэдээллээр хангахын тулд дотор махны гарцыг малын төрөл тус бүрээр шинэчлэн тогтоох, улсын хэмжээгээр дотор махны гарцын нийт хэмжээг тооцож гаргах, зах зээлийн багтаамж, хэрэглээний болон нийт зах зээлийн чиг хандлага, дотоод, гадаад зах зээлд борлуулалтыг нэмэгдүүлэх стратеги, нийлүүлэлтийн болон түгээлтийн суваг, өртгийн гинжин хэлхээний динамик зэрэг олон талын нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна.

Түүнчлэн үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн дунд дотор махан бүтээгдэхүүний эрүүл мэндийн болон эдийн засгийн ач холбогдол, үнэ цэний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүний ашиглалтыг сайжруулах, дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дотоод, гадаадын зорилтот зах зээлд тохирсон үнээр гаргах боломжтой гэдгийг судлан, харуулах нотолгоо, баримт мэдээлэл хэрэгтэй байна.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ

Оновчтой үйлдвэрлэл ба зохистой хэрэглээ: Монгол Улс дотооддоо хоол хүнсэнд хэрэглэсэн болон экспортлох зорилгоор төхөөрсөн малын амьдын жингийн бараг гуравны нэг хувь нь дотор мах болон дайвар бүтээгдэхүүн байдгийг судалгаагаар тогтоосон байна. Манай улс бод, бог мал төхөөрөх, мах боловсруулах томоохон үйлдвэрлэлтэйн дээр уламжлалт аргаар мал төхөөрч хүнсэндээ хэрэглэдэг онцлогтой. Гэвч эдгээрээс гарах дотор мах, дайвар бүтээгдэхүүний тэжээллэг чанар, эдийн засгийн ач холбогдол, хэрэглээний уламжлалт аргын талаар мэдлэг хомстойгоос үүдэн тэдгээрийг боловсруулах, ашиглах, хэрэглэх боломж хязгаарлагдмал байгаагаас гадна зарим хэсэг нь ашиглалтгүй хаягдаж байна.

Ийм учраас холбогдох үйлдвэрлэгч, хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх, дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг үр ашигтай байдлаар боловсруулж, хоол, хүнсэнд хэрэглэх, биологийн идэвхт нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дотоод, гадаадын зорилтот болон нийтлэг зах зээлд нийлүүлэх, дотор

мах, дайврын боловсруулалтыг гүнзгийрүүлж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг дүүрэн хангах явдал тулгамдсан асуудал болсон байна.

2.1 Судалгааны зорилго

Монгол малын дотор мах, дайвар түүхий эдийн нөөц, ашиглалт, боловсруулалтын түвшин, хэрэглээг нэмэгдүүлэх боломжийг судалж, дотоод, гадаад зах зээлд тогтвортой байршуулах маркетингийн загвар боловсруулахад оршино.

2.2. Судалгааны зорилт

Монгол Улс дахь дотор мах, дайвар бүтээгдэхүүний нөөц (гарц)-ийг тогтоох, түүний төрөл зүйлийн боловсруулалт, борлуулалт, хэрэглээний зах зээлд дүн шинжилгээ хийх, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, дотоодын хэрэглээг нэмэгдүүлэх арга зам, зорилтот зах зээлд экспортлох, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг үнэлэхэд оршино.


Энэхүү судалгааны үр дүнг дотор махны өртгийн сүлжээг бэхжүүлэх оновчтой маркетингийн стратеги боловсруулах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний үнэ цэнийг хэрэглэгч, үйлдвэрлэгчдэд сурталчлахад ашиглана.

2.3. Судалгааны объект

Малын дотор мах, дайвар түүхий эдийн үйлдвэрлэл, боловсруулалт, ашиглалт, хэрэглээний хэлхээг бүрдүүлж байгаа үйлдвэрлэгч, нийлүүлэгч, мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа явуулдаг зах, сүлжээ дэлгүүр, супермаркет, мухлаг, нийтийн хоолны үйлчилгээ явуулж буй ресторан, гуанз, цайны газар, бүтээгдэхүүн хадгалах, түгээхэд оролцогч тээвэр, логистикийн үйлчилгээ эрхлэгч нар болон хэрэглэгчид байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллагууд байж болно.

2.4. Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг зах зээлийн судалгаа гүйцэтгэдэг нийтлэг арга зүйг баримтлан явуулна. Малын дотор мах, дайвар түүхий зах зээлийн судалгааны арга зүйг дүрслэл 1-д үзүүлэв.



Дүрслэл 1. Судалгааны аргачлал

2.4.1 Төхөөрч буй малын дотор эрхтэн, дайвар түүхий эдийн гарцыг тодорхойлох судалгаа

Малын дотор эрхтэн, дайвар түүхий эдийн гарцын судалгааг малын биеийн бүтэц, тогтолцооны дагуу ялган салгасан эд, эрхтэн тус бүрийг нэг бүрчлэн жигнэх замаар тодорхойлж, амьдын жинтэй харьцуулна. Энэ удаагийн нэг агшны хэмжилтийн үр дүнг өмнөх жилүүдэд хийгдсэн янз бүрийн судлаачдын судалгаа, хэмжилтийн үр дүнтэй, он дарааллын дагуу харьцуулан дүгнэнэ.

Үйлдвэрийн аргаар төхөөрөх бод, богийн дотор эрхтнийг дагалдах хальс, бүрхүүл, агуулагдахуун, салс, шингэнээс цэвэрлэсний дараа хэмжилт хийх ба дайвар бүтээгдэхүүн тус бүрийг тусад нь жигнэж

тодорхойлно. Энэхүү судалгаанд зэвэрдэггүй ган сав суулга, Стандарт хэмжилзүйн газрын баталгаажуулсан, граммын нарийвчлалтай жин хэмжүүр ашиглана. Хэмжилтийн алдаа хэвийн хэлбэлзэл дотор байна.

Улаанбаатар, Дархан, Орхон, Дорнод, Сүхбаатар аймаг дахь мал төхөөрөх үйлдвэрт төхөөрч буй малын (Үхэр, адуу, хонь, ямаа) дотор эрхтэн, дайвар түүхий эдийн гарцыг малын төрөл тус бүрээр тодорхойлох хэмжилтийг тусгайлан боловсруулсан арга зүйн дагуу явуулна.

Дээрх аймгаас бусад аймаг, сумдад байгаа 48 үйлдвэр, цех дээр уламжлалт аргаар төхөөрсөн малын (Үхэр, адуу, хонь, ямаа) дотор эрхтэн, дайвар түүхий эдийн гарцыг малын төрөл тус бүрээр тодорхойлох хэмжилтийг тусгайлан боловсруулсан арга зүйн дагуу явуулна.

2.4.2 Дотор мах, дайвар түүхий эдийн дотоод зах зээлийн судалгаа

Дотоод зах зээлийн судалгааг бог малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ, нийлүүлэлт дээр голлож, тооны болон чанарын аргыг хослуулан явуулна. Үүнд:

- Дотор махны үйлдвэрлэл, дотоод зах зээлийн нийлүүлэлтийн хэмжээ (нэр төрлөөр), боловсруулалт болон ашиглалтын хэлбэр, хэтийн төлөв ба
- Дотор махны зах зээлийн багтаамж, түүний өөрчлөлт, хэрэглэгчдийн сонголт, зах зээлийн сегментчилэл, ирээдүйн чиг хандлагыг олгогдсон нөөцийн хэмжээнд судална.
- Дотор махны боловсруулалт, хэрэглээг сайжруулахад нөлөөлж буй хүчин зүйлс, боломжуудыг олгогдсон нөөцийн хэмжээнд тодорхойлох оролдлого хийнэ.

Энэ хэсэгт дурдсан судалгааг явуулах, хэрэглээний чиг хандлага, төлөв байдлыг тодорхойлохын тулд өмнөх судлаачдын хийсэн судалгаа, статистик мэдээлэл, бусад мэдээллийн эх сурвалж болон үйлдвэрлэгч, худалдан авагч, боловсруулагч, эцсийн хэрэглэгчээс авсан асуумж судалгаанд дүн шинжилгээ хийх замаар энэхүү судалгааг явуулахаас өмнөх үеийн суурь шугамыг тодорхойлох ажлыг гүйцэтгэнэ.

2.4.3 Зорилтот гадаад зах зээл-Хятад, Өмнөд Солонгос, Ойрх дорнодын орнуудын дотор махны зах зээлийн судалгаа

Монгол Улсын экспортын мэдээ, Өмнөд Солонгос, Хятад, Ойрх дорнодын орнуудын дотор махны хэрэглээний зан үйл, эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн байдлыг хоёрдогч мэдээллийн олон янзын эх үүсвэр ашиглан чанарын судалгааны аргаар тоймлон гаргана. Энэ хүрээнд:


- Зорилтот зах зээлийн орнуудын дотор махны үйлдвэрлэл, ашиглалт/боловсруулалтын нэр төрөл, тоо хэмжээ,
- Зорилтот зах зээлийн орнуудад дотор махан бүтээгдэхүүн нийлүүлэгч гол экспортлогчид болон тэдгээрийн үйлдвэрлэл, борлуулалт, ирээдүйн төлөв байдал,
- Зорилтот зах зээлийн орнуудын зах зээл дээрх дотор маханд суурилсан гол бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийн тоо хэмжээ,
- Зорилтот зах зээлийн орнуудын дотор махны экспорт, импортын хэмжээ, үнийг судалж, мөн
- Монгол малын дотор махны өрсөлдөх чадварыг үнэлж, зорилтот зах зээлд экспортлох боломжийг олгогдсон нөөцийн хэмжээнд судална.
- Монгол малын дотор махыг зорилтот зах зээлд нэвтрүүлэх маркетингийн арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулна.

2.4.4. Дотор маханд суурилсан биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүний судалгаа

- Зорилтот зах зээлийн орнуудын хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэр төрөл, хэрэглээний талаар мэдээллийн дүн шинжилгээнд тулгуурласан судалгаа явуулна.
- Дотоодын зах зээл дээрх хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглээний талаар Улаанбаатар хотын хэмжээнд судалгаа хийнэ.
- Импортын хүнсний нэмэлт бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглээний байдлыг Гаалийн статистик болон худалдааны сүлжээнд түүвэрлэн судална.
- Дотор маханд суурилсан биологийн идэвхт - хүнсний нэмэлт бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн талаар судална.

Дээр дурдсан 4 чиглэлийн судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх байдлаар индукц, дедукцийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалыг ашиглан дотор махны гадаад, дотоод зах зээлийн хэмжээ, гол хөдөлгөгч хүчин зүйлс, худалдан авагч, эцсийн хэрэглэгчийн хандлага, зах зээл дээрх гол тоглогчийг тодорхойлох оролдлого хийнэ.

Судалгааны үр дүнг нэгтгэн 4P, SWOT, PESTLE аргаар дүн шинжилгээ хийж, дэлгэрэнгүй тайлан гаргах бөгөөд тайланд судалгааны нэгдсэн мэдээлэл, олж мэдсэн, шинээр тодорхойлсон, тогтоосон зүйлүүд болон тэдгээрт хийсэн дүн шинжилгээ, хийсэн дүгнэлт, өгөх зөвлөмжийг энгийн бичлэг, зураг, схем, хүснэгтээр нэгтгэн ойлгомжтой байдлаар тусгана.




Дүрслэл Дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны хүрээ

**БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ,
ТААМАГЛАЛ: ЭХ ҮҮСВЭРЭЭР**

Судалгааны багийн тооцоогоор манай улс сүүлийн таван жилд 220 – 320 мян тн буюу жилд дунджаар 270 мян тн дотор мах үйлдвэрлэжээ (хүснэгт 2-ыг үзнэ үү). Үүнээс 80 орчим хувь нь богийн (хониных >45-50%, ямааных >30%), 18% нь үхрийнх, үлдэх бага хэсэг нь адууны дотор мах байна.

2019-2023 оны статистик мэдээллийг суурь болгож 2030 он хүртэлх хугацаанд бэлтгэх дотор махны боломжит нөөцийн харьцааг тооцоход үхрийн дотор махны хэмжээ 20% орчим нэмэгдэх, адууных 60%, богийнх 6.5% орчим буурах төсөөлөлтэй байна. Богийн дотор махны нийлүүлэлтийн хэмжээ буурах хандлагатай ч нийт нөөцөд давамгайлсан (75%) хэвээр байх юм (график 2).

3.1. Монгол Улсын дотор мах, дайвар түүхий эдийн нөөц




Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

График 2. Дөрвөн төрлийн малын дотор мах, дайвар түүхий эд тус бүрийн зах зээлд эзлэх хувь хэмжээ, %-иар /2023-2030 он/

График 2-т харуулсан тоон үзүүлэлт нь 2019-2023 оны статистик мэдээллийг суурь болгож судалгааны багийн өөрсдийн гаргасан таамаглал тооцоо болно.

3.1.1. Үхрийн дотор мах, дайвар түүхий эд




Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

График 3. Монгол үхрийн хүнсний дотор мах, дайврын зах зээлийн 2019-2023 оны байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ:мян. Ам. Доллар)

2024-2030 он хүртэлх хугацаанд зах зээлд хүнсний зориулалтаар нийлүүлэгдэх үхрийн тоо 2019-2023 оны дунджаас 12.4 хувиар өсөх төлөвтэй байна. Үүнийг дагалдаад зах зээлд нийлүүлэгдэх үхрийн дотор мах, дайврын хэмжээ, борлуулалтын орлого ерөнхийдөө өссөн дүнтэй байгааг график 3-т харуулж байна.

3.1.2. Адууны дотор мах, дайвар




Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

График 4. Монгол адууны хүнсний дотор мах, дайврын 2019-2023 он хүртэлх зах зээлийн байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ: мян. Ам. Доллар)

2024-2030 он хүртэлх хугацаанд зах зээлд хүнсний зориулалтаар нийлүүлэгдэх адууны тоо 2019-2023 оны дунджаас 62.9 хувиар буурах төлөвтэй байна. Үүнийг дагалдаад зах зээлд нийлүүлэгдэх адууны дотор мах, дайврын хэмжээ, үнийн дүн ерөнхийдөө буурч байгааг график 4-т харуулсан.

3.1.3. Хонины дотор мах, дайвар түүхий эд




Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

График 5. Монгол хонины хүнсний дотор мах, дайврын 2019-2023 он хүртэлх зах зээлийн байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ:мян. Ам. Доллар)

2024-2030 он хүртэлх хугацаанд зах зээлд хүнсний зориулалтаар нийлүүлэгдэх хонины тоо 2019-2023 оны дунджаас 16.4 хувиар буурах төлөвтэй байна. Үүнийг дагалдаад зах зээлд нийлүүлэгдэх хонины дотор мах, дайврын хэмжээ, үнийн дүн ерөнхийдөө буурч байгааг график 5-д харуулж байна.

3.1.4. Ямааны дотор мах, дайвар



Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

График 6. Монгол ямааны хүнсний дотор мах, дайврын 2019-2023 оны зах зээлийн байдал, 2030 он хүртэлх өөрчлөлтийн таамаглал, (бүтээгдэхүүний биет жин: тонноор, үнэ:мян. Ам. Доллар)

2024-2030 он хүртэлх хугацаанд зах зээлд хүнсний зориулалтаар нийлүүлэгдэх ямааны тоо 2019-2023 оны дунджаас 14.2 хувиар буурах төлөвтэй байна. Үүнийг дагалдаад зах зээлд нийлүүлэгдэх ямааны дотор мах, дайврын хэмжээ, үнийн дүн ерөнхийдөө буурч байгааг график 5-д харуулж байна.

График 3, 4, 5, 6-д харуулсан тоон үзүүлэлт нь 2019-2023 оны статистик мэдээллийг суурь болгож 2024-2030 он хүртэл хугацаанд зах зээлд нийлүүлэгдэх 4 төрлийн малын дотор мах, дайврын тоо хэмжээ, үнийн дүнгийн өөрчлөлтийг судалгааны багаас гаргасан таамаг тооцоо болно. Ингэхдээ нэгж бүтээгдэхүүний үнийг 2023 оны үнээр тооцсон, малын тооны өсөлт, бууралтыг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар 2020 онд баталсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги”-г үндэслэж тооцсон болно.

3.2. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн зах зээлийн өөрчлөлт

2023 онд нийт үйлдвэрлэсэн 260 орчим тн дотор мах, дайвар түүхий эдийн 12 хувь (29 мянган т)-ийг үйлдвэрт төхөөрсөн малаас, 15 хувь (37 мянган т)-ийг уламжлалт аргаар бэлтгэсэн бол үлдэх 70 гаруй хувийг бүрдүүлэх 180 мянга гаруй тн дотор махыг хэрхсэн нь тодорхойгүй байна. Нийт малын тоог цөөрүүлэхэд чиглэсэн салбарын яамны бодлоготой уялдан 2030 он хүртэлх хугацаанд хүнсэнд бэлтгэх малын тоо тодорхой хэмжээгээр буурна хэмээн таамаглаж байна. Гэхдээ 2030 он хүртэл МБҮ-т төхөөрөх малын тоог нэмэгдүүлэх зорилт хэрэгжсэнээр тухайн хугацаанд нийлүүлэгдэх дотор махны (211 мянган тн) 60 хүртэл хувийг (140 орчим мянган тн) үйлдвэрийн аргаар бэлтгэж боловсруулах боломж бүрдэнэ хэмээн төсөөлсөн (график 7). Үйлдвэрийн аргаар төхөөрсөн малын дотор мах, дайвар түүхий эдэд технологийн шаардлагын дагуу анхан шатны боловсруулалт хийдэг тул дотоод, гадаад зах зээлд борлуулах боломжтой болно гэж үзэж байна.




График 7. Монгол улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийн өөрчлөлт, хэрэглээний ангиллаар

3.3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн өртгийн сүлжээний шинжилгээ

Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн өртгийн сүлжээ хангалтгүй судлагдсан, энэ талаарх тоо баримт, мэдээлэл туйлын хомс байна. Үйлдвэрт төхөөрч байгаа малын дотор мах, дайвар түүхий эдэд боловсруулах үйлдвэрлэлийн шатнаас эхлэн өртөг шингэдэг. Мал төхөөрөх үйлдвэрийн тухайд малыг амьдын жингээр нь үнэлж авч байгаа ба амьдын жингийн 30 орчим хувийг гэдэс дотор, түүний агуулагдахуун эзэлдэг. Иймд хэрэв үйлдвэр дотор мах, дайвар түүхий эдийг боловсруулж ашиглалгүй, хаягдал болгосон тохиолдолд гэдэс дотрын үнэ нь махны өртөгт шингэх болно. Ченжүүд малын дотор мах, дайврыг ихэнхдээ авалгүй хаядгаас гэдэс дотрын эзлэх хувь бөөний худалдааны цэгт махны үнэд шингэн борлуулагдаж байна.

Малын дотор мах, дайврын өртгийн сүлжээний ерөнхий схемийг доорх байдлаар төсөөлж болох хэдий ч сүлжээний аль хэсэгт, ямар хэмжээгээр өртөг шингээгдэж байгааг тооцож гаргах боломж одоогоор байхгүй байна (дүрслэл 3). Иймд малын дотор мах, дайвар түүхий эдийн нийлүүлэлт - өртгийн сүлжээний бүрэн зураглал гаргаж, аль шатанд мах, махан бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх ямар хүчин зүйлс үйлчилж, ямар өртөг шингэж байгааг тодорхойлон, зохицуулах зохистой арга хэмжээг төлөвлөхөд чиглэгдсэн өргөн хүрээний судалгаа хийх шаардлагатай байна.


Монгол Улсын Хүнсний дотор мах, дайврын өртгийн сүлжээний ерөнхий схем



Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан зураглал

Дүрслэл 3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын өртгийн сүлжээний ерөнхий бүтэц














Тайлбар:



3.4. Дотор мах, дайвар түүхий эдийн зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйлийн шинжилгээ

Хүнсний дотор мах, дайвар түүхий эдийг махан бүтээгдэхүүний жор, найрлагад нэмж ашиглах нь боловсруулалт, ашиглалтын зохистой шийдлийн нэг болно. Иймд хүнсний үйлдвэрүүд ийм чиглэлийн технологи хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Түүнээс гадна дотор мах, дайврын шим тэжээллэг чанар, хямд үнэ зэрэг нь хэрэглээний соёл төлөвшсөн зах зээлд түүний борлуулалтад эерэг нөлөөлөх үзүүлэлт юм. Манай дотоодын зах зээлийн тухайд дотор мах, дайврын гарал үүсэл тодорхойгүй байх, өнгө үзэмж доогуур, шинэлэг байдалд хэрэглэгчийн итгэл муу байдгаас зах зээл дээрх борлуулалт, түгээлтийг сааруулдаг байна.

Хүснэгт 4. Зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйлийн үнэлгээ

Зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйл	2019-2023	2024-2026	2027-2030
	Үзүүлж буй нөлөөллийн зэрэг		
Хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн интеграци			
Хүнс тэжээлийн үнэт чанар ба үнэ			
Бүтээгдэхүүний гарал үүслийг мөшгөх тогтолцоо, цэвэр, аюулгүй байдлын хяналт, баталгаажуулалт, гадаад үзэмж			
Үнэлгээний ялгагдах байдал			
			
Маш өндөр	Өндөр	Дунд зэрэг	Сул

Эх сурвалж: Судалгааны багаас өгсөн үнэлгээ


Хүснэгт 4-д харуулснаар хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн зах зээлд нэвтрэлтийг өргөжүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд бусад махан бүтээгдэхүүний орц найрлагад дотор мах, дайврыг оруулсан шинэ нэрийн бүтээгдэхүүн бий болгох, уламжлалт бүтээгдэхүүний амт, чанар, үнэр, өнгийг сайжруулахад хүнсний баяжуулагч байдлаар дотор мах, дайврыг ашиглах зэргээр дэлхий нийтийн шинэ чиг хандлагад нийцүүлэн “тураг мах”-тай хослуулах нь чухал байгаа бөгөөд бид энэ чиг хандлагыг 2030 он гэхэд үйлдвэрлэлд нэвтрүүлж чадвал Монгол Улсын дотор мах, дайврын зах зээлийг өргөжүүлэх нэг гол нөхцөл болох юм.

Дотор мах, дайврын зах зээлийг өргөжүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх хоёрдогч гол хүчин зүйл нь дотор мах, дайвар түүхий эдийн чанар ба үнэ өртөг байх болно. Энэ нь дотор махны зах зээлийн гол хөдөлгөгч хүч өмнө нь ч байсан, цаашид ч нөлөөгөө хэвээр хадгалах болно гэж үзэж байна.

Гуравдагч гол хүчин зүйл нь дотор мах, дайврын гарал үүсэл, бэлтгэж байгаа арга технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал юм. Энэ хүчин зүйлийн нөлөөллийг эерэг байдалд хөрвүүлэхийн тулд юуны өмнө хүнсэнд төхөөрч байгаа малын 70-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар төхөөрдөг болох явдал юм. Монгол Улсын Засгийн газраас баталсан Махны үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг түүштай хэрэгжүүлж, 2027-2030 онд хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 70-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэдэг болсон нөхцөлд зах зээлийн хөдөлгөгч хүчин зүйлийн нөлөөлөл нэмэгдэж дотор мах, дайврын зах зээлийн нэвтрэлт эрс сайжрах боломжтой.

График 8-д ямар төрлийн дотор мах, дайвар дотоодын зах зээлд хэдий хир хэмжээтэй борлуулагдаж байгааг биет жингээр харуулж байна. Бидний гаргасан судалгаагаар хамгийн их борлуулагдаж байгаа нь толгой, гүзээ, элэг, уушги, хонины сүүл байна.

Зах зээлд илүү нэвтэрсэн дотор мах, дайвар түүхий эдийн нөөцийн хэмжээ




Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

График 8. Зах зээлд борлогдож байгаа зарим нэрийн дотор мах, дайварын нөөцийн хэмжээ

Өнөөгийн байдлаар богийн өлөн гэдэс, бод, богийн элэг, зүрх, бөөр, гүзээ, сархинаг зах зээлд борлуулалт сайтай байгаа бол хонины сүүл, умс, хятай, уушги дунд зэргийн борлуулалттай, толгой, шийр, дотор өөх, жонго борлуулалт муутай байна. Цаашдаа бод, богийн өлөн гэдэс, элэг, гүзээ, хонины сүүл, толгой, шийрийн борлуулалтын хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа бол умс, хятай, уушги, бөөр, зүрх, дотор өөх, жонгоны борлуулалт өсөлт муутай байхаар байна (График 9).

3.5. Хүнсний голлох дотор мах, дайварын зах зээлийн нэвтрэлт ба өсөлтийн төлөв



Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан зураглал

График 9. Хүнсний дотор мах, дайврын шинэ зах зээлд нэвтрэх боломж ба өсөлтийн хэтийн төлөвийн зураглал

Зах зээлд илүү нэвтрэлт сайтай дотор мах, дайвар түүхий эд




График 10. Дотор мах, дайвар зарж борлуулж байгаа захын тоо (дотор мах, дайврын нэр төрлөөр)

График 10-т Улаанбаатар хотын хүнсний захуудад аль төрлийн дотор мах, дайвар өргөн нэвтрэлттэй буюу хэдэн захад зарагдаж байгааг харуулж байна. Бидний газар дээрээс нь хийсэн судалгаагаар зүрх 12, элэг, гүзээ, умс, хитай тус бүр 11, уушиг, бөөр тус бүр 10, хонины сүүл 8 зах дээр зарагдаж байна.

БҮЛЭГ 4. МАЛЫН ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ГАРЦ, НӨӨЦ

Монгол Улсын таван хошуу малын махан ашиг шимийг судлах ажлыг оросын эрдэмтэд 1930-аад оноос эхэлсэн бөгөөд 1950-иад оны сүүлчээс манай үндэсний эрдэмтэд өргөн хүрээтэй судалж эхэлжээ. Манай эрдэмтэд монгол малын махан ашиг шим, гарц, химийн найрлагыг судлахад түлхүү анхаарч ихээхэн ажил гүйцэтгэжээ. Харин дотор мах, дайвар түүхий эдийн гарц, нөөцийг судлах ажил сүүлийн жилүүдэд огт хийгдээгүй байна.

Экспортод зориулан үйлдвэрийн аргаар боловсруулсан дотор мах, дайвар түүхий эдийн гарц тогтоох ажлыг Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа Махимпекс, Махмаркет, Перком, Агронэгтгэл, Монгол мах-экспо, Цалуут импекс, Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Сүхбаатар махмаркет, Хийморь Сүхбаатар мах импекс, Баянтал компаний мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр, Дорнод аймгийн Вайтгрупп, Чойбалсан групп, Махмаркет зэрэг үйлдвэрт гүйцэтгэв.

4.1. Дотор мах, дайвар түүхий эдийн гарц тодорхойлох

4.1.1. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн дотор мах, дайвар түүхий эдийн гарц тогтоох

Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн дайвар бүтээгдэхүүний гарц тогтоох хэмжилтийг нийт 1560 дээжинд гүйцэтгэлээ. Дээж авах, хэмжилт хийх гэрээт ажлын арга зүйг батлуулах болон бусад зохион байгуулалтын ажлаас шалтгаалж мал төхөөрөх оргил хугацаанаас нэлээд оройтож эхэлсэн. Гарцыг малын төрлөөр шүүд жигнэсэн дунджаар болон гүлүүзны жинд харьцуулсан хувиар тооцож гаргав. Хэмжилтийн үр дүнг доорх хүснэгтүүдэд харуулж байна (хүснэгт 5, 6, 7, 8).

Хүснэгт 5. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн адууны дотор мах, дайвар түүхий эдийн үнэмлэхүй жин болон харьцангуй дундаж гарц

Гулуузны жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, үнэмлэхүй жин, граммаар												
	Зүрх	Толь	Уушиг	Цагаан мөгөөрс	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Шөрмөс	Толгой	Улаан хоолой	Нарийн гэдэс	Умс, китай
145.4	1277.5	392.3	1550	287.5	775	3088	1375	514.4	200	11137.5	200	3056.3	3425
Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн адууны дайвар бүтээгдэхүүний гарцын дундажыг гулуузны жинд харьцуулсан хэмжээ /хувиар/													
	0.88	0.27	1.07	0.2	0.53	2.12	0.95	0.35	0.14	7.66	0.14	2.1	2.36

Үйлдвэрт төхөөрсөн адууны гулуузын жин дунджаар 145.4 кг бөгөөд гулууз махны жингийн 18.7 %-тай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд (цусыг оролцуулалгүй) гардаг байна (хүснэгт 5). Төхөөрсөн малаас гарах цусны хэмжээ гулуузын жингийн 5 орчим хувийг бүрдүүлдэг. Түүнчлэн шийрний жинг энэ судалгаагаар тодорхойлоогүй. Эдгээр түүхий эдийн хэмжээг нэмбэл адууны гулуузын жингийн 4/1 илүү нь дотор мах, дайвар түүхий эд байна.

Хүснэгт 6. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн үхрийн дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузны жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, үнэмлэхүй жин, граммаар																		
	Зүрх	Тольт	Уушиг	Цагаан мөгөөрс	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Шөрмөс	Толгой	Цөс	Улаан хоолой	Хар гэдэс	Олгой	Ходоод	Салбан сархинаг	Цоохор сархинаг	Гүзээ	Годон
153.4	1250	604.2	2066.5	126.4	799.6	4432.2	1521.1	607.6	552.4	9694.5	264	217.5	2100.8	770.5	2102	2683.5	1240.8	8709.5	341.5
Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн үхрийн дайвар бүтээгдэхүүний гарцын дундажийг гулуузны жинд харьцуулсан хэмжээ /хувиар/																			
	0.81	0.39	1.35	0.08	0.52	2.89	0.99	0.4	0.36	6.32	0.2	0.14	1.37	0.5	1.37	1.75	0.81	5.68	0.22

Үйлдвэрийн аргаар төхөөрсөн 153,4 кг гулуузын гарцтай үхрийн дотор мах, дайвар бүтээгдэхүүний гарц гулуузны жингийн 26,15% байна (хүснэгт 6). Үүн дээр цус, шийрний жинг нэмж тооцвол энэ нь 30% хүрнэ.

Хүснэгт 7. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ямааны дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузын жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, үнэмлэхүй жин, граммаар														
	Зүрх	Тольг	Уушиг	Цагаан мөгөөрс	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Толгой	Улаан хоолой	Сэмж	Бөөрний өөх	Ходоод	Гүзээ	Өлөн гэдэс
15.3	102	77.7	284.2	42.2	125.8	459.2	129.2	108.4	1577.9	42	741.8	129.6	176.8	560.5	446.4
	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ямааны дайвар бүтээгдэхүүний гарцын дунджийг гулуузын жинд харьцуулсан хэмжээ /хувиар/														
	0.66	0.5	1.85	0.27	0.82	3	0.84	0.7	10	0.27	4.84	0.84	1.15	3.66	2.91

Үйлдвэрийн аргаар төхөөрсөн 15,3 кг гулуузын гарцтай ямааны дайвар бүтээгдэхүүний гарцыг гулуузын жинд харьцуулахад 32,31% байна. Бодит хэмжилтээр тогтоосон энэ үзүүлэлт дээр цус, шийрний гарцыг нэмбэл (хүснэгт 7) ямааны дотор мах, дайвар түүхий эдийн гарц гулуузын жингийн 40 орчим хувьд хүрэхээр байна.

Хүснэгт 8. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хонины дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузын жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, үнэмлэхүй жин граммаар																		
	Зүрх	Тольг	Уушиг	Цагаан мөгөөрс	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Годон	Толгой	Сүүл	Улаан хоолой	Сэмж	Бөөрний өөх	Ходоод	Хос	Шулуун гэдэс	Гүзээ	Чацархай
20.5	129	71	286	52	99	513	141	99	338	1853	973	211	477	135	239	130	189	669	443
	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хонины дайвар бүтээгдэхүүний гарцын дунджийг гулуузын жинд харьцуулсан хэмжээ /хувиар/																		
	0.63	0.35	1.4	0.25	0.48	2.5	0.7	0.48	1.65	9.04	4.75	1.03	2.33	0.66	1.17	0.63	0.9	3.26	2.16

Үйлдвэрийн аргаар төхөөрсөн 20,5 кг гулуузын гарцтай хонины дотор мах, дайвар бүтээгдэхүүний гарцыг гулуузын жинд харьцуулахад ь 34,37% бөгөөд үүн дээр цус, шийрний жинг нэмэхэд энэ үзүүлэлт 40 орчим %-д хүрэхээр байна.

4.1.2. Уламжлалт аргаар төхөөрсөн малын дотор мах, дайвар түүхий эдийн гарц

Уг ажлыг Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Нийслэл хотын 48 уламжлалт аргаар мал төхөөрөх газарт гүйцэтгэв.

Уламжлалт аргаар төхөөрсөн малын дотор мах, дайвар түүхий эдийн гарцыг тодорхойлох хэмжилтийг малын төрлөөр тус бүр 20 дээж, нийт 3840 дээжид гүйцэтгэлээ. Гарцыг малын төрлөөр, шууд жигнэсэн дунджаар болон гулуузын жинд харьцуулсан хувиар тооцож гарган, хүснэгтээр харууллаа (хүснэгт 9, 10, 11, 12).

Хүснэгт 9. Уламжлалт аргаар бэлтгэсэн адууны дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузны жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, гарцын жин /граммаар/								
	Зүрх	Уушиг	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Толгой	Нарийн гэдэс	Умс, китай
163.96	845	2040	1098	3446	1657	710	13990	2068	2029
	Уламжлалт аргаар бэлтгэсэн адууны дайвар бүтээгдэхүүний гарцын дунджийг гулуузны жинд харьцуулсан хэмжээ /хувиар/								
	0.52	1.24	0.67	2.1	1.01	0.43	8.53	1.26	1.24

Уламжлалт аргаар бэлтгэсэн 163,96 кг гулуузын гарцтай адууны дайвар бүтээгдэхүүний гарц гулуузын жингийн 0,43-8,53 хувийг эзлэх бөгөөд нийт 17%-тай тэнцэж байна (хүснэгт 9).

Хүснэгт 10. Уламжлалт аргаар бэлтгэсэн үхрийн дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузны жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, гарцын жин /граммаар/														
	Зүрх	Уушиг	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Толгой	Хар гэдэс	Олгой	Ходоод	Салбан	Цоохор	Гүзээ	Дотор өөх	Годон
113.9	1070	2319	568	2957	2016	826	10192	2141	559	1021	1199.5	1173	5285	1743	302
	Уламжлалт аргаар бэлтгэсэн үхрийн дайвар бүтээгдэхүүний гарцын дунджийг гулуузны жинд харьцуулсан хэмжээ /хувиар/														
	0.94	2.04	0.5	2.6	1.77	0.73	8.95	1.88	0.49	0.9	1.05	1.03	4.64	1.53	0.27

Уламжлалт аргаар бэлтгэсэн 113,9 кг гулуузын гарцтай үхрийн дотор мах, дайвар түүхий эдийн гарцыг гулуузын жинд харьцуулахад 29,32% байна.

Хүснэгт 11. Уламжлалт аргаар бэлтгэсэн ямааны дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузны жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, гарцын жин /граммаар/											
	Зүрх	Уушиг	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Толгой	Дотор өөх	Сэмж	Ходоод	Гүзээ	Өлөн гэдэс
13.57	100	508	101	804.5	206.1	196.8	1821	930	511	487	939	494
	Уламжлалт аргаар бэлтгэсэн ямааны дайвар бүтээгдэхүүний гарцын дунджийг гулуузны жинд харьцуулсан хэмжээ /хувиар/											
	0.74	3.74	0.74	5.93	1.52	1.45	13.4	6.85	3.77	3.59	6.92	3.64

Уламжлалт аргаар бэлтгэсэн 13,57 кг гулуузын гарцтай ямааны дайвар бүтээгдэхүүний гарцыг гулуузын жинд харьцуулахад 52,29% байна.

Хүснэгт 12. Уламжлалт аргаар бэлтгэсэн хонины дайвар бүтээгдэхүүний гарцын үнэмлэхүй болон харьцангуй дундаж хэмжээ

Гулуузны жин /кг-р/	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл, гарцын жин /граммаар/													
	Зүрх	Уушиг	Бөөр	Элэг	Өрц	Хэл	Годон	Толгой	Сүүл	Дотор өөх	Ходоод	Хос	Шулуун гэдэс	Гүзээ
13.3	146	410	148	490	240	100	250	2470	1300	860	320	148	450	850
	Уламжлалт аргаар бэлтгэсэн хонины дайвар бүтээгдэхүүний гарцын дунджийг гулуузны жинд харьцуулсан хэмжээ /хувиар/													
	1.1	3.08	1.11	3.68	1.8	0.8	1.88	18.6	9.77	6.47	2.41	1.11	3.38	6.39

Уламжлалт аргаар бэлтгэсэн 13,3 кг гулуузын гарцтай хонины дайвар бүтээгдэхүүний гарцыг гулуузны жинд харьцуулахад 61,58% байна.

Хүснэгт 13. Үйлдвэрт болон уламжлалт аргаар орон нутагт төхөөрсөн малын гулуузны жин, кг-аар

Төхөөрөлтийн ялгаа	Малын төрөл ба гулуузны дундаж жин, кг			
	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Үйлдвэрт	145.4	153.4	20.5	15.3
Уламжлалт аргаар	163.96	113.9	13.3	13.57
Дундаж амьдын жин	200	250	40	35

2023 оны намар үйлдвэрт төхөөрсөн малын тарга хүчний байдлыг гулуузны дундаж жингээр баримжаалахад аль ч төрөл дээр дундаас дээш тарга хүчтэй байгаа боловч орон нутагт уламжлалт аргаар төхөөрсөн малын тарга хүч адуунаас бусад малынхад дунд, дундаас доош байлаа. Эндээс онд орж чадахааргүй малыг малчид түлхүү төхөөрсөн байдал ажиглагдаж байна. Энэ нь 2023 оны 11 сараас хойших цаг агаарын байдал болон өвөл хүндхэн болох дохиолол эрт мэдэгдсэнтэй холбоотой байж болох юм.

Малын гулуузны жин буурахын хирээр дотор махны гулуузтай харьцуулсан жин ихсэж байгааг дээрх хүснэгтүүдээс харж болно. Мөн үйлдвэрт төхөөрсөн адууны 13, үхрийн 19, ямааны 15, хонины 19 нэрийн; харин уламжлалт аргаар төхөөрсөн адууны 9, үхрийн 15, ямааны 12, хонины 14 дотор мах, дайвар түүхий эдийн гарц тодорхойлох хэмжилт хийлээ. Гэтэл уламжлалт аргаар төхөөрсөн малын дотор махны жин үйлдвэрт төхөөрсөн малынхаас өндөр байгаа нь малын тарга хүчнээс гадна хэмжилт хийсэн арга болон эрхтэн тус бүрийг бусад дагалдах зүйлсээс бүрэн салгаж цэвэрлээгүйтэй холбоотой байж болно.

4.2. Монгол Улсын дотор мах, дайвар түүхий эдийн нөөц

Төслийн хүрээнд гүйцэтгэсэн дотор махны гарц тодорхойлох хэмжилтийн дүнг өмнө нь бусад судлаачдын хийсэн адил үр дүнгүүдтэй нэгтгэж, дундажлах байдлаар төхөөрсөн мал тутмаас гарах түүхий эдийн гарцыг “Хүнсний зориулалттай дотор мах, дайвар түүхий эд болон тэдгээрийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MNS 1023:2007” стандартын ангиллын дагуу нэр төрлөөр нь тооцож, хүснэгт 14, 15, 16, 17-д харуулав.

Хүснэгт 14. Адууны дотор мах, дайвар түүхий эдийн гарц, кг-аар

Ангилал	Дотор мах, дайвар түүхий эдийн нэр төрөл	Адууны дотор мах, дайврын гарц	
		Нэгжийн гарц, кг	Хүнсэнд хэрэглэж байгаа дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ
1 дүгээр ангиллын дотор мах	Элэг, кг	4.10	4.1
	Хэл, кг	0.17	0.17
	Бөөр, кг	0.40	0.4
	Зүрх, кг	0.64	0.64
	Цөвдөл мах, кг	0.00	0
	Өрц, кг	1.37	1.37
	Годон сүүл, кг	0.34	0.34
	Хэсгийн дүн	7.03	7.02
2 дугаар ангиллын дотор мах	Уушги, кг	1.97	0.00
	Ястай толгой, кг	3.70	0.00
	Шийр, кг	6.27	0.00
	Нойр булчирхай, кг	0.00	0.00
	Ходоод, кг	0.00	0.00
	Улаан хоолой, кг	0.10	0.00
	Цагаан мөгөөрс, кг	0.28	0.00
	Багалзуур, кг	0.56	0.00
	Умс, зг	1.14	1.14
	Дэлүү, кг	0.64	0.00
	Хятай, кг	1.14	1.14
	Хар гэдэс, кг	1.02	1.02
	Чих, кг	0.00	0.00
	Уруул, кг	0.00	0.00
	Шөрмөс, кг	0.08	0.00
Бүлх, кг	0.00	0.00	
	Хэсгийн дүн	16.89	3.30
Техникийн түүхий эд	Өөх, кг	5.43	5.43
	Сэлдээ кг	0.00	0
	Төмсөг, кг	3.20	0
	Туурай, кг	0.00	0
	Нүд, кг	0.00	0
	Цус, кг	14.15	0
	Хэсгийн дүн	22.78	5.43
Нийт дүн		68.50	15.75

Нас гүйцсэн нэг толгой адуунаас 70 орчим кг буюу амьдын жингийн 35, гулуузын жингийн 45 орчим хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гардаг. Үүнээс 20 орчим хувийг нь хүнсний зориулалтаар ашиглах боломжтой. Хэрэв цусыг авч хүнсний зориулалтаар ашиглабал дээрх үзүүлэлт 3 – 5 хувиар өснө.

Хүснэгт 15. Үхрийн дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ, кг-аар

Ангилал	Дотор мах, дайвар түүхий эдийн нэр төрөл	Үхрийн дотор мах, дайврын гарцын тооцоо	
		Нэгжийн нийт гарц, кг	Хүнсэнд хэрэглэж байгаа дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ
1 дүгээр ангиллын дотор мах	Элэг, кг	4.09	4.09
	Хэл, кг	0.75	0.75
	Бөөр, кг	0.79	0.79
	Зүрх, кг	1.16	1.16
	Цөвдөл мах, кг	0.9	0.9
	Өрц, кг	1.27	1.27
	Годон сүүл, кг	0.44	0.44
	Дэлэн, кг	2.8	0
	Тархи, кг	0.00	0
	I-ийн дүн	12.20	9.40
2 дугаар ангиллын дотор мах	Уушги, кг	1.94	1.94
	Ястай толгой, кг	10.67	10.67
	Шийр, кг	5.48	5.48
	Нойр булчирхай, кг	0.22	0.00
	Гүзээ, кг	5.86	5.86
	Ходоод, кг	1.52	1.52
	Улаан хоолой, кг	0.23	0.00
	Цагаан мөгөөрс, кг	0.12	0.00
	Багалзуур, кг	0.42	0.00
	Шулуун гэдэс, кг	0.37	0.37
	Дэлүү, кг	0.52	0.00
	Сархинаг, кг	1.26	1.26
	Олгой, кг	0.76	0.00
	Нарийн гэдэс, кг	2.22	2.22
	Хос, кг	1.07	0.00
	Үхрийн тагалцаг, кг	0.00	0.00
	Чих, кг	0.00	0.00
	Уруул, кг	0.00	0.00
Шөрмөс, кг	0.55	0.00	
Бүлх, кг	0.00	0.00	
	II-ийн дүн	33.21	29.32
Техникийн түүхий эд	Дотор өөх, кг	6.08	6.08
	Чив төмсөг, кг	0.00	0.00
	Цөс, кг	0.26	0.00
	Эвэр, туруу, кг	0.00	0.00
	Нүд, кг	0.00	0.00
	Цус, кг	12.02	0.00
	III-ийн дүн	18.36	6.08
	Нийт дүн	63.77	44.8

Тооцоогоор нэг үхрээс 60 гаруй кг буюу дундаж амьдын жингийн 25, гулуузын жингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий гардаг. Үүнээс 70 орчим хувийг нь хүнсний зориулалтаар боловсруулж ашиглах боломжтой. Үүн дээр цусыг нэмбэл энэ хэмжээ 80%-д хүрнэ.

Хүснэгт 16. Хонины дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ, кг-аар

Ангилал	Дотор мах, дайвар түүхий эдийн нэр төрөл	Хонины дотор мах, дайврын гарцын тооцоо	
		Нэгжийн гарц, кг	Хүнсэнд хэрэглэж байгаа дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ
1 дүгээр ангиллын дотор мах	Элэг, кг	0.720	0.720
	Хэл, кг	0.090	0.090
	Бөөр, кг	0.129	0.129
	Зүрх, кг	0.189	0.189
	Цөвдөл мах, кг	0.170	0.170
	Өрц, кг	0.145	0.145
	Годон сүүл, кг	0.208	0.208
	Дэлэн, кг	0.400	0.00
	Хэсгийн дүн	2.510	1.650
2 дугаар ангиллын дотор мах	Уушиг, кг	0.436	0.436
	Ястай толгой, кг	2.117	2.117
	Шийр, кг	0.877	0.877
	Нойр булчирхай, кг	0.035	0.00
	Гүзээ, кг	0.848	0.848
	Ходоод, кг	0.232	0.232
	Улаан хоолой, кг	0.093	0.00
	Цагаан мөгөөрс	0.050	0.00
	Багалзуур, кг	0.070	0.00
	Шулуун гэдэс, кг	0.170	0.170
	Дэлүү, кг	0.086	0.00
	Сархинаг, кг	0.232	0.232
	Өлөн гэдэс, кг	0.580	0.580
	Олгой, кг	0.248	0.248
	Хос гэдэс, кг	0.427	0.427
	Хэсгийн дүн	11.06	6.17
Техникийн түүхий эд	Дотор өөх, кг	1.296	1.296
	Өөхөн сүүд, кг	0.785	0.785
	Чив төмсөг, кг	0.00	0.00
	Хээлийн сав, кг	0.00	0.00
	Нүд, кг	0.00	0.00
	Цус, кг	2.423	2.42
	Хэсгийн дүн	4.50	4.50
Нийт дүн		18.07	12.32

Нэг толгой хониноос амьдын жингийн 45%, гулуузын жингийн 90 орчим хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гардгаас 68 хувийг хүнсний зориулалтаар ашиглах боломжтой.

Хүснэгт 17. Ямааны дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ, кг-аар

Ангилал	Дотор мах, дайвар түүхий эдийн нэр төрөл	Ямааны дотор мах, дайврын гарцын тооцоо	
		Нэгжийн гарц, кг	Хүнсэнд хэрэглэж байгаа дотор мах, дайврын нэгжийн гарцын хэмжээ
1 дүгээр ангиллын дотор мах	Элэг, кг	0.52	0.52
	Хэл, кг	0.11	0.11
	Бөөр, кг	0.13	0.13
	Зүрх, кг	0.13	0.13
	Цөвдөл мах, кг	0.12	0.12
	Өрц, кг	0.13	0.13
	Годон сүүл, кг	0.07	0.07
	Дэлэн, кг	0.32	0.00
	Хэсгийн дүн	1.51	1.19
2 дугаар ангиллын дотор мах	Уушиг, кг	0.30	0.30
	Ястай толгой, кг	1.92	1.92
	Шийр, кг	0.80	0.80
	Нойр булчирхай, кг	0.28	0.00
	Гүзээ, кг	0.59	0.59
	Ходоод, кг	0.17	0.17
	Улаан хоолой, кг	0.04	0.00
	Цагаан мөгөөрс, кг	0.00	0.00
	Багалзуур, кг	0.06	0.00
	Шулуун гэдэс, кг	0.12	0.12
	Дэлүү, кг	0.07	0.00
	Сархинаг, кг	0.14	0.14
	Өлөн гэдэс, кг	0.38	0.38
	Олгой, кг	0.15	0.15
	Хос гэдэс, кг	0.35	0.35
Хэсгийн дүн	5.35	4.91	
Техникийн түүхий эд	Дотор өөх, кг	1.35	1.35
	Чив төмсөг, кг	0.00	0.00
	Хээлийн сав, кг	0.00	0.00
	Эвэр, туруу, кг	0.00	0.00
	Нүд, кг	0.00	0.00
	Цус, кг	2.40	2.40
	Хэсгийн дүн	3.75	3.75
Нийт дүн		10.61	9.85

Эх сурвалж: Төслийн багийн гаргасан тооцоо

Нэг толгой ямаанаас амьдын жингийн 30%, гулуузын жингийн 70 орчим хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гардгаас 90 хувийг хүнсний зориулалтаар ашиглах боломжтой.

Дээрх хүснэгт (14-17)-д хүнсэнд төхөөрсөн нэгж малаас гарч байгаа нийт болон зөвхөн хүнсэнд хэрэглэгддэг дотор мах, дайврын нэр төрөл, нэгж тус бүрийн жинг ялган харуулсан болно Хүснэгтийн 4 дүгээр баганад байгаа зөвхөн хүнсэнд хэрэглэж байгаа дотор мах, дайврын нийт жинг 2019-2023 онд хүнсэнд төхөөрсөн малын тоогоор (хүснэгт 18) үржүүлэх замаар Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын нийт нөөцийг малын төрөл тус бүрээр тооцон гаргаж, хүснэгт 19-д харуулав.

Хүснэгт 18. Монгол Улсын 2019-2023 онд хэрэгцээлсэн малын тоо, малын төрлөөр

Он	2019	2020	2021	2022	2023
Адуу	633,300	955,000	570,300	655,000	541,600
Үхэр	943,700	1,319,400	899,400	1,103,400	1,051,700
Хонь	9,653,300	12,508,100	8,296,500	10,530,800	10,721,500
Ямаа	6,671,000	9751100	7206200	8598800	7314300
Бүгд	17903319	24535620	16974421	20890022	19631123

Эх сурвалж: УСХ

Хүснэгт 19. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын нөөц: малын төрлөөр,

биет жин: тн-оор (2019-2023 онд хэрэгцээлсэн малын тоонд үндэслэн тооцсон)

Он		2019	2020	2021	2022	2023
Дотор дайврын хэмжээ, тн	Адуу	9974.5	15041.3	8982.2	10316.3	8530.2
	Үхэр	42277.8	59109.1	40293.0	49432.3	47116.2
	Хонь	118928.7	154099.8	102212.9	129739.5	132088.9
	Ямаа	65709.4	96048.3	70981.1	84698.2	72045.9
Нийт дүн		236890.4	324298.5	222469.3	274186.3	259781.2
Нийт харьцуулсан хувь	Адуу	4.2	4.6	4.0	3.8	3.3
	Үхэр	17.8	18.2	18.1	18.0	18.1
	Хонь	50.2	47.5	45.9	47.3	50.8
	Ямаа	27.7	29.6	31.9	30.9	27.7
Нийт дүнгийн хувь		100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан тооцоо

Бид 4 төрлийн малын хүнсний дотор мах, дайврын нийт нөөцийг тооцож үзэхэд, манай улс 2019-2023 онд хүнсэнд хэрэгцээлсэн 4 төрлийн малаас жилд 222.5-324.3 мянган тонн дотор мах, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой (хүснэгт 19) байжээ Үүнд арьс, шир, тархи, эвэр, яс зэрэг хүнсний бус дайвар түүхий эдийг оруулаагүй, зөвхөн хүнсэнд хэрэглэгддэг дотор мах, дайврыг хамруулж тооцсон.

Үүнээс малчин өрхийн дотоодод хэрэгцээлсэн 4 төрлийн малаас гарах 37.2 мянган тонн дотор мах, дайврыг малчид, хөдөөгийн хэрэглэгчид бүрэн хэрэгцээлсэн гэж тооцвол цаана нь 185.3-287.1 мянган тонн дотор мах, дайвар гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэгдэх боломжтой байжээ.

Эрдэмтдийн судалж тооцооноор малын дотор мах, дайврын гарц малын амьдын жин ба нас, хүйс, тарга хүчээс хамааран тухай бүр хэлбэлздэг, малын өсөлт, бойжилт нь байгаль, цаг уурын нөхцөлтэй холбогдон жигд биш явагддаг зэрэг онцлогтой байдаг боловч энэ нь үндсэн нөөцийн хэмжээнд ноцтой өөрчлөлт авчрахгүй юм.

4.3. Дотор мах, дайвар түүхий эдийн гарц тогтоох хэмжилтийг сайжруулах асуудал

Хүнсний дотор мах, дайврын гарцын талаар үндэсний лавлагаа бий болгох зайлшгүй шаардлагатай нь энэхүү судалгааны явцад харагдлаа. Цаашид хүнсний дотор мах, дайврын гарцыг нарийн зөв тогтоож, нөөцийн хэмжээг үнэн зөв үнэлдэг байх, төхөөрч буй малын “хошуунаас сүүл” хүртэлх бүх зүйлийг боловсруулж, бүрэн дүүрэн ашигладаг болохын тулд “дотор мах, дайвар болон дагалдах түүхий эдийн гарц”-ыг 4 төрлийн мал тус бүр дээр хэмжих нэгдсэн арга зүйг нарийн

боловсруулж, намрын мах бэлтгэлийн явцад үйлдвэрүүд дээр жил бүр хэмжилт хийлгэж, дүнг нэгтгэн авч боловсруулалт хийдэг болох шаардлагатай байна.

Энэ жилийн тухайд “Преком” ХХК-ий мал төхөөрөх үйлдвэрт адууны дотор мах, дайврын хэмжилтийн ажил хамгийн сайн хийгдсэн бөгөөд үүнийг цаашид загвар болгон ашиглах саналыг дэвшүүлж байна.

Энэ жишээн дээр түлгуурлан цаашид хэмжилт хийхдээ “Дотор мах, дайвар бүтээгдэхүүний гарц тодорхойлох хэмжилт хийх ажлын технологийн заавар” гаргаж, түүнийг хэрэгжүүлэх багийг үйлдвэрийн удирдлагын тушаал, шийдвэрээр томилон ажиллуулдаг байх нь зүйтэй.

Хэмжилт хийх ажлыг технологийн зааврын дагуу хэрэгжүүлснээр хавсралт хүснэгт (1, 2, 3, 4)-д харуулж буй мэдээллүүд бүрэн гүйцэд гарч ирэх ач холбогдолтой. Өөр нэг чухал санал нь “дотор мах, дайврын ангилал”-ын талаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартыг дээр дурдсан хавсралт хүснэгтэд харуулсан ангилалтай ижил болгон шинэчилж, мөрдүүлэх хэрэгтэй байна. Дээрх саналуудтай холбогдуулан 2023 онд Преком ХХК-ий мал төхөөрөх үйлдвэр дээр хийгдсэн адууны дотор мах, дайврын хэмжилтийн бүртгэлийн маягтуудын загварыг энэ тайлангийн хавсралтад харууллаа (хавсралт хүснэгт 1-4).

БҮЛЭГ 5. ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Дотор мах, дайвар түүхий эдийн дотоод зах зээлийн судалгааг бог малын дотор мах, дайврын нийлүүлэлт, борлуулалт, эрэлт, хэрэгцээ, ашиглалт дээр голлож явуулав. Мөн хэрэглэгчдийн зан хандлагыг тандах асуумж судалгаа гүйцэтгэсэн болно.

5.1. Дотор мах, дайвар түүхий эдийн ашиглалт, боловсруулалт

5.1.1. Үйлдвэрт төхөөрсөн малаас гарах дотор мах, дайвар түүхий эдийн ашиглалт, боловсруулалт, борлуулалтын түвшин

Монголын Махны Холбооноос 2024 оны 1-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан дотор мах, дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах тухай хэлэлцүүлгийн үеэр нийслэл УБ хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй зарим үйлдвэрийн төхөөрсөн малаас гарах дотор мах, дайвар түүхий эдийн ашиглалт, борлуулалтын талаар мал төхөөрөх үйлдвэрүүдээс асуулга-судалгаа авсан юм.

Уг судалгаанд мал төхөөрөх, мах экспортлох эрх бүхий Мах импекс ХК, Монгол эко мах ХХК, Мах маркет ХХК, Цалуут импекс ХХК, БӨЖТ ХХК, Траст трэйд ХХК, Монгол мах экспо ХХК, Сүхбаатар маркет ХХК, Арвижих лотос ХХК, Саян Уул ХХК, Дархан мийт фүүдс ХХК, Чойбалсан груп ХХК, Жавхлант дэлгэрхангай ХХК, Сүхбаатар хийморь импекс ХХК, Дээжийн өргөө ХХК, Преком ХХК зэрэг 16 аж ахуйн нэгж хамрагдав.

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал нийлбэр дүнгээр нэг ээлжинд 3125 бод, 16220 толгой бог мал төхөөрөхөөр байна.

Эдгээр үйлдвэрийн төхөөрсөн малын дотор мах, дайвар түүхий эдийн ашиглалт дараах байдалтай байна (хүснэгт 20).

Хүснэгт 20. Үйлдвэрүүдийн бэлтгэсэн дотор мах, дайвар түүхий эдийн борлуулалт, ашиглалтын байдал, малын төрөл болон борлуулалтын хувиар

Нэр төрөл	Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Бүгд
Асуулгад хариулсан ААН-ийн тоо	11	14	13	12	50
Арьс, ширний борлуулалтын хувь	64	50	38	58	53
Толгойн ашиглалтын хувь	55	57	46	67	56
Шийрний ашиглалтын хувь	45	36	15	42	35
Дотор мах, гэдэс ашигталатын хувь	64	57	46	67	59
Өлөн гэдэс	27	79	46	67	55
Цусны ашиглалтын хувь		7	8		4
Ясны ашиглалтын хувь	18	14	8	17	14
Төхөөрөх явцад гарсан хүнсний бус хаягдлын эзлэх хувь		7	15	8	8
Шуллагааны хаягдал	18	14	26	33	23
Дундаж үзүүлэлт	32.3	36	28	40	34

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд төхөөрсөн малын арьс, ширний 53%-ийг шууд борлуулж, үлдэх хэсгийг хаягдалд тооцох, эсвэл малаа төхөөрүүлсэн хүмүүст буцаан өгдөг байна. Малын толгойн ашиглалт дунджаар 56 хувь, шийр 35 хувь, дотор мах, гэдэсний ашиглалт 59 хувь байна. Цус, төхөөрөлтийн явцад гарч байгаа хүнсний бус хаягдал, ясны ашиглалт хамгийн бага (4-14%) байна.

Борлуулалтын хувьд хамгийн өндөр хувийг хонины өлөн гэдэс (79%) эзэлж байгаа бол бараг ашиглалтгүй байгаа дайврын тоонд малын цус (4%) тооцогдож байна. Үхрийн өлөн гэдэсний ашиглалт 27%, бусад нь хаягдаж байгаа нь дотоодын хиам үйлдвэрлэлд хиймэл хальс хэрэглэх явдал түгээмэл болсон, үхрийн гэдсийг экспортлохгүй байгаа зэрэгтэй холбоотой байж болох юм. Харин хонь, ямааны өлөн гэдэсний борлуулалт 100 хувь биш байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь төхөөрөх үйлдвэрүүд захиалгаар төхөөрсөн малын өлөн гэдсийг зарим тохиолдолд захиалагчид буцаан олгодогтой холбоотой байж болох юм.

Адууны давсалсан өлөн гэдсийг “салями” сортын хиамны бүрхэвчийн зориулалтаар Итали руу, “казы” хэмээх уламжлалт хоолны бүрхэвчийн зориулалтаар Узбекистан, Казахстан зэрэг орнуудад экспортолж ирсэн уламжлалт худалдааны чиглэл сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж, Хятад, Хонконг руу хатаасан өлөн гэдэс гаргадаг бизнест зайгаа тавьж өгсөн нь үнийн өрсөлдөөнтэй холбоотой боловч өнөөгийн ашиглалт 67 хувьтай байгаа нь борлуулалт бүрэн тогтвортой биш байгааг харуулж байна. Одоогоор нэг адуунаас хамгийн олон нэр төрлийн дотор мах, дайврыг борлуулж байна.

Хүнсний зориулалтын дотор мах, дайврын борлуулалт дөрвөн төрлийн малын дундаж үзүүлэлтээр 59 хувьтай байгаа нь үйлдвэрийн аргаар мал төхөөрдөг үйлдвэрүүдийн хувьд чамлалттай байна.

Мал төхөөрөх үеийн хүнсний бус хаягдлын борлуулалт 8 хувь байхад, шуллагааны хаягдлын борлуулалт 23 хувьтай байгаа нь хэдийгээр багахан хувийг эзэлж байгаа ч цаашид хүнсний бус хаягдлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэл тавигдаж буйг харуулж байна.

2023 онд Монгол улсаас экспортолсон 517 тонн буюу 4.5 сая толгой бог малын өлөн гэдэсний 80 хувийг Европын өндөр хөгжилтэй орнуудад нийлүүлсэн байна. Эндээс үзэхэд богийн өлөн гэдэсний хувьд тогтвортой борлуулалттай, зах зээлд байр сууриа олсон бүтээгдэхүүн болсон тул мал төхөөрөх үйлдвэрүүдээс хамгийн бага хэмжээгээр хаягдалд тооцогддог дайврын тоонд багтжээ. Харин малын

цусыг үндсэндээ 100% хаядаг. Түүнчлэн мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэлээс хаягдалд тооцогддог ясны хэмжээ 52 хувьтай байгаа нь өндөр үзүүлэлт гэж үзнэ.

Хүснэгт 21. Мал төхөөрөх үйлдвэрлэлээс шууд хаягдалд тооцдог дотор мах, дайврын судалгаа (үйлдвэрүүдийн өгсөн хариулт, хувиар)

Нэр төрөл	Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Бүгд
Асуулгад хариулсан ААН-ийн тоо	11	14	13	12	50
Арьс, шир	18	42	7	15	21
Толгой	9	33	21	8	18
Шийр	27	67	50	38	46
Дотор мах, гэдэс	9	33	14	8	16
Өлөн гэдэс	27	0	14	0	10
Цус	100	94	94	100	97
Яс	45	67	50	46	52
Төхөөрөх явцад гарсан хүнсний бус хаягдал	64	83	50	46	61
Шуллагааны хаягдал	64	67	50	38	55
Дундаж үзүүлэлт	32.3	36	28	40	34

Үйлдвэрүүд төхөөрсөн малын өрцний мах, годон, элэг, зүрх, бөөр, өлөн гэдэс зэрэг түүхий эдийн 70 хүртэл хувийг харин уушги, гүзээ, дотор өөх зэрэг түүхий эдийн 50 хувийг боловсруулдаг.

Дотор мах, дайвар түүхий эдийг хүнсний зориулалтаар боловсруулахын зэрэгцээ зарим нэг үйлдвэр хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, түүнчлэн гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэдэг. Үйлдвэрлэгч нарын хувьд дотор мах, дайвар түүхий эдийг хүнсний зориулалтаар боловсруулахад тогтвортой борлуулах зах зээл, мөн мэргэжлийн ажиллах хүчний хомсдол, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх технологи-эрүүл ахуйн мэдлэг, лабораторийн чадамж гол бэрхшээл болдог (хүснэгт22, 23, 24).

Хүснэгт 22. Дотор мах, дайврыг боловсруулахад учирч буй гол бэрхшээл

№	Асуулт	Хувь
1	Зориулалтын ажлын байрны зай талбай, хүрэлцээ муу	13
2	Шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг	44
3	Хүний нөөцийн хүрэлцээ муу	50
4	Технологийн мэдлэг, дадлага, туршлага дутмаг	31
5	Дотооддоо тогтвортой борлуулах зах зээл хомс	56
6	Борлуулалтын зах зээлийн талаар мэдээлэл дутуу	25
7	Үнээр өрсөлдөх чадвар дутуу	25
8	Хөргөх, хөлдөөх агуулахын хүрэлцээ муу	13
9	Албан ёсоор манай улсаас импортлох зах зээл хомс тул үйлдвэрлэгч нарт гадагш чиглэсэн үйл ажиллагаа явуулах сонирхол байхгүй	31
10	Бусад...	6

Хүснэгт 231. Дотор мах, дайврыг боловсруулахад технологийн талаас учирч буй бэрхиээл

№	Асуулт	Хувь
1	Хэрхэн боловсруулах, хадгалах, тээвэрлэх технологи, эрүүл ахуйн мэдлэг дутуу	44
2	Дотор мах, дайврын шим тэжээл, эрдэс, витаминь найрлагын талаар мэдлэг дутуу	25
3	Хэнд зориулж, ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж болох талаар мэдлэг, мэдээлэл дутуу	50
4	Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн, аюулгүй бүтээгдэхүүний шинэ жор зохиох мэдлэг дутуу	38
5	Хадгалалтын хугацааг зөв тогтоох, шинэлэг байдлыг хадгалахад хүндрэлтэй	38
6	Тохиромжтой сав баглаа боодол, тоног төхөөрөмжийн талаар мэдээлэл дутуу	19
7	Бүтээгдэхүүний найрлага, аюулгүйн үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох чадавхтай лаборатори дутмаг	50
8	Бусад	13

Хүснэгт 24. Дотор мах, дайвар боловсруулж зах зээлд гаргахад учирч буй бэрхиээл

№	Асуулт	Хувь
1	Борлуулалтын тоо хэмжээ бага.	44
2	Тогтвортой худалдан авагч байхгүй.	69
3	Хөрөнгө оруулалтын өгөөж муу.	38
4	Экспортын зах зээл хомс түл бөөнөөр үйлдвэрлэх сонирхол байхгүй.	50
5	Тээврийн зардал өндөр.	25
6	Хадгалах зардал өндөр.	31
7	Бусад...	6

Дотоодын хэрэглэгчдэд дотор махны хүнс тэжээлийн үнэт чанарын талаар нэгдсэн журмаар сурталчлах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, аюулгүй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь мэдлэг, дадлага олгох сургалтын нэгдсэн платформ үүсгэх нь дотор мах, дайвар түүхий эдийн борлуулалтыг идэвхжүүлэх нэг арга зам юм (хүснэгт 25).

Түүнчлэн “экспортын зах зээлийг шинээр нээж бөөнөөр нь борлуулах шаардлагатай байна” гэж үзэж байгаа нь манай үйлдвэрлэгчдийн зүгээс дотор мах, дайврыг боловсруулах боломж, сонирхол байгаа хэдий ч хөрөнгө оруулалтын өгөөж, санхүүгийн үр ашгаар энэхүү сонирхол нь хязгаарлагдаж буйг харуулж байна. Дэвшилтэт технологиор боловсруулж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолтой байгаагаа 56 хувь нь илэрхийлсэн нь цаашид дэмжин хөгжүүлбэл зохих чухал санаачилга мөн юм.

Хүснэгт 25. Дотор мах, дайврын борлуулалтыг идэвхжүүлэх арга зам

№	Асуулт	Хувь
1	Дотоодын хэрэглэгчдэд дотор мах, дайврын ашигтай тустай талуудыг нэгдсэн журмаар сурталчлах.	63
2	Зөвхөн зах зээлийн хэрэгцээнд тулгуурлан үйлдвэрлэх биш экспортын зах зээлүүдийг шинээр нээж бөөнөөр борлуулах.	75
3	Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, аюулгүй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь мэдлэг, дадлага олгох сургалтын нэгдсэн платформ үүсгэх.	56
4	Олон улсын худалдаа, үнэ, эрхзүйн орчны мэдээллийг үйлдвэрлэгчдэд тогтмол хүргэх мэдээллийн нэгдсэн платформ бий болгох.	31
5	Арьс, шир, яс, цус, сэвс, бусад хүнсний бус хаягдлыг төхөөрөх үйлдвэрүүдээс тогтмол худалдан авах чадавхи бүрдүүлэх.	50
6	Дэвшилтэт технологиор шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадавхи бий болгох.	56
7 7	Олон улс, бүс нутгийн чанартай үзэсгэлэн худалдаанд нэгдсэн журмаар тогтмол оролцож сурталчилгаа хийхэд төрийн дэмжлэг үзүүлэх.	50
8	Бусад... (гол нь гадагш чиглэсэн байх, мэргэжлийн сургуульд суралцагчдыг дадлагажуулах, хүний нөөц бэлтгэх)	6

5.1.2. Дотор мах, дайвар түүхий эдэд суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Хүнсний аюулгүй байдлын олон улсын стандарт нэвтрүүлж, баталгаажуулсан Траст Трейд, Хатан сүйх, Хүн Од, Мах маркет зэрэг боловсруулах үйлдвэр дотор мах, дайвар түүхий эдийг боловсруулан элэгний нухаш, гүзээний ороомог, царцмаг, түүнчлэн өөхөн тос, саван зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг (хүснэгт 26).

Хүснэгт 262. Малын дотор мах, дайвраар бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг гол компаниудын бүтээгдэхүүний нэр төрөл, худалдааны суваг

№	Компаний нэр	Үйлдвэрлэж буй дотор махан бүтээгдэхүүний		Худалдаалж буй суваг
		нэр төрөл	хэмжээ, тн	
1	Хатан сүйх импэкс ХХК	ясны шөл, элэгний нухаш, үхрийн гол махтай царцмаг. Мөн малын бүлх, шөрмөсийг боловсруулж хиаманд үургийн баяжуулагч болгон ашигладаг.	55	Хүнсний зах, сүлжээ дэлгүүр, хүнсний дэлгүүрүүдээр худалддаг. Ясны шөлийг БНСАУ-д экспортлохоос гадна дотоодын Шөлөндөө хоолны газарт нийлүүлдэг.
2	Хүн-Од ХХК	Царцмаг дотор махан хиам, хонины уураг сүүл, элэгний нухаш, годон	65.8	Хүнсний зах, сүлжээ дэлгүүр, хүнсний дэлгүүрүүдээр худалддаг.
3	Мах маркет ХХК	Дотор махан царцаамаг, элэгний нухаш, богийн таван цулын бууз	25	Хүнсний зах, сүлжээ дэлгүүр, хүнсний дэлгүүрүүдээр худалддаг.
4	Очир дагинас ХХК	Үхрийн элэгний нухаш, зүрхтэй царцмаг, дотор махны болон Гүзээний шөл, Гэрийн тэжээвэр амьтны хоол.	145	Гэрийн тэжээвэр амьтанд зориулан дотор мах, дайвар түүхий эдээр үйлдвэрлэсэн 9 нэр төрлийн бүтээгдэхүүнийг БНСУ-ын зах зээлд нийлүүлж байна. Бусад бүтээгдэхүүнээ хүнсний зах, сүлжээ дэлгүүр, хүнсний дэлгүүрүүдээр худалддаг
5	Трасттрейд ХХК	Элэгний нухаш, үхрийн зүрх болон гахайн хуйхтай царцмаг, үхрийн гүзээний ороомог болон гүзээний царцмаг	42.1	Улаанбаатарт орон нутагт 5 нэрийн дэлгүүр /Дархан, Эрдэнэт, Дорнод, Сайншанд-Замын-Үүд, Өмнөговь-Цогтцэций/-д худалдаалж байна.
6	Хиам, консервын үйлдвэр ХХК	Элэгний нухаш	170	Хүнсний зах, сүлжээ дэлгүүр, хүнсний дэлгүүрүүдээр худалдан борлуулж байна.

Нэр бүхий үйлдвэрүүд нийтдээ 500 гаруй тн дотор махан бүтээгдэхүүн жилдээ үйлдвэрлэдэг байна. Үйлдвэрүүдээс гадна жижиг цехүүд мөн дотор махан бүтээгдэхүүн бага хэмжээгээр зах зээлд нийлүүлдэг. Дотор махан бүтээгдэхүүний гарц түүхий эдийн жингийн 60 орчим хувь хэмээн тооцвол 1000 орчим т дотор мах боловсруулдаг байхаар байна. Гэхдээ үйлдвэрлэлд үхрийн элэг, зүрх, гүзээ голлон ашигладаг бөгөөд нөөцийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа богийн дотор мах ашиглалт хангалтгүй байна.

5.2.Дотор мах, дайварын дотоод зах зээл дээрх борлуулалтын байдал

Манай улс нийт дотор махны 5 хувийг экспортод гаргаж, мөн 5-10 хувийг дотооддоо ашиглан, үлдсэн 85-90 хувийг үрэгдүүлж байгаа талаар зарим судлаачид мэдээлсэн байдаг.

Улаанбаатар хотод дотор мах, дайвар бүтээгдэхүүн борлуулдаг зах, дэлгүүрээр судалгааны хүрээнд үнийн судалгаа хийж үзэхэд маш чамлалттай борлуулалт хийгддэг нь харагдаж байна. Улаанбаатар хотод зарагдаж байгаа малын дотор мах, дайвар түүхий эдийн хамгийн их борлуулалт хийдэг газар өнөөдрийн байдлаар Хүчит шонхор зах юм.

Хүчит шонхор зах дахь малын дотор мах зардаг лангуун дээр нийт 50 орчим хүн ажилладаг. Тэдний 30 орчим нь бог малын түүхий эд, 10-аад нь адууны гэдэс, 10 орчим нь үхрийн дотор мах, дайвар түүхий эд борлуулдаг. Нэг хүн өдөрт дунджаар 25 бог, 10 адуу, 10 үхрийн гэдэс тус тус зарж борлуулдаг байна. Долоо хоногт ойролцоогоор 3500 кг үхрийн дотор мах, дайвар түүхий эд, 15750 кг бог малын дотор мах, дайвар түүхий эд, 3500 кг адууны дотор мах, дайвар түүхий эд борлогдож байна. Гэхдээ энэ нь зөвхөн нэг агшны судалгаа гэдгийг анхаарах хэрэгтэй.

Бусад супер маркет, жижиг зах, дэлгүүрүүд гол төлөв Хүчит шонхор захаас татан авалтаа хийдэг ажээ. Эдгээр дэлгүүр, захуудад 7 хоногт дунджаар 1850 кг үхрийн дотор мах, дайвар түүхий эд, 1230 кг адууны дотор гэдэс, 1450 кг богийн дотор мах, дайвар түүхий эд нийлүүлэгдэж байна (хүснэгт 27, 28, 29, 30). Хүчит шонхор захын борлуулалт энд орсон болно.

Сүүлийн жилүүдэд дотор мах, дайвар бүтээгдэхүүн зарагдах хэмжээ багассан тухай жижиглэн худалдаа эрхлэгч нар ярьж байв. Онцлон дурдахад Хятад компани, хувь хүмүүс малын дотор мах, гэдсийг их хэмжээгээр нядалгааны газраас нь бөөндөж шууд авдаг болсон ажээ. Ялангуяа адууны гэдэс, дотор, дотор өөх, далангийн өөхийг Хятад компани ихээр авдаг байна.

Мөн үхэр болон бог малын дотор өөхийг савангийн үйлдвэрүүд авч үйлдвэрлэлд оруулж байгаа нь сайшаалтай хандлага гэж үзнэ. Бидний хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын Баянзүрх Худалдааны төв, Дүүхээ төв, Сонгино-хайрхан зах, Давшил трейд, Чухаг супермаркет, Хар хорин зах, Сандэй зах, Бөмбөгөр, Алтжин бөмбөгөр, Хүчит шонхор зах, Нарантуул, Баянзүрх, Лавай зэрэг зах, худалдааны төвүүд дээр борлуулагдаж байгаа дотор мах, дайвар бүтээгдэхүүний хэмжээ 7 хоногт 25.6 тн, сардаа 102.4 тн, жилдээ 1.2 мянган тонн болж байна.

Хүснэгт 27. Үхрийн дотор мах, дайвар түүхий эдийн зах зээл, борлуулалтын судалгаа (2024 оны 1 дүгээр сар)

Ханган нийлүүлэгч	" Хүчит шонхор" бөөний худалдааны төв										ХШБХТ* ба Орон нутаг	Дорнод
	Баянзүрх Худалдааны төв	СХД Дүүхээ төв	Сонгино-хайрхан зах	СХД Давшил трейд	Чухаг супер-маркет	Хар хорин зах	Сандэй зах	Бөмбөгөр	Алгжин	Хүчит шонхор зах		
Борлуулалтын хэмжээ: 7 хоног/кг	50	30	200	150-200	20	500	50	200	150	1850	300-400	50
Түүхий эдийн нэр төрөл	Жижиглэнгийн захууд дээр зарагдаж буй түүхий эдийн үнэ, төг/кг											
Элэг	3500		2500-3000	-	2500	2000	-	-	3000	1000	3500	2500
Уушиг	1000		1500	-	-	2000	-	1500	1500	300	1000	2500
Бөөр	1000		1500	-	-	2000	-	1500	1500	300	4000	1000
Зүрх	7000	6000	6000	-	6000	6000	6000	8500	8500	4000	8000	6000
Гүзээ	7000		6000	4500	7500	6000	6000	8500	8500	4000	8000	8500
Буллуны яс	-	3500	3500	-	-	-	-	-	-	500	-	-
Хэл	-		-	-	-	-	-	19500	-	15000	-	-
Хуйхалсан шийр	-		5000	-	-	-	-	-	7500	5000	-	-
Өөх	-		-	-	-	-	-	-	-	400	1000	-
Чихсэн жонго	-		-	-	-	-	-	-	-	1000	7000	-

Хүснэгт 28. Адууны дотор мах, дайвар түүхий эдийн борлуулалтын судалгаа /2024 оны 1 дүгээр сар/

Ханган нийлүүлэгч	" Хүчит шонхор" бөөний худалдааны төв										ХШБХТ ба Орон нутаг	Дорнод
	Баянзүрх зах	СХД Дүүхээ төв	Сонгино-хайрхан зах	СХД Давшил трейд	Чухаг супермаркет	Хар хорин зах	Сандэй зах	Бөмбөгөр	Алгжин	Хүчит шонхор зах		
Борлуулалтын хэмжээ /7 хоног/кг	100	100	150	100		120	60	150	100	3500	300	50
Түүхий эдийн нэр төрөл	Жижиглэнгийн захууд дээр зарагдаж буй түүхий эдийн үнэ, төг/кг											
Элэг			1000	1000						1000	1000	
Уушиг			1000	1000						1000	1000	
Бөөр			1000	1000						1000	1000	
Зүрх			1500	1500						1000	5000	
Умс	9500	6500	8500	8500		6000	6000	8500	9000	4500	8000	9000
Хитай	9500	6500	8500	8500		6000	6000	8500	9000	4500	8000	9000
Нарийн гэдэс											15000	

Хүснэгт 29. Богийн дотор мах, дайвар түүхий эдийн зах зээл, борлуулалтын судалгаа /2024 оны 1 дүгээр сар/

Ханган нийлүүлэгч	"Хүчит шонхор" бөөний худалдааны төв										ХШБХТ ба Орон нутаг	Дорнод
	Баянзүрх Худалдааны төв	СХД Дүүхээ төв	Сонгино-хайрхан зах	СХД Давшил трейд	Чухаг супер-маркет	Хар хорин зах	Сандэй зах	Бөмбөгөр	Алгжин	Хүчиг шонхор зах		
Борлуулалтын хэмжээ 7 хоног/кг	150	100	150	100		300	50	150	50	15750	300	100
Түүхий эдийн нэр төрөл	Жижиглэнгийн захууд дээр зарагдаж буй түүхий эдийн үнэ, төг/кг											
Элэг	1500		1500	1500		500	500	2000	2000	600	1000	1500
Уушиг	1000		1000	1000		500	500			300	1000	1000
Бөөр	1000		3000	2800		2000	2000			800	4000	1000
Зүрх	6500		6500	4500		3500	3000	8500	8500	1500	7500	6000
Гүзээ	600		1500			500		8500	8500	500	1000	600
Сүүл	11000	11500	9500	6500				12000	12000		15000	7000-10000
өрцний мах			3500									
Хуйхалсан толгой			5000	4500		4500		4500	5000	3500		
Годон			8500									
Өлөн			2500-3000									
Үстэй толгой				1000		1000	1000			500		
Чихсэн жонго				600			4500					
Өөх											500	

Хүснэгт 30. Улаанбаатар хотын зах, худалдааны төвүүд дээр борлуулагдаж буй дотор мах, дайвар бүтээгдэхүүний хэмжээ, тн-оор

№	Малын төрөл	7 хоногийн борлуулалтын хэмжээ тн	Сарын борлуулалтын хэмжээ тн	Жилийн борлуулалтын хэмжээ тн
1	Үхэр	3.7	14.8	177.6
2	Бог	17.2	68.8	825.6
3	Адуу	4.7	18.8	225.6
4	Бүгд	25.6	102.4	1228.8

Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан дүн

Хүснэгт 19-д харуулсан, 2019-2023 онд хэрэгцээлсэн 4 төрлийн малын нийт 222.5-324.3 мянган тонн дотор мах, дайврын боломжит нөөцөөс экспортод гаргасан 1.7 мянган тн, хөдөөгийн хэрэглэгчдийн хэрэгцээлсэн 37.2 мянган тонн, Улаанбаатар хотын захуудаар борлуулагдаж буй 1.2 мянган тонн, нийт 40.1 мянган тонн дотор мах, дайврыг хасахад ойролцоогоор 182.4-284.2 мянган тонн дотор мах, дайвар хэрэглээгүй хаягдсан байж болзошгүй. Энэ нь нийт нөөцийн 82-87.6 хувьтай тэнцэж байгаа буюу бусад судлаачдын гаргасан тооцоотой тун ойролцоо дүнтэй байна.

5.3. Нийтийн хоол үйлдвэрлэлийн талаарх судалгааны тойм

2020 оны байдлаар Монгол улсын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нийтдээ 8500 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 47% нь аймаг орон нутагт, 53% нь нийслэл хотод ажиллаж байна. Эдгээрийн 31% нь нийгмийн салбарт, 68 % нь бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба хоолны газрын нийт сүүдлын тоо 600000-650000 гаруй юм байна.

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын судалгааг доорх хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 31. Нийслэл хотод хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгаа (2024 оны 4 сарын 15-ны байдлаар)

№	Объект	Тоо
1	Ресторан	1129
2	Кафе	323
3	Баар	974
4	Гуанз / цайны газар /	1107
5	Түргэн хоолны газар	127
6	Кофе шоп	25
7	Хүргэлтийн хоол	12
8	Буфет	34
9	Кейtring буюу захиалгат хоолны үйлчилгээ	5
10	Их, дээд сургууль, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байр, хүүхдийн зуслангийн нэгдсэн гал тогоо	959
11	Эмнэлэг, амралт, сувиллын газрын нэгдсэн гал тогоо	120
12	Үйлдвэрийн ажилчид, цэргийн анги, хорихын нэгдсэн гал тогоо	98
Нийт		4913

Нийслэлд нийт 1129 ресторан үйл ажиллагаа явуулдаг гэсэн судалгаа байгаагаас 358 аж ахуйн нэгж, гуанз, цайны газар 1107 ажиллаж байгаагаас 466 аж ахуйн нэгжийг судалгаанд хамруулав. Судалгаанд хамруулсан 35 ресторан (9.7), 26 цайны газар (5.5%) малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр 12 нэр төрлийн хоол, 11 төрлийн зууш, салат хийж нийтэд үйлчилдэг байна. Жилдээ 185,6 тн дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр хоол үйлдвэрлэдэг бөгөөд үүнээс ресторан 92,3 тн, гуанз, цайны газар 93,3 тн дотор мах, дайвар хэрэглэдэг гэсэн тойм судалгаа, дүн мэдээ гарч байна. Гуанз, цайны газрууд ихэнхдээ гүзээтэй цувдайг кг-аар бөөндөж авдаг тул дотор мах, дайварын ашиглалтыг нэр төрлөөр нь гаргах боломжгүй байна. Судалгаанаас үзэхэд Таван цулын шөл, хуушуур, цуйван, гүзээний салат, хэлэн зууш, гүзээний шөл, дотор махан пирожки зэрэг төрлийн хоолыг ихэвчлэн хийдэг байна.

Үндэсний хоолоор үйлчилдэг Модерн Номадс, Их Монгол, Баянгол зэрэг ресторан, зоогийн газарт таван цулын шөл, гүзээний шөл, шарсан элэг, дотор махан бүүз, хуушуур, битүү чанасан хонины толгой, гургалдай, адууны үмс, хятай, таван цулын шөл, хонины годонтой шөл, гүзээний салат, гүзээний ороомог гэх мэт дотор махан хоол хийдэг байна. Үүнээс гадна цуйван, хорхог, шорлог, адуу үхрийн чанасан хавирга, банштай хар шөл гэх мэт үндэсний хоолоор үйлчилдэг байна.

Нийслэлийн 2 дүүргийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 аж ахуйн нэгж, иргэн жилдээ 89640 кг дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр 4 нэр төрлийн хоол, 2 нэр төрлийн зууш бэлтгэн

хэрэглэгчдэд хүргэж байна. Жуулчны баазууд улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг учраас харьцангуй бага хэмжээтэй дотор мах, дайвар бүтээгдэхүүн хэрэглэдэг судалгаа гарч байна.

Хүснэгт 32. Нийслэл дэх нийтийн хоолны газруудын дотор мах, дайварын нийт ашиглалтын хэмжээ

Үзүүлэлт	Ресторан	Гуанз цайны газар	Амралтын газар, жуулчны бааз	Бүгд дүн
Нийт тоо	1129	1107	133	2369
Дотор мах ашигладаг хоолны газрын тоо	35	26	17	78
Ашигладаг дотор мах, дайварын хэмжээ (тн)	92.3	93.3	89.6	257.2

Эх сурвалж: Судалгааны баг газар дээрээс нь авсан тоо, мэдээлэл

Цаашид дотор мах, дайвар бүтээгдэхүүний хоол, хүнсний хэрэглээ, хэрэгцээг Томоохон их, дээд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, цэргийн анги, хорих ангиуд зэрэг хоолны газруудыг хамруулан томоохон хэмжээний судалгаа хийж жилд улсын хэмжээнд хэрэглэгдэх дотор мах, дайвар бүтээгдэхүүний тоо хэмжээг гаргах, цаашид экспортлох боломжийг судлах шаардлагатай байна. Ялангуяа хүнсний хэрэглээнд адууны дайвар бүтээгдэхүүнийг (умс, хятай, каз гэх мэт) монголчууд нилээдгүй хэрэглэдэг мөртлөө ресторан, гуанз цайны газрын хоолны цэсэнд адууны дайвар бүтээгдэхүүний нэр төрөл бараг байхгүй байна.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын тогооч нарын холбоо, Монголын ресторан, зоогийн газрын холбоо хамтран “UB Food festival 2023” арга хэмжээг Монголын үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэдэд таниулах, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, зочлох үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулдаг.

Дотор махны ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэхэд БНХАУ-тай дайвар бүтээгдэхүүний мал эмнэлэг ариун цэврийн протоколыг тохирох шаардлагатай байна. Гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэлд илүү анхаарч энэ чиглэлийн импортлогч компаниудтай холбоо харилцаа тогтоох шаардлага байна.

5.4. Хэрэглэгчийн зан төлөв, хандлагын судалгаа

5.4.1. Онлайн асуумж-судалгаа

Хот суурин газрын оршин суугчдын дотор мах, дотор махан бүтээгдэхүүний хэрэглээний зан төлөвийг судлан мэдэж, түүний хэрэглээг дэмжих, хүнсний шимт тэжээллэг чанарыг сурталчлан таниулах оновчтой бодлогыг тодорхойлох, хөдөөгийн хүн ам, ялангуяа малчин айл өрх бог малын дотор махыг монгол уламжлалыг баримтлан хэрхэн ашиглаж байгаа болон ашиглалтгүй хаягдал болж байгаа дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааг явуулсан юм. Судалгааг хэрэглэгчтэй нүүр тулан уулзаж ярилцлага авах, on-line – аар асуумж бөглүүлэх аргыг хослон явуулав. On-line асуумжид дараах мэдээллийг илрүүлэх зорилготой асуултуудыг оруулсан. Үүнд:

- Зах зээлийн хэмжээ, түүнийг бүрдүүлэгчийн нас, хүйс, орлого, хэрэглэх хандлага,
- Хэрэглэж болох сурталчилгааны арга
- Худалдан авалтын хэмжээ
- Өрсөлдөж болох бүтээгдэхүүн
- Зах зээлийн үнийн нөлөө
- Боловсруулалтын түвшин

- Уламжлалт хэрэглээний зан үйл болон бусад шаардлагатай мэдээлэл.

Дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээлийн хэрэглэгчийн зан төлөвийн судалгаанд насны бүлэг, хүйс зэрэг хүчин зүйлсийн оролцоог аль болох тэгш хангах байдлаар 900 гаруй хүнийг хамруулан явууллаа. Судалгааг “Хот суурин газрын хүн ам” болон “Орон нутгийн малчин өрх” гэсэн хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүрд зориулсан асуумжийн загвар боловсруулж Google form-д байршуулан <https://forms.gle/RK6Sy7GHEdbu2LTB9>, https://forms.gle/t7otMdbtrTLtX_sud99 линкүүдээр дамжуулж, хот, суурингийн 586, орон нутгийн малчин 121 хүнээс хариулт авч, дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж, хүснэгт 33-д танилцуулж байна:

Хүснэгт 33. Хэрэглэгчдийн асуумж судалгааны дүн

Асуумжийн бүлэглэл	Хариултад хийсэн дүн шинжилгээ
Зах зээлийн хэмжээ, түүнийг бүрдүүлэгчийн нас, хүйс, орлого, хэрэглээний хандлага, зан төлөв	<p>Оролцогчдын насны ангиллыг авч үзвэл: 15-24 насныхан 7.9%; 35-45 насныхан 35%; 25-34 насныхан 28.7%; 46-55 насныхан 18.6%; 55-аас дээш насныхан 9.3% байна.</p> <p>дотор махны зах зээлийг үндсэнд нь 25-45 насныхан (63.7%) бүрдүүлж байна. 55-аас дээш насныхны оролцоо бага байгаа нь хэрэглээндээ бус, асуумжид оролцох боломж хязгаарлагдмал, мэдээллийн технологи ашиглах чадвар дутагдалтай байгаатай холбоотой байж болох юм. Харин хүүхэд, өсвөр насныхан дотор махыг бага хэрэглэдэг, эсвэл хэрэглэх сонирхолгүй байгаа нь харагдаж байна.</p> <p>асуумжид оролцогчдын 79.4%-ийг эмэгтэй, 20.5%-ийг эрэгтэй хүн бүрдүүлж байгаа нь хот, суурин газарт амьдардаг гэр бүлийн хувьд хоол, хүнсний хэрэглээг зохицуулж, шийдэхэд эмэгтэйчүүд голлох үүрэгтэй болох нь харагдаж байна.</p> <p>Хүмүүс дотор махыг орлогын түвшингээс үл хамааран хэрэглэдэг байна.</p> <p>Асуулгад оролцогчдын: 13.6% нь тогтмол; 82.5% нь хааяа хэрэглэдэг; 4 % нь огт хэрэглэдэггүй гэжээ.</p> <p>Үүнийг нарийвчлан задалж үзвэл, оролцогчдын 31.4 % нь сар бүр хэрэглээтэй, 59.6% нь улирал юм уу жилд 1-2 удаа л хэрэглэдэг байна.</p> <p>Дотор махыг хааяа болон эсвэл огт хэрэглэдэггүй гэсэн хариулт өгсөн хүмүүс дотор махыг гэртээ цэвэрлэж, боловсруулахад төвөгтэй, эсвэл эрүүл ахуйн аюулгүй байдал нь баталгаагүй, шинэлэг байдал нь эргэлзээтэй гэсэн нь дотор махны хэрэглээнд саад болж байгаа гол зүйлс нь түүний гарал үүсэл, ариун цэвэр, аюулгүй байдалтай холбоотойг харуулж байна.</p> <p>Хэрэглэгчдийн дийлэнх буюу 61.9% өөрсдөө харж төхөөрүүлсэн малынхаа гэдэс, дотрыг хэрэглэдэг, 24.3% нь захаас, үлдэх хэсэг нь нийтийн хоолны үйлчилгээнээс хоол авч иддэг байна.</p> <p>Дотор махны худалдан авахдаа гол нь түүний эрүүл, аюулгүй байдлын баталгаа, цэвэрлэгээ, боловсруулалтын чанар, өнгө, үнэр, шинэлэг байдлыг чухалчилдаг байна.</p>
Хэрэглэж болох сурталчилгааны арга хэрэгслийн тухайд	<p>Дотор махны талаарх мэдээллийг 78.9% нь гэр бүлийн уламжлалаас, 22.8% нь интернэт, нийгмийн сүлжээнээс, 14.8% нь ном, сонин, сэтгүүлээс авсан байна.</p> <p>Дотор мах хэрэглэх уламжлалт нүүдлийн соёл, зан заншил хэвээр хадгалагдаж байна. Үүний зэрэгцээ хүмүүс мэдээллийг олон янзын сувгаар авдаг болжээ. Харин дотор махны хэрэглээний хүнс, тэжээл, эрүүл мэндийн ач холбогдлын талаар хэрэглэгчдэд зориулсан зориудын сургалт маш хангалтгүй байгаа нь харагдаж байна.</p>
Зах зээлд өрсөлдөх боломжит бүтээгдэхүүн	<p>Асуулгад оролцсон хүмүүсийн 76.8% нь үйлдвэрийн аргаар боловсруулсан дотор мах худалдаж авдаггүй байна. Энэ нь үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан дотор мах зах зээлд маш бага (23.2%) хэмжээтэй нийлүүлэгдэж байгаатай холбоотой байж болох юм.</p> <p>Хэрэглэгчдийн 90 гаруй хувь нь цэвэр, шинэ дотор махыг түүхийгээр нь худалдан авах сонирхолтой байна. Иймээс дотор махыг хэрэглэгчийн энэ эрэлт хүсэлтэд нийцсэн байдлаар, үйлдвэрлэлийн аргаар боловсруулан шинэлэг байдлыг нь хадгалж, тусгай стандартын дагуу савлаж, хаяглаж, шошголон нийлүүлбэл хэрэглэгчид хүлээн авахад бэлэн байна.</p> <p>Хүүхэд, өсвөр насныхны хэрэглээ нийлээд 10 орчим хувь байгаа нь энэ насныханд чиглэсэн сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, тэдний таашаалд нийцсэн амт, чанартай шинэ бүтээгдэхүүнийг бий болгох шаардлага байгаа нь харагдаж байна.</p>

5.4.1.1. Регрессийн шинжилгээ

Малын дотор мах хүнсэндээ хэрэглэдэг хэрэглэгчийн ерөнхий шинжийг тогтоох зорилгоор ү1 хувьсагчаар хамааран хувьсагчаа сонгон магадлалын шугаман загварыг үнэлсэн үр дүнг авч үзье. Анхдагч үнэлгээгээр байршлаас бусад хувьсагчид статистикийн хувьд ач холбогдолтой гарсан тул байршлын үзүүлэлтүүдийг хасч, дахин тооцоолол хийв.

Хүснэгт 34. Дотор мах хэрэглэдэг хэрэглэгчийн ерөнхий шинжийг тогтоох шугаман загварын үнэлгээ

Хамааран хувьсагч: Дотор мах хүнсэндээ хэрэглэдэг эсэх- ү1						
Тайлбарлагч хувьсагч	Хувьсагч	Тэмдэглэгээ	Анхны үнэлгээ		Дахин үнэлгээ	
			Коэф	Стандарт хазайлт	Коэф	Стандарт хазайлт
	Тогтмол	c	0.833**	0.067	0.815**	0.064
	Нас	age	0.002**	0.001	0.002**	0.001
	Боловсрол	educ	-0.006**	0.003	-0.006**	0.003
	Ам бүл	family	0.011**	0.006	0.011**	0.006
	Орлого	income	0.038**	0.018	0.034**	0.017
	Аймгийн төв	Location1	-0.007	0.040		
	Бусад хот	Location2	0.004	0.090		
	Улаанбаатар	Location3	-0.026	0.028		
	Ач холбогдлыг дунд зэрэг мэддэг	Significance 1	0.065**	0.029	0.066**	0.029
	Ач холбогдлыг сайн мэддэг	Significance 2	0.065**	0.029	0.067**	0.029
	R ²		0.05		0.045	
	Регрессийн стандарт алдаа		0.172		0.172	
	F статистикийн утга		2.769		3.96	
	Дарвин-Ватсоны статистик		1.767		1.756	
*- 90 хувийн ач холбогдолтой, **-95 хувийн ач холбогдолтой, -99 хувийн ач холбогдолтой						

Хүснэгтийн үр дүнгээс харахад дотор мах хэрэглэх сэдэлд тухайн хэрэглэгчийн нас, ам бүл, орлого эерэг нөлөөтэй, боловсрол сөрөг байхаар харагдаж байна. Нарийвчилж авч үзвэл 25-45 настай буюу залуу, дунд насныхан асуулгад оролцогсдын дунд зонхилсон (63.7%) бөгөөд эдгээрийн ихэнх нь дээд боловсролтойн дээр хэрэглээ багатай байгаа нь дотор махны хэрэглээнд боловсрол сөрөг нөлөөтэй гэсэн дүн гарахад хүргэсэн байж болох юм. Ам бүл олонтой эсвэл нас ахисан хэрэглэгчид дотор махыг хэрэглэх хандлага илүү байна. Тухайн хэрэглэгч дотор махны хүнс тэжээлийн ач холбогдлыг мэдэхийн хэрээр хэрэглэх хандлага нь сайжирдаг. Хэрэглэгчийн хүнс тэжээлийн талаарх мэдлэг бусад хүчин зүйлсээс хамгийн хүчтэй нөлөөтэй байна. Цаашид хэрэглэгчийн дотор махны хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд түүний хүнс тэжээлийн ач холбогдлыг сурталчлан ойлгуулах тал дээр анхаарах хэрэгтэй юм.

Өмнө авч үзсэн шугаман хамаарлыг шугаман бус хамаарлаар баяжуулан ложит болон пробит загварыг үнэллээ. Эдгээр загварын үнэлгээнээс харахад мөн л нас, ам бүлийн тоо, орлого, хүнс тэжээлийн талаарх мэдлэг эерэг нөлөөтэй байгаа бол боловсрол сөрөг нөлөөтэй байгааг (гэхдээ энэ нь настай хамааралтай байж болохыг дахин сануулъя) баталгаажуулж байна.

Хүснэгт 35. Дотор мах хэрэглэдэг хэрэглэгчийн ерөнхий шинжийг тогтоох шугаман бус хамаарлын үнэлгээ

Хамааран хувьсагч: Дотор мах хүнсэндээ хэрэглэдэг эсэх- ү1						
Тайлбарлагч хувьсагч	Хувьсагч	Тэмдэглэгээ	Ложит загвар		Пробит загвар	
			Коэф	Стандарт хазайлт	Коэф	Стандарт хазайлт
	Тогтмол	c	0.065	2.381	0.488	1.067
	Нас	age	0.077***	0.030	0.035***	0.013
	Боловсрол	educ	-0.229*	0.139	-0.118*	0.065
	Ам бүл	family	0.361*	0.203	0.163*	0.093
	Орлого	income	1.121*	0.646	0.523*	0.295

	Ач холбогдлыг дунд зэрэг мэддэг	Significance1	1.381*	0.680	0.629*	0.338
	Ач холбогдлыг сайн мэддэг	Significance2	1.710*	0.750	0.764**	0.367
Макфаддены R ²			0.155		0.156	
Регрессийн стандарт алдаа			0.175		0.171	
LR статистикийн утга			22.033		22.245	
Лог үнэний хувь бүхий утга			-59.99		-59.884	
*- 90 хувийн ач холбогдолтой, **-95 хувийн ач холбогдолтой, ***-99 хувийн ач холбогдолтой						

Эдгээр хоёр загварын тайлбарлах чадвар бас ч муугүй байгааг тухайн загваруудын Макфаддены R квадратаас харж болно. Энэ хоёр загвараар хувьсагчуудын ахиу нөлөөг тооцоолж шугаман загвартай харьцуулсан үр дүнг дараах хүснэгтэд харуулав. Хүснэгт дэх мэдээллээс харахад 3 загвараар тооцоологдсон ахиу нөлөө ойролцоо байна. Гэхдээ дотор мах хэрэглэх шийдвэр нь шугаман бус хамаарлаар илүүтэй тайлбарлагдаж байна.

Хүснэгт 36. Ахиу нөлөөг 3 загвараар тооцоолсон харьцуулалт

Тайлбарлагч хувьсагчид	Магадлалын шугаман загвар -LPM	Ложит загвар - Logit model	Пробит загвар – Probit model
Тогтмол	0.815	0.002	0.030
Нас	0.002	0.002	0.002
Боловсрол	-0.006	-0.007	-0.007
Ам бүл	0.011	0.010	0.010
Орлого	0.034	0.032	0.032
Ач холбогдлыг дунд зэрэг мэддэг	0.066	0.039	0.039
Ач холбогдлыг сайн мэддэг	0.067	0.049	0.047

Бог малын дотор махны хэрэглээний давтамжид нөлөөлөх хүчин зүйлийг судлахын тулд ү2 хувьсагчаар хамааран хувьсагчийг сонгон авав. Энэ загвар нь олон хүчин зүйлийн регрессийн загвар юм. Өмнөх загварын үр дүнг илүү тодруулсан зарим хүчин зүйлийг тайлбарлая. Давтамжийн хувьд орлого өндөртэй хүмүүс илүү цөөн хэрэглэдэг бол сумын төвийн хэрэглэгчтэй харьцуулахад аймгийн төв, бусад том хотуудын хэрэглэгчид илүү олон давтамжтай хэрэглэдэг байна. Дотор махны хүнс тэжээлийн ач холбогдлыг сайн мэддэг байхын хэрээр олон давтамжтай хэрэглэхээр байна.

Хүснэгт 37. Бог малын дотор махны хэрэглээний давтамжид нөлөөлж буй олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ

Тайлбарлагч хувьсагч	Хувьсагч	Тэмдэглэгээ	Олон хүчин зүйлийн регрессийн загвар -ү2	
			Коэффициент	Стандарт хазайлт
	Тогтмол	c	51.765***	11.215
	Нас	age	-0.227**	0.126
	Хүйс	gender	6.429**	3.266
	Боловсрол	educ	-1.781***	0.539
	Ам бүл	family	0.416	0.949
	Орлого	income	-7.647***	2.975
	Аймгийн төв	Location1	19.293**	6.548
	Бусад том хот	Location2	13.179	14.848
	Улаанбаатар	Location3	1.859	4.656
	Ач холбогдлыг дунд зэрэг мэддэг	Significance1	5.790	4.754

	Ач холбогдлыг сайн мэддэг	Significance2	16.583**	4.835
R ²			0.15	
Регрессийн стандарт алдаа			28.30	
F статистикийн утга			8.51	
Дарвин-Ватсоны статистик			2.07	
** -95 хувийн ач холбогдолтой, *** -99 хувийн ач холбогдолтой				

Хүснэгт 38. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан дотор мах авдаг эсэх талаарх регрессийн шинжилгээ

	Хувьсагч	Тэмдэглэгээ	Олон хүчин зүйлийн магадлалын шугаман регрессийн загвар	
			Кoeffициент	Стандарт хазайлт
Тайлбарлагч хувьсагч	Тогтмол	c	-0.030	0.165
	Нас	age	0.002	0.002
	Хүйс	gender	-0.016	0.048
	Боловсрол	educ	-0.013*	0.008
	Ам бүл	family	-0.011	0.014
	Орлого	income	0.077*	0.044
	Аймгийн төв	Location1	0.264**	0.097
	Бусад том хот	Location2	0.493**	0.219
	Улаанбаатар	Location3	0.214***	0.069
	Ач холбогдлыг дунд зэрэг мэддэг	Significance1	0.124***	0.070
	Ач холбогдлыг сайн мэддэг	Significance2	0.146***	0.071
	R ²			0.05
Регрессийн стандарт алдаа			0.418	
F статистикийн утга			2.53	
Дарвин-Ватсоны статистик			1.92	
*-90 хувийн ач холбогдолтой** -95 хувийн ач холбогдолтой, ***-99 хувийн ач холбогдолтой				

Регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад үйлдвэрийн аргаар боловсруулсан дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг өндөр орлоготой, аймгийн төв, Улаанбаатар, хот суурин газрын хүнс тэжээлийн ач холбогдлыг сайн мэддэг хүмүүс хэрэглэдэг хандлага ажиглагдаж байна.

Малчид зах зээлд мал, махаа хэрхэн нийлүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлийн шинжилгээг магадлалын шугаман загвараар гүйцэтгэв. Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 39. Малчид зах зээлд мал, махаа нийлүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлийн шугаман загварын шинжилгээ

Тайлбарлагч хувьсагч	Хувьсагч	Тэмдэглэгээ	Үнэлгээ	
			Коеф	Стандарт хазайлт
Тайлбарлагч хувьсагч	Тогтмол	c	0.499***	0.189
	Нас	age	0.006*	0.004
	Орлого	income	0.172*	0.101
	Малын тоо	Number	-0.0003**	0.0001
R ²			0.06	
Регрессийн стандарт алдаа			0.398	
F статистикийн утга			2.206	
Дарвин-Ватсоны статистик			1.734	
*-90 хувийн ач холбогдолтой** -95 хувийн ач холбогдолтой, ***-99 хувийн ач холбогдолтой				

Цөөн тооны малтай, ахимаг насны, орлого өндөртэй малчид ихэвчлэн малыг амьдаар нь болон уламжлалт аргаар төхөөрч зах зээлд нийлүүлдэг байна. Харин олон малтай, залуу малчид сумын “бой” болон үйлдвэрт төхөөрүүлж нийлүүлдэг бололтой. Зах зээлд нийлүүлж буй малын тоо нь тухайн малчны

мал малласан жил болоод малын тооноос шууд хамаарч байна. Үүнийг үз хувьсагчаар хамааран хувьсагчаар сонгон хийсэн олон хүчин зүйлийн регрессийн загвараас харж болно.

Хүснэгт 40. Зах зээлд нийлүүлж буй малын тоо малчны мал малласан жил болоод малын тооноос хамаарах олон хүчин зүйлийн регрессийн загвар

Тайлбарлагч хувьсагч	Хувьсагч	Тэмдэглэгээ	Олон хүчин зүйлийн регрессийн загвар -үз	
			Коэффициент	Стандарт хазайлт
Туршлага буюу мал малласан жил	number	exper	1.536**	0.676
			0.135***	0.029
R ²			0.20	
Регрессийн стандарт алдаа			89.63	
Дарвин-Ватсоны статистик			2.049	
** -95 хувийн ач холбогдолтой, *** -99 хувийн ач холбогдолтой				

Регрессийн шинжилгээний дүн шинжээчийн оюун дүгнэлттэй ойролцоо буюу зарим тохиолдолд давхцаж байгаа нь бог малын дотор махны хэрэглээний зах зээлийн судалгаа нь өндөр магадлалтай болохыг харуулж байна.

5.4.1.2. Асуумж судалгаанаас хийсэн дүгнэлт

Ажлын даалгаварт заасан хэрэглэгчийн тоонд асуумж судалгаанд оролцсон хүний тоо ($n < 1000$) хүрээгүй (хот хөдөө нийлээд 700 гаруй хүн) боловч оролцогчийн тоо нэмэгдсэнээр хэрэглэгчийн зан төлөвийн талаар дүгнэлт, мэдээлэл энэ судалгааны дүнгээс ноцтой зөрөхгүй байхаар байна.

Судалгаагаар Улаанбаатар хот болон зарим суурин газрын хүн амын дундах дотор мах, дайврын хэрэглээний ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон. Бог малын дотор махны хамгийн том зах зээл нь Улаанбаатар хот болох нь тогтоогдсон. Үйлдвэрийн аргаар боловсруулсан дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг аймгийн төв, Улаанбаатар, хот суурин газар амьдардаг, дотор махны хүнс тэжээлийн ач холбогдлыг сайн мэддэг, өндөр орлоготой хүмүүс хэрэглэдэг хандлага ажиглагдаж байна.

Дотор махыг хэрэглэгчид тогтмол бус, бага хэрэглэж байгаа нь түүхий эдийн боловсруулалтын арга технологи, чанарын доголдол, ариун цэвэр, аюулгүй байдлын баталгаагүй (46.8%) байдалтай холбоотой байна. Давтамжийн хувьд орлого өндөртэй хүмүүс илүү цөөн, сүмн төвийн хэрэглэгчтэй харьцуулахад аймгийн төв, бусад том хотуудын хэрэглэгчид илүү олон давтамжтай хэрэглэдэг.

Хэрэглэгчдийн бараг тал хувь нь (46.3%) дотор махыг эрүүл мэндээ дэмжих зорилгоор хэрэглэдэг гэсэн нь богийн, ялангуяа, хонины дотор махны шимт чанарыг хэрэглэгчид сайн мэддэг гэсэн ойлголт өгч байна. Тухайн хэрэглэгч дотор махны хүнс тэжээлийн ач холбогдлыг мэдэхийн хэрээр хэрэглэх хандлага нь сайжирдаг байна. Энэхүү хүнс тэжээлийн талаарх мэдлэг бусад хүчин зүйлсээс хамгийн хүчтэй нөлөөтэй байна.

Дотор мах хэрэглэх сэдэлд тухайн хэрэглэгчийн нас, ам бүл, орлого эерэг нөлөөтэй бол харин боловсрол өндөрсөхийн хэрээр хэрэглэх магадлал нь багасдаг зүй тогтол (гэхдээ энэ хандлага боловсролоос илүүтэй настай хамааралтай байж болно) ажиглагдаж байна. Ам бүл олонтой эсвэл нас ахисан хэрэглэгчид дотор махыг хэрэглэх хандлага илүү байна. Дотор махны гол хэрэглэгч нь нас тогтсон болон ахимаг насныхан байгаа тул хүүхэд, өсвөр насны залуучуудад чиглэсэн маркетингийн арга хэмжээ авах, шинэ, инновацлаг бүтээгдэхүүнийг санал болгох шаардлагатай.

Асуумжид оролцогсдын 50 гаруй хувь нь хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэдэг гэсэн нь дотоодод ийм төрлийн бүтээгдэхүүний зах зээл байгааг харуулна. Тэр тусмаа, Монголд үйлдвэрлэсэн ийм бүтээгдэхүүнийг хэрэглэхэд ихэнх хэрэглэгч бэлэн байна.

Малчин өрхийн тухайд, малаа зах зээлд борлуулах, мах бэлтгэх, хувийн хэрэгцээнд хэрэглэх талаарх шийдвэрийг голчлон өрхийн тэргүүн-эрэгтэйчүүд гаргадаг. Ихэнх малчин өрх сарын 500-800 мянган төгрөгийн орлоготой байгаа нь сард 5-10 бог мал зах зээлд нийлүүлдэг байж болохыг харуулж байна. 301-ээс дээш толгой бог малтай өрх зах зээлд мал нийлүүлэх чадвартай байна. Цөөн тооны малтай, ахимаг насны, орлого өндөртэй малчид ихэвчлэн малыг амьдаар нь болон уламжлалт аргаар төхөөрч зах зээлд нийлүүлдэг байна. Харин олон малтай, залуу малчид сумын “бой” болон үйлдвэрт төхөөрүүлж нийлүүлдэг бололтой. Зах зээлд нийлүүлж буй малын тоо нь тухайн малчны мал малласан жил болоод малын тооноос шууд хамаарч байна.

Асуумжид оролцсон малчдын 55% нь жилд 20 хүртэл бог мал хүнсэндээ хэрэглэдэг гэснээс үзвэл нийт малчин өрх жилдээ 3,5 сая орчим бог мал хүнсэндээ хэрэглэдэг байх магадлалтай. Үүнээс 2.0 сая нь хонь, 1.6 сая нь ямаа байх боломжтой. Энэ нь жилдээ 35.0 мянган тонн богийн дотор мах зах зээлд нийлүүлэгдэх боломжтойг харуулж байна.

5.4.2. Олон нийтийн мэдээллийн сүлжээгээр явуулсан тандан судалгаа

Өмнө өгүүлсэн асуумж судалгаанаас гадна “Шинэ өсөлт” болон “Шинэ малчин” сэтгүүлийн редакция хамтран “Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний хэрэглээ, зах зээл, экспортыг нэмэгдүүлэх боломж” сэдвээр нийгмийн хандлага, хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг тандан судалсан болно.

Нийгмийн сүлжээнд өрнүүлсэн дотор мах, дайвар бүтээгдэхүүний талаарх өндөр үзэлтэй видеонууд сурвалжилгуудын доор ирүүлсэн сэтгэгдлийг агуулгаар нь ангилж харвал:

- Монголчууд тэр дундаа малчид цамаан, залхуу болсон байна (25 хувь)
- Манайхаас бусад оронд малынхаа дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж, олон төрлийн хоол хүнс хийдэг (15 хувь)
- Цэвэрхэн бэлтгэсэн дотор мах, дайвар бүтээгдэхүүн үнэтэй байсан ч авна. Толгой шийрийг нь хуйхалсан байвал сайн (10 хувь)
- Хүнсний захуудад зарж байгаа дотор мах хэтэрхий бохир, заваан байдаг. Түүнээс дотор мах идэхийг хүсдэг (10 хувь)
- Дотор мах, дайвар түүхий эдийг ашиглалгүй хаядаг, байгаль орчны бохирдол үүсгэж байгаа нь буруу,
- Аймаг, сум, багт мал төхөөрөх цех, үйлдвэр олныг бий болгомоор байна (40 хувь) гэсэн байна.

Мөн Улаанбаатар хотын томоохон худалдааны төвүүдээр үйлчлүүлж буй хэрэглэгчдээс аман асуулга авахад дотор мах хэрэглэх дургүй гэх хүн тааралдаагүй. Харин цэвэрхэн бэлдсэн, бага хэмжээтэйгээр, боловсон савлагаатайгаар худалдаанд элбэг байвал өвлөөс бусад улиралд хүссэн үедээ авч хэрэглэж байна гэж ихэнх нь хариулжээ.

БҮЛЭГ 6. ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

6.1. Олон улсын зах зээлийн тойм

Энэхүү судалгаанд интернэтийн нээлттэй эх үүсвэрт байгаа “Эдийн засгийн төлөв байдлын ажиглалтын төв”-ийн (Observatory of Economic Complexity) 2020-2022 оны мэдээллүүдийг ашиглав. Барааны ангиллыг HS 0206 (Edible offal) гэсэн кодоор түүвэрлэн авлаа. HS Code 0206 ангилалд үхэр, гахай, хонь, ямаа, адуу, илжиг, луус, одой морь зэрэг амьтдын шинэ, хөргөсөн эсвэл хөлдөөсөн хүнсний дотор мах багтдаг байна.

2021 онд хүнсний зориулалттай дотор мах, дайвар бүтээгдэхүүний олон улсын худалдааны 87.3 хувийг үхэр, гахайн шинэ болон хөлдөөсөн дотор мах, дайвар бүтээгдэхүүн эзэлж, 8.36 тэрбум ам.долларын худалдаа хийгдсэн байна.

Дэлхийн хүнсний дотор махны зах зээлийн хэмжээ 2030 он гэхэд 58.2 тэрбум долларт хүрч, таамагласан хугацаанд CAGR 4.7%-иар өсөх төлөвтэй байна. 2022 онд дотор махны зах зээл 13,319.2 кило тн-д хүрч, 2.3%-ийн (2019-2022) өсөлттэй гарсан байсан.

Амьтныг толгойноос нь сүүл хүртэл идэх үзэл санаа нь хог хаягдал болж болзошгүй бүрэлдэхүүн хэсгүүдийг хоол хийхэд ашиглах явдал юм. Амьтан бүр төрөл бүрийн дайвар гаргадаг. Тиймээс нийлүүлэлт илүү өргөнтэй болохоор дотор мах, дайварын үнэ хямд байдаг. Нөгөө талаар амьтны махыг ашиглах зорилгоор агнах, төхөөрөх үед түүний янз бүрийн хэсгүүд ашиглалтгүй үлддэг.

Хүнсний зориулалттай дотор мах, дайварын олон улсын худалдаанд 1.88 тэрбум ам.долларын экспортын борлуулалтаар АНУ тэргүүлж байгаа бол 2.85 тэрбум ам.долларын худалдан авалтаар БНХАУ толгой импортлогч болсон байна.

Хүнсний зориулалттай дотор мах, дайвар бүтээгдэхүүний олон улсын худалдаанд эхний 5 байр эзэлж буй экспортлогч орнуудын байршлыг авч үзвэл Хойд Америкийн хоёр, Европын хоёр, Далайн орнуудаас нэг орон байна.

Харин импортын хувьд эхний 5 байр эзэлж буй орнууд дотор Ази тивийн гурван орон, Өмнөд, Хойд Америк тивээс тус бүр нэг орон байна. Үүнээс, Ази тивийн гурван импортлогч орны худалдан авалтын нийлбэр дүн 4.7 тэрбум ам. доллар буюу, нийт худалдааны 48.7 хувийг эзэлсэн нь мал, амьтны гаралтай хүнсний зориулалттай дотор мах, дайвар бүтээгдэхүүний хэрэглээгээр Азийн зах зээл томоохон байр суурь эзэлж буйг харуулж байна.

2022 онд дээрх ангиллын дотор махны зах зээлийн нийт хэмжээ 9.32 тэрбум ам. долларт хүрч дэлхийн хамгийн их худалдаалагдсан 1218 барааны 400-д бичигдэж дэлхийн нийт худалдааны 0.039% болсон байна.

2022 онд дэлхийн дотор махны борлуулалтын 21.25% (1.98 тэрбум ам. доллар) -ийг АНУ, импортын 29.18 % (2.72 тэрбум ам. доллар)-ийг БНХАУ тус, тус эзэлсэн байна.

Дотор махны гол экспортлогчид нь АНУ (2,72 тэрбум ам. доллар), Испани (877.0 сая ам. доллар), Австрали (736.0 сая ам. доллар), Нидерланд (701 сая ам. доллар), Канад (569 сая ам. доллар) байсан бол гол импортлогчид нь Хятад (2.72 тэрбум ам. доллар), Япон (1.02 тэрбум ам. доллар), АНУ (464 сая ам. доллар), Хонг Конг (439 сая ам. доллар), Мексик (428 сая ам. доллар) улсууд байна.

Хүснэгт 41. Дотор мах, дайвар түүхий эд хамгийн их экспортлогч болон импортлогч 5 орны жагсаалт



Үзүүлэлт	Улсын нэр	Үнийн дүн (тэрбум ам.дол)	Нийт худалдаанд эзлэх хувь
Толгой 5 экспортлогч	АНУ	1.88	19.6
	Испани	1.01	10.5
	Австрали	0.8	8.35
	Нидерланд	0.675	7.05
	Канад	0.553	5.77
Дүн		4.918	51.3
Толгой 5 импортлогч	БНХАУ	2.85	29.7
	Япон	0.985	10.3
	Хонг Конг	0.834	8.71
	АНУ	0.526	5.49
	Мексик	0.456	4.76
Дүн		5.651	59.0

6.2. Хүнсний дотор мах, дайврын бүс нутгийн зах зээл: Гол баримтууд

Монгол Улсын дотор махны экспортын хувьд сонирхож байгаа зах зээл нь БНХАУ, Өмнөд Солонгос болон Персийн булангийн орнуудаас гадна өнөөгийн байдлаар манай орноос бод, богийн мах, дотор мах импортлож байгаа ОХУ болон Ази, Зүүн өмнөд Азийн зарим орныг хамарч байна.

Хүснэгт 42. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврыг бүс нутгийн зах зээлд нийлүүлэх газар зүйн байршил:

Улсаар

Гол зах зээлийн орнууд			
Зүүн Ази, өмнөд Азийн орнууд:		Ойрх дорнод, дунд болон төв Азийн орнууд	
БНХАУ			Булангийн орнууд
БНСУ			Саудын Арав
Япон			Иран
Вьетнам			АНЕУ
Лаос			Казахстан
Индонез			Узбекстан
Филлипин			Киргиз
Малайз			Турк
Хонг Конг			ОХУ

Монгол Улсын зах зээлийн зорилтот бүсэд хамрагдсан орнуудын дотор махны импортын мэдээллийг дээр дурьдсан интернетийн нээлттэй эх үүсвэр (Observatory of Economic Complexity)-ээс түүвэрлэн авлаа.

6.2.1. БНХАУ-ын хүнсний дотор мах, дайврын зах зээл

Хүснэгт 43. БНХАУ-ын 2020-2022 онд импортоор авсан дотор махны үнийн дүн /сая ам. доллар/, дотор махны импортод эзлэх хувь, экспортлогч орны нэрээр

№	Импортлогч орны нэр	Экспортлогч орон	2020		2021		2022	
			Дүн	%	Дүн	%	Дүн	%
1	БНХАУ	АНУ	456.0	17.2	665.0	23.58	753.0	27.7
2		Испани	552.0	20.83	655.0	23.22	509.0	18.7
3		Дани	288.0	10.86	346.0	12.27	317.0	11.7
4		Нидерланд	235.0	8.87	254.0	9.00	279.0	10.2
5		Франц	174.0	6.56	197.0	6.99	191.0	7.02
6		Уругвай	105.0	3.96	190.0	6.74	175.0	6.42
7		Их Британи	102.0	3.85	126.0	4.47	132.0	4.86
8		Чили	87.5	3.31	85.4	3.03	74.7	2.75
9		Бразили	27.1	1.02	47.9	1.70	64.8	2.3
10		Канад	130.0	4.91	32.9	1.17	52.0	1.91
11		Шинэ Зеланд	43.5	1.65	47.4	1.68	32.9	1.64
12		Австрали	32.7	1.24	32.1	1.14	26.7	0.98
13		Бусад	417.2	15.74	141.3	5.01	112.9	3.82
Нийт дүн			2650	100.0	2820	100.0	2720.0	100.0

БНХАУ-ын дотор махны импорт тогтвортой байгаа бөгөөд гол экспортлогч нь АНУ(27.7%), Испани (18.7%), Дани (11.7%), Нидерланд (10.2%) байна (хүснэгт 36). Монгол Улс нь БНХАУ-тай хил залгаа оршдог хөршийн хувьд техникийн болон мал эмнэлгийн ариун цэвэр, хорио цээрийн саадуудаа арилгаж чадсан тохиолдолд өрсөлдөх боломж харагдаж байна.

6.2.2. БНСУ-ын хүнсний дотор мах, дайврын зах зээл

Хүснэгт 44. БНСУ-ын 2020-2022 онд импортоор авсан дотор махны үнийн дүн /сая ам. доллар/, дотор махны импортод эзлэх хувь, экспортлогч орны нэрээр

№	Импортлогч орны нэр	Экспортлогч орон	2020		2021		2022	
			Дүн	%	Дүн	%	Дүн	%
1	БНСУ	Австрали	111.0	44.2	130.0	44.98	138.0	40.95
2		АНУ	77.0	30.7	64.8	22.42	76.5	22.70
3		Шинэ Зеланд	20.7	8.25	25.1	8.69	26.5	7.86
4		Испани	5.59	2.23	16.6	5.74	6.35	1.88
5		Канад	9.44	3.76	16.1	5.57	14.6	4.33
6		Австри	0.79	0.31	4.97	1.72	3.36	1.00
7		Нидерланд	2.08	0.83	4.95	1.71	7.45	2.21
8		Хонг Конг	5.89	2.35	4.95	1.71	46.8	13.89
9		Франц	3.76	1.5	4.85	1.68	1.36	0.40
10		Мексик	2.22	0.88	2.78	0.96	3.36	1.00
11		Их Британи	0.95	0.38	2.68	0.93	2.09	0.62
12		Бельги	-		0.517	0.18	3.3	0.98
13		Бусад	11.58	4.61	10.7	3.71	7.33	2.18
Нийт дүн			251.0	100.0	289.0	100.0	337.0	100

БНСУ-ын дотор махны импорт өсөлттэй байгаа бөгөөд гол экспортлогч нь Австрали(40.95%), АНУ (22.7%), Хонг Конг (13.89%), Шинэ Зеланд (7.86%) байна (хүснэгт 34). Энэ зах зээл дээр Монгол Улс шинэ хөргөсөн болон хөлдөөсөн дотор мах, боловсуулаагүй дайвар бүтээгдэхүүнээр өрсөлдөхөд бэрхшээлтэй байж болох юм.

6.2.3. Персийн булангийн болон бусад сонирхож байгаа орнуудын хүнсний дотор мах, дайврын зах зээл

Хүснэгт 45. Персийн булангийн болон бусад сонирхож байгаа орнуудын 2020-2022 онд импортоор авсан дотор махны үнийн дүн /сая ам. доллар/, экспортлогч орнуудын нэрс

№	Импортлогч орны нэр	2020		2021		2022	
		Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
1	Саудын Араб	19.2	0.95	19.7	0.36	23.7	0.602
2	АНЭУ	18.5	0.47	24.1	7.06	21.1	4.27
3	Кувейт	3.59	0.49	6.84	0.13	7.18	0.901
4	Катар	3.79	0.01	4.92	0.02	6.37	1.17
5	Оман	1.75	0.12	1.06	0.03	1.66	0.693
6	Бахрейн	2.27	-	3.01	-	-	-
7	Иран	0.04	3.99	3.99	3.27	0.104	2.43
8	Ирак	0.93		2.53	-	-	-
9	ОХУ	114.0	68.5	166.0	68.9	151.0	32.2
9	Казахстан	2.7	0.42	3.89	0.03	2.25	0.193
10	Узбекистан	-	-	-	-	1.8	1.23
11	Филлипин	155.0	0.04	308.0	0.09	399.0	0.0363
12	Вьетнам	150.0	19.1	317.0	7.78	171.0	26.7
13	Индонез	109.0	0.05	178.0	0.03	167.0	95.8
14	Турк	0.66	10.2	0.54	13.4	0.921	5.77

Персийн булангийн болон бусад сонирхож байгаа орнуудын тухайд дотор махны импорт Саудын Араб, Кувейт, Катар, Казахстан, Филиппин зэрэг орнуудад өсөлттэй, Вьетнам, Индонез, ОХУ зэрэг орнуудад тогтвортой байна (хүснэгт 38). Монгол Улсын тухайд транзит тээврийн асуудлыг БНХАУ-тай тохиролцож чадсан нөхцөлд энэ дах зээлд нэвтрэх боломж байж болох юм.

6.3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын экспорт, импортын өнөөгийн байдал

Статистикийн хорооны дүнгээр Монгол Улс 2023 онд 19,6 сая мал зах зээлийн эргэлтэд оруулсан бөгөөд 526,6 мянган тн мах үйлдвэрлэсэн: үүнээс адууны мах 81,2 мянган тн, үхрийн мах 131,5 мянган тн, тэмээний мах 11,2 мянган тн, хонины мах 193,0 мянган тн, ямааны мах 109,7 мянган тонн-ыг тус тус үйлдвэрлэсэн байна. Монгол улс 2021 онд 102,177 тонн шинэхэн, хөргөсөн болон хөлдөөсөн цувдайг боловсруулсан бөгөөд үүнд хонины (35%), ямааны (30%), үхрийн (25%) цувдай зонхилж байна (НҮБ-ын ХХААБ).

Хүнсэнд төхөөрсөн малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнээс 2023 онд 1.7 мянган тн дайвар бүтээгдэхүүн экспортолсон байна. Үүнээс 1001.2 тн дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг Хонконг, Вьетнам, Казахстан, Армен, Япон улсад, бог малын 699.0 тн өлөн гэдсийг Австри, Герман, Итали, Египет, Швейцар, Нидерланд, Хонконг, Узбекистан, Япон улсад тус тус экспортолсон байна.

Хүснэгт 46. Монгол Улсаас 2020-2023 онд экспортолсон дотор мах дайвар бүтээгдэхүүний үнэ, мян. ам. доллар; хэмжээ, тонн

2020 он		2021 он		2022 он		2023 он	
Хэмжээ	Үнэ	Хэмжээ	Үнэ	Хэмжээ	Үнэ	Хэмжээ	Үнэ
2019	10106.9	1970	16286.4	1196	16493.3	1104	7992.2

Эх сурвалж: ҮСХ

Дайвар бүтээгдэхүүний импортын хувьд ихэнх нь гахайн өөх, элэг, хүйх зэрэг бүтээгдэхүүн байна. 2023 онд 230,602 кг дайвар бүтээгдэхүүн импортлогдсон байна.

Хүснэгт 47. Монгол Улсад 2020-2023 онд импортлогдсон дотор мах, дайвар бүтээгдэхүүний үнэ /мян. ам.доллар/;
хэмжээ /тонн/

2020 он		2021 он		2022 он		2023 он	
Хэмжээ	Үнэ	Хэмжээ	Үнэ	Хэмжээ	Үнэ	Хэмжээ	Үнэ
438.9	426708.0	570.1	491811.0	414.0	452297.0	230.6	188762.0

Эх сурвалж:УСХ

Монгол улс, 2021 онд 934 мянган ам.долларын экспорт, 426 мянган ам.долларын импорт хийжээ.

Хүснэгт 48. Малын дотор мах, дайварын экспорт хийдэг компаний нэр, бүтээгдэхүүний нэр төрөл

№	Экспортлогч компаний нэр	Дайвар бүтээгдэхүүний нэр төрөл	Импортлогч улс
1	Аеиа ХХК ГХО-тай	Богийн өлөн гэдэс	Итали, Ливан
2	Азийн алтан од мийт ХХК	Үхрийн гэдэс, хонины дайвар мах, адууны дайвар бүтээгдэхүүн, Адууны нарийн гэдэс, хонины гүзээ	Хонг Конг, БНХАУ
3	Алижан ХХК	Адууны нарийн гэдэс	Казахстан ХХК
4	Ах дүү хос эрдэнэ ХХК	Үхрийн дайвар бүтээгдэхүүн, адууны нарийн гэдэс, хонины давсалсан гүзээ, хонины бөөр, хонины гүзээ, Адууны умс, Үхрийн сархинаг	Хонг Конг, БНХАУ, БНАСАУ, Вьетнам
5	Баян ньуу фүүд сентури ХХК	Үхрийн дайвар бүтээгдэхүүн, хонь, ямааны дайвар бүтээгдэхүүн, адууны дайвар бүтээгдэхүүн	Хонг Конг, БНХАУ, Киргизстан, Вьетнам
6	ББ экспресс ХХК	Богийн өлөн гэдэс	Австри, Герман, Испани, Япон
7	Болор - Оч ХХК	Богийн өлөн гэдэс	Герман, Япон
8	Болорхуяг ХХК	Үхрийн сархинаг	Хонг Конг, БНХАУ
9	Голден кофе ХХК	Богийн өлөн гэдэс	Египет
10	Голденгоат ХХК	Богийн өлөн гэдэс	Япон, Турк
11	Голс ХХК	Адууны нарийн гэдэс	Узбекистан
12	Гуфран энд гуна ХХК	Богийн өлөн гэдэс	Египет,Итали, Ливан
13	Дер баг ет ХХК	Хонины ходоод, хонины элэг, Богийн өлөн гэдэс	Турк
14	ЕЕСС ХХК	Богийн өлөн гэдэс	Швейцарь
15	Жи Эй атлантик ХХК ГХО-тай	Богийн өлөн гэдэс	Австри, Герман
16	Интердарм-Улаанбаатар ГХО ХХК	Богийн өлөн гэдэс	Герман, Нидерланд Франц,Нидерланд
17	Интернешнл халал мийт комплекс монголиа ХХК	Хонины дайвар бүтээгдэхүүн	Азербайжан Иран
18	Кинг Би Эй ХХК	Өлөн гэдэс дайвар мах	Узбекистан улс
19	Кингерфреш ХХК	Богийн өлөн гэдэс Адууны хэл, адууны элэг	Франц, Япон Польш
20	Мах-Экспорт ХХК	Адууны дайвар	Казахстан
21	Мийт партнер ХХК	Үхрийн дайвар мах	Армен
22	Монголиан мийт экспорт центр ХХК	Богийн өлөн гэдэс, хонины дайвар Үхрийн сархинаг,	БНСУ, Турк, Узбекистан
23	Мөнх дөлгөөн тэнгис ХХК	Богийн өлөн гэдэс	Франц
24	Нова виртүброс ХХК	Богийн өлөн гэдэс	Турк
25	Номхонтэнгис ГХО ХХК ХХК /ГХО/	Адууны нарийн гэдэс	Хонг Конг, БНХАУ
26	Нью-Оникс ХХК	Богийн өлөн гэдэс	Австри

27	Оргил евро мон миит ХХК	Үхрийн гүзээ, адууны нарийн гэдэс, адууны үмс, адууны чив, дайвар мах, хонины давсалсан гүзээ	Хонг Конг, БНХАУ Вьетнам
28	ПРЕКОМ ХХК	Бүдүүн гэдэс, адууны Дайвар мах, адууны	Япон
29	Това бридж ГХО ХХК	Адууны элэг	Япон
30	Хангай мийт ХХК	Үхрийн гэдэс	Хонг Конг, БНХАУ
31	Чойбалсан групп ХХК	Богийн өлөн гэдэс	Узбекистан улс
32	Эмээлт эрдэнэ трейд ХХК	Хонины гүзээ, дайвар бүтээгдэхүүн	Вьетнам
33	Эххөгжил ХХК /ГХО/	Ямааны дайвар бүтээгдэхүүн, Адууны дайвар мах	Хонг Конг, БНХАУ

Эх сурвалж: ҮСХ

6.4. Монгол Улсын хүнсний дотор мах, дайварын экспортыг нэмэгдүүлэх гарц, боломж

Монгол Улсын дотор мах, дайвар бүтээгдэхүүний стандартын ангилал олон улсын ангиллаас нэлээд зөрүүтэй байна. Олон улсын ангиллаар, юуны өмнө малаас гарч байгаа бүх дайврыг ашиглалтын байдлаар нь хүнсэнд хэрэглэдэг, хүнсэнд хэрэглэдэггүй, хаягдал гэж 3 ангилдаг байна. Хүнсэнд хэрэглэдэг дайврыг улаан, цагаан, бараан гэж 3 ангилдаг бол хүнсэнд хэрэглэдэггүй дайврыг дахин боловсруулдаг, хаягдал болгодог гэж хоёр хуваадаг. Гол ялгаатай хэсэг нь хүнсний бараан дайварт толгой, хүзүү, шийр, шилбийг хамруулж авч үздэг нь сонирхол татаж байна.

Цус, эвэр, туурай, булчирхай, яс, өөх, арьс, ширийг малын тэжээл үйлдвэрлэл, бүс бараа, гоо сайхан эмийн үйлдвэрлэлд ашигладаг бол ходоод гэдэсний агуулагдахуун, сэвс, өвдөл цөвдөл, хээл зэргийг био хий, тариалангийн бордоо, малын тэжээл үйлдвэрлэлд ашигладаг ажээ. Ийм байдлаар мал төхөөрөх явцад гарч байгаа бүх дайврыг ямар нэг байдлаар ашиглаж, үүсэж буй хог хаягдлыг багасгахын зэрэгцээ, өртөг шингээн ашиг орлого олдог байна.

Хүснэгт 49. Мал төхөөрөх үйлдвэрээс гарч байгаа дайвар бүтээгдэхүүн, түүнийг ашиглах чиглэлээр нь ангилсан байдал (олон улсын)

Эх үүсвэр	Ангилал	Ашиглалт			
Мал	Өвчсөн гулууз мах	Хүн амын хүнсэнд			
	Дайвар бүтээгдэхүүн	Хүнсэнд хэрэглэдэг	Улаан дайвар	Элэг, бөөр, зүрх, хэл, мөгөөрсөн хоолой, уушги, дэлүү	Хүн амын хүнсэнд
			Цагаан дайвар	Ходоод, гэдэс, багалзуур	
			Бараан дайвар	Толгой, хүзүү, шийр, шилбэ	
	Дайвар бүтээгдэхүүн	Хүнсэнд хэрэглэдэггүй	Дахин боловсруулдаг	Цус, туурай, эвэр, булчирхай, яс, өөх, арьс шир	Малын тэжээл үйлдвэрлэл, даавуу, гоо сайхан, эмийн үйлдвэрлэл
			Хаях	Ходоод гэдэсний агуулагдахуун, сэвс, өвдөл цөвдөл, ураг	Био хий, газар тариалангийн бордоо, малын тэжээл үйлдвэрлэл
Гологдол хэсэг	Хаях		Ходоод гэдэсний агуулагдахуун, сэвс, өвдөл, цөвдөл, ураг	Био хий, газар тариалангийн бордоо, малын тэжээл үйлдвэрлэл	

6.5. Хүнсний дотор мах, дайврын экспортод гарч байгаа шинэ хандлага, туршлага

Манай улсын хувьд аль ч төрлийн дотор мах, дайврыг их хэмжээгээр тасралтгүй экспортлох боломж, нийлүүлэлтийн чадавх байхгүй юм. Энэ тохиолдолд зах зээлийн судалгааг нарийн нягт явуулсны үндсэн дээр тухайн зах зээл дээрх тусгай эрэлт хэрэгцээтэй “niche” зах зээл буюу онилсон хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүнийг бага хэмжээгээр, тасалдалтайгаар нийлүүлдэг байх нь илүү зохимжтой юм. Ийнхүү бага хэмжээгээр экспорт хийх нь бүтээгдэхүүний чанарт илүү анхаарах боломж олгохын зэрэгцээ төлбөр тооцоо харьцангуй богино хугацаанд хийгдэх, эргэлтийг хурдасгах давуу талтай юм.

6.6. Дотор мах, дайвар түүхий эдийг ашиглах бусад чиглэл

Дотор махны ашиглалтыг сайжруулах, экспортлоход чухал нөлөө үзүүлэх нэг хүчин зүйл нь дотор мах, дайврын физик, химийн шинж чанар, аюулгүйн үзүүлэлт, хэрэглээний онцлогийг зөв ойлгох, зөв технологи сонгох, дэвшилтэт арга барилд суралцах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Дайвар бүтээгдэхүүнийг ихэвчлэн техникийн зориулалттайгаар ашиглах хандлага давамгайлж байгаа бөгөөд эдгээрийн дотроос кератин, коллаген уураг онцгой чухал түүхий эд юм. Тухайлбал, кератин болон коллагеныг хүнс, бүс бараа, эрүүл мэнд, гоо сайхан, гал түймэртэй тэмцэх гэх мэт янз бүрийн зориулалтаар өргөн хүрээнд тухий эд болгон ашиглаж байна. Кератин, коллагенаас гадна өлөн гэдэс, давсаг зэрэг салслаг дайвруудыг хүнсний бүтээгдэхүүний бүрхүүл болон хүн, мал эмнэлгийн салбарт бас олон янзаар ашиглаж ирсэн уламжлалтай.

Иймд дотор мах, дайврыг хүнснээс бусад зориулалтаар ашиглах үйлдвэрлэл хөгжсөн орнуудын туршлагыг судлах, тэдний зохицуулалтын талаарх онцлогийг ойлгох нь дотор мах, дайврын ашиглалт, зах зээлийг тэлэхэд чухал ач холбогдолтой болох нь дараах мэдээллүүдээс харагдаж байна.

6.7. Гэрийн тэжээвэр амьтны хоол, мал, амьтны тэжээлийн бэлдэц (HS Code 2309)

2021 онд гэрийн тэжээвэр амьтны хоол ба мал амьтны тэжээлийн бэлдцийн олон улсын худалдаа 40.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх жилээс 17.8 хувиар өссөн байна. Энэ төрлийн бүтээгдэхүүн дэлхийн нийт худалдаанд 0.19 хувийг эзэлж, худалдааны эрэмбээр 110-р байранд оржээ.

Гэрийн тэжээвэр амьтны хоолны хувьд 4.43 тэрбум ам.долларын экспортын борлуулалт хийж, 3.19 тэрбум ам.долларын импортын худалдан авалт хийсэн ХБНГУ үг жагсаалтыг тэргүүлсэн байна.

Олон улсын худалдаанд гэрийн тэжээвэр амьтны хоолны 50.3 хувийг 20.6 тэрбум ам.долларын худалдааны эргэлттэй муур, нохойн хоол эзэлж байгаа бол, 49.7 хувь буюу 20.3 тэрбум ам.долларын худалдааны эргэлтийг гэрийн мал, амьтны тэжээлийн бэлдэц эзэлж байна.

2021 оны олон улсын худалдаанд эхний байранд орсон толгой 5 импортлогчдын дөрөв нь нийт 8.62 тэрбум ам. долларын худалдан авалт хийсэн Европын улс орнууд байгаа бөгөөд худалдааны нийт эргэлтийн 21 хувийг эзэлж байна.

Хүснэгт 50. Гэрийн тэжээвэр амьтадын хоол тэжээлийн бэлдэц хамгийн ихээр экспортолсон болон импортолсон 5 улсын жагсаалт

Үзүүлэлт	Нэр төрөл	Үнийн дүн (тэрбум ам.дол)	Нийт худалдаанд эзлэх хувь (%)
Толгой 5 экспортлогч	ХБНГУ	4.43	10.8
	Нидерланд	3.92	9.58
	АНУ	3.81	9.33
	Франц	3.29	8.05
	БНХАУ	2.53	6.19
Дүн		17.98	44.0
Толгой 5 импортлогч	ХБНГУ	3.19	7.81
	АНУ	2.55	6.25
	Франц	1.9	4.65
	Нидерланд	1.83	4.0
	Польш	1.6	3.93
Дүн		11.07	27.06

6.7.1. Зорилтот зах зээлийн зарим мэдээллүүд

6.7.1.1. Япон улсын гэрийн тэжээвэр амьтны хоолны зах зээл 2021 он

Япон улс, 2019 оны байдлаар гэрийн тэжээвэр нохойн хоолны хэрэглээний 51.2 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 48.8 хувийг импортоор хангасан бол муурны хэрэглээний 56.2 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, үлдэх 43.8 хувийг импортын худалдан авалтаар хангажээ.

Хүснэгт 51. Япон Улсын ГТА-ны хоолны импорт болон дотоодын үйлдвэрлэл төрлөөр (2019 оны санхүүгийн жил)

Хэмжих нэгж: тонноор

Үзүүлэлт	Нохой	Эзлэх хувь	Муур	Эзлэх хувь	Бусад ГТА	Эзлэх хувь
Дотоодын	134,317	51.2	170,524	56.2	24,463	90.9
Импортын	128,043	48.8	133,002	43.8	2,449	9.1
БҮГД	262,360	100	303,526	100.0	26,912	100.0

2019 оны байдлаар Японы импортод Тайланд, АНУ, Франц улсууд тэргүүлж эдгээр гурван орон нийт импортын 65 хувийг бүрдүүлж байна. Японы зах зээлд худалдаалдаг гэрийн тэжээвэр амьтны хоол нь түүний найрлага дахь усны эзлэхүүнээс хамаарч төрлийн хувьд 5 ангилалд хуваагддаг байна.

Хүснэгт 52. Япон Улсын ГТА-ны хоолны импортын болон дотоодын үйлдвэрлэл, хоолны ангилалаар (2019 оны санхүүгийн жил) хэмжих нэгж: тонноор

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хуурай	Зөөлөн хуурай	Хагас чийгтэй	Нойтон	Бусад	Бүгд
Нохойн хоолны хэрэглээ	Тонн	176609	21570	5104	34017	25061	262361
Нохой хоолны худалдааны хэмжээ	Сая ам.дол	718	64	27	207	339	1355
Муурны хоолны хэрэглээ	Тонн	194078	3	33	106463	2951	303528
Муурны хоолны худалдааны хэмжээ	Сая ам.долл	806.9	0.2	0.9	724.9	54.0	1586.9

6.7.1.2. БНСУ-ын зах зээлийн товч тойм- Гэрийн тэжээвэр амьтан.

2019 оны байдлаар Солонгосын гэрийн тэжээвэр амьтдын хоолны зах зээл нэг тэрбум гаруй ам.доллараар хэмжигдэж байна. Солонгосын тэжээвэр амьтдын тоо толгой нэмэгдэж байна. 2019 оны байдлаар Солонгос улсад 8.6 сая гэрийн тэжээмэл амьтан (2.6 сая муур, 6 сая нохой) бүртгэгдсэн бөгөөд 2019 он хүртэлх таван жилийн өсөлтийн хурд жилд 8 хувь, нохойн тоо толгой жилд 4 хувь байжээ. Евромониторингийн мэдээлснээр Солонгосын муурны хүнсний зах зээл 2025 он гэхэд 550.9 сая ам.долларын борлуулалт хийх төлөвтэй, дараагийн 6 жилд жилд дунджаар 6% өснө.

Гэрийн тэжээвэр амьтны хоолны төрөл, үнийн сегментээр ангилбал хямд ангиллын бүтээгдэхүүн 70 мянган тонн буюу нийт зах зээлийн 51 хувийг, дээд ангиллын бүтээгдэхүүн 43 мянган тонн буюу 31 хувийг, дундаж үнэтэй бүтээгдэхүүн 17 мянган тонн буюу 13 хувь, эмчилгээний бүтээгдэхүүн 8 мянган тонн буюу 6 хувийг эзэлж байна.

Тус улсын гэрийн тэжээвэр амьтны хоолны зах зээлийн 30 хувийг АНУ, 19 хувийг БНХАУ, 14 хувийг Тайланд, 9 хувийг Франц, 9 хувийг Канад, бусад орнууд 19 хувийг тус тус бүрдүүлж байна.

6.7.1.3. БНХАУ-ын зах зээлийн товч тойм- Гэрийн тэжээвэр амьтан

БНХАУ-ын гаалийн мэдээллээр тус улс 2021 онд 2309.10 кодтой гэрийн тэжээвэр амьтны хоол 17.6 мянган тонныг импортолж худалдан авалтын дүн 114 сая ам.долларт хүрсэн.

Хүснэгт 53. БНХАУ-ын гэрийн тэжээвэр амьтны хоолны импортын тоо хэмжээ (2016-2021) Хэмжих нэгж: тонноор

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт импорт	9813	16767	34920	54310	106672	97560
Канад	983	2874	8876	21900	51849	47895
АНУ	1927	3522	6686	8917	17855	17595
БҮГД	12723	23163	50482	85127	176376	163050

2022 оны эхний 11 сарын байдлаар АНУ-аас импортолсон гэрийн тэжээвэр амьтны хоол (2309.10 кодтой)-ны импорт 44026 тоннд хүрч 304 сая ам.долларын борлуулалт хийсэн нь 2021 онтой харьцуулахад 197 хувийн өсөлттэй гарсан байна.

Хүснэгт 54. БНХАУ-ын гэрийн тэжээвэр амьтны хоолны импортын үнийн дүн (2017-2022 эхний 11 сар) Хэмжих нэгж: сая ам.доллараар

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022/1-11 сар
Нийт импорт	90.0	206.4	307.6	621.9	580.8	614.9
Канад	16.3	70.5	141.3	321.7	274.6	123.9
АНУ	28.4	44.0	48.8	116.6	114.1	304.0

БНХАУ-ын эрх баригчдын шаардлагын дагуу тэжээвэр амьтдын импортын бүх хоол хүнс нь Хятадын Гаалийн ерөнхий газар (GACC) болон Хятадын Хөдөө Аж Ахуй Яамны тэжээлийн бүтээгдэхүүний бүртгэлтэй байх ёстой. (MAPA). 2022 оны 9-р сард Хятадын JD.com сайтаас гаргасан Хятадын гэрийн тэжээвэр амьтдын аж үйлдвэрийн цагаан номд дурдсанаар, 2022 онд Хятадад гэрийн тэжээвэр амьтдын тоо 100 саяас давж, зах зээлд нэвтрэлтийн түвшин нь 20 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь гэрийн тэжээвэр амьтны хоол, ялангуяа дээд зэргийн чанартай хоолны зах зээлд томоохон түлхэц үзүүлж байна.

6.8. Монгол малын дотор махны өрсөлдөх чадвар

Хүнсний дотор махны хувьд дэлхийн худалдааны багаахан хувийг эзэлдэг боловч манай орны хувьд авч үзэх юм бол дэлхийн хамгийн том импортлогч нь манай үрд хөрш БНХАУ(2.72 тэрбум ам. доллар), улс төр, эдийн засгийн хувьд сайн харилцаатай Япон (1.02 тэрбум ам. доллар), БНСУ (337.0 сая ам. доллар), Хонг Конг (439.0 сая ам. доллар), Вьетнам (171 сая ам. доллар), хойд хөрш ОХУ (151.0 сая ам. доллар), мөн сонирхож болох зах зээл Филиппин (399,0 сая ам. доллар, энэ улс дотор махны экспорт бараг хийдэггүй), Индонез (167,0 сая ам. доллар) зэрэг орнууд байна. Иймд эдгээр орнуудыг дотор махны экспортын зах зээлийн хувьд боломжит хувилбар гэж авч үзээд экспортын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар анхааран ажиллах хэрэгтэй байна. Вьетнам, Филиппин, Индонезийн зах зээлд ямааны дотор мах экспортлох боломжтой байж болох юм.

Персийн булангийн орнуудын хувьд 2022 онд 60.0 сая ам.долларын импорт хийжээ. Эдгээр орнуудын гол түншүүд нь далайн тээвэр хийх боломжтой, амьд мал болон шинэ эсвэл сэврээсэн мах нийлүүлдэг Бразил, Австрали, Шинэ Зеланд улсууд байна. Манай дотор мах Ex Works (үйлдвэрийн үнэ) үнийн хувьд өрсөлдөх чадвартай байж болох ч тээврийн зардал, нийлүүлэх хугацааны хувьд Бразил, Австрали, Шинэ Зеланд улсуудтай өрсөлдөхөд төвөгтэй байж болох юм.

Дэлхийн дотор махны зах зээлийн 97.62 хувийг 2022 оны байдлаар үхэр, гахайн дотор мах эзэлж байна. Үүнд үхрийн дотор мах 47.79 хувь (4.45 тэрбум ам. доллар) байгаа нь үхрийн дотор махны эрэлт өндөр байдгийг харуулж байна. Элэг, хэл багтаагүй үхрийн хөлдөөсөн дотор махны борлуулалт 2.77 тэрбум ам. доллар, хөлдөөсөн хэл 549.0 сая ам.доллар, хөлдөөсөн элэг 325.0 сая ам. доллар байгаа нь эдгээр бараа илүү эрэлттэй байгааг харуулж байна. Хөлдөөсөн дотор махан бүтээгдэхүүн нийт дотор махны борлуулалтын 79.36% (7.4 тэрбум ам. доллар) байгаа нь тээвэрлэлттэй холбоотой байж болох юм. Гэвч энэ нь ямар ч байсан дотор махыг хөлдөөж борлуулах нь илүү боломжтой гэдгийн харуулж байна.

Олон улсын зах зээлд малын гоц халдварт өвчнөөр тайван бүс нутгаас бэлтгэсэн, эрүүл малын мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх ерөнхий шаардлага тавигддаг тул манай орны хувьд энэ тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ нь мал, амьтны эрүүл мэндийн түвшний хувьд ижил түвшинд байгаа орнуудтай эхний ээлжинд хүнсний дотор мах, дайврын экспорт, импортын хорио цээр, ариун цэврийн нөхцөлийн талаар хууль эрх зүйн гадаад орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ИДЭВХТ ХҮНСНИЙ НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТОЙМ

7.1. Олон улсын зах зээл дээрх биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний хэрэглээ

Биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний (цаашид БИБ гэх) түүх 20-р зууны эхний хагаст Америкийн химич Карл Ренборг царгас, яншуй, “полигонум гидропайпер”-аас (нэгэн төрлийн чинжүү) бүрдсэн анхны БИБ-ийг гаргаж авснаар эхэлдэг. БИБ нь амин дэм, эрдэс бодис, амин хүчил, үл орлогдох тосны хүчил, төрөл бүрийн ургамал, ургамлын ханд, эслэг, пробиотик зэрэг олон төрлийн шим тэжээл, бусад орцуудыг агуулж болох бөгөөд эдгээрийг нунтаг, шахмал, капсул/бортого, шингэн, зөөлөн гель гэх мэт хэлбэрээр үйлдвэрлэдэг. БИБ-ийг хэрэглэгчдийн бүлгээр нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид, жирэмсэн эхчүүд, ахмад настнууд, тамирчид, борлуулалтын сувгаар нь эмийн сан, супермаркет/хайпермаркет, төрөлжсөн дэлгүүр, цахим худалдаа болон бусад гэж ангилдаг байна.

Precedence Research-ийн тайланд дэлхийн биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ 2022 онд 337 тэрбум ам.доллараар үнэлэгдэж байсан бол 2032 он гэхэд 647.58 тэрбум ам.долларт хүрч, 2023-2032 оны хооронд жилийн дундаж өсөлт нь 6.8% байхаар байна.




График 11. Дэлхийн биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ

Бидний сонирхож байгаа Ази Номхон далайн орнуудын хоол тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ 2022 онд 134.8 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2032 он гэхэд 256.62 тэрбум ам.долларт хүрч, 2023-2032 оны хооронд жилд дунджаар 7.1%-иар өсөх төлөвтэй байна.



График 12. Ази номхон далайн орнуудын хоол тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээ

7.2. БНХАУ-ын биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээл

Тус улсын БИБ-ний зах зээл 2015-2020 онд жилийн дундаж өсөлт нь 6.4%-д хүрч, 2020 онд 149 тэрбум юань (22.3 тэрбум ам. доллар) болжээ. Олон улсын нэр хүнд бүхий “SPER” байгууллагын хийсэн зах зээлийн судалгаагаар Хятадын БИБ болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээл 2033 он гэхэд жилийн 10.24%-ийн өсөлттэйгээр 89.63 тэрбум ам.долларт хүрнэ гэж таамаглаж байна.

Хятад улс 2021 онд гурван хүүхдийн бодлого хэрэгжүүлснээр эх нялхсын эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүний эрэлт нэмэгджээ. iResearch Study -ийн мэдээлснээр, бодлого зарласны дараах нэг жилийн дотор энэ зах зээлийн үнэлгээ 81.9 тэрбум юаньд хүрсэн байна. 2020-2022 оны хооронд эх, нялхсын эрүүл мэндийн бүтээгдэхүүний онлайн худалдаанд эрдэс бодис бүхий нэмэлтүүд хамгийн их борлуулалттай ангилалд багтаж, энэ сегмент нийт борлуулалтын 40 гаруй хувийг эзэлж байна. Эдгээр борлуулалтын 46.3 хувийг кальцийн бэлдмэл дангаараа бүрдүүлсэн байна

Залуу хэрэглэгчид эрүүл мэндийн нэмэлтүүдийг стресс бууруулах, нойр сайжруулах, дархлаа дэмжих, эрүүл мэндийн ерөнхий байдлыг сайжруулах зорилгоор худалдан авч байна. Хятадын зах зээлд эрүүл мэндийн зах зээлд амин дэм, эрдсийн бэлдмэлээс гадна омега-3 тосны хүчил, эслэгийн нэмэлт, уургийн нунтаг зэрэг бүтээгдэхүүн эрэлт ихтэй байна.

БНХАУ-д БИБ-ийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг шаарддаг. Бүртгэлийн үйл ажиллагаа хийхдээ Зах зээлийн зохицуулалтын төрийн захиргаа” (State Administration for Market Regulation SAMR) болон “Үндэсний эрүүл мэндийн комисс” (National Health Commission NHC)-оос тогтоосон дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой. Эрүүл мэндийн ангилалд багтсан бүх бүтээгдэхүүний бүртгэлийг “Улсын Хүнс, Эмийн Захиргаа” (State Food & Drug Administration SFDA) шинжилгээ туршилт хийсний дараа бүртгэдэг.

7.3. Өмнөд Солонгосын биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зах зээл

Хүн амын өсөн нэмэгдэж байгаа байдал, тэдгээрийн эрүүл мэндийн мэдлэг, насжилт нь Өмнөд Солонгост эрүүл мэндийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлж байна. Өмнөд Солонгосын Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны (Ministry of Food and Drug Safety) мэдээлснээр 2012 онд тус улсад 12,495 төрлийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн бүртгэгдсэн байсан бол 2019 онд энэ тоо хоёр дахин өсч 26,342 болсон байна. Зах зээлийн хэмжээ 2019 онд 4.1 тэрбум доллар, 2022 онд 5.57 тэрбум ам.доллар байсан бол 2030 он гэхэд 11.52 тэрбум ам.долларт хүрч жилийн дундаж өсөлт нь 9.5% болно гэж таамаглаж байна.

Өмнөд Солонгост 2021 онд айл өрхүүд хүнсний нэмэлт тэжээлд дунджаар 259.5 доллар зарцуулсан байна. Өмнөд Солонгосын иргэдийн 84.5 хувь нь хүнсний нэмэлт тэжээлийг хэрэглэдэг гэжээ. Солонгосчууд өдөрт уух тунгаар савласан, хэрэглэхэд хялбар сав баглаа боодолтой (stick) бүтээгдэхүүн илүү ихээр сонирхох болсон байна. Мөн хүн амын хөгшрөлт их болж тэдэнд тохирсон, эрүүл хөгшрөлтийг дэмжих бүтээгдэхүүн, түхэйлбал, үе мөчний эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна. Түүнээс гадна нь тусгайлан хувь хүнд зориулсан эсвэл хэрэглэгчийн захиалгаар хийх нэмэлт бүтээгдэхүүнүүд түгээмэл болж байна. Өмнөд Солонгосын Статистикийн газрын мэдээгээр 2022 онд 65, түүнээс дээш насны хүмүүс нийт хүн амын 17,5% (нийт хүн ам 51.6 сая) , 2025 онд 20,6% болох юм байна.

7.4. Монгол Улсын биологийн идэвхит хүнсний нэмэлт бүтээгдэхүүний хэрэглээ

Монгол улсад 2020 оноос 2023 оны 9-р сарын хооронд импортоор оруулж ирсэн болон экспортолсон БИБ-ний тоо хэмжээ, үнийн дүнг хүснэгт 48, 49-д харуулав. Гаалийн бүртгэлд импортын бүтээгдэхүүний нэр төрлийг ихэвчлэн “21069019” гэсэн HS код бичээд “биологийн идэвхт бүтээгдэхүүн” гэж ерөнхий нэрээр бичсэн тул чухам ямар төрлийн БИБ импортоор орж ирж байгаа нь мэдэгдэхгүй байна. Импортын БИБ-ний тоо хэмжээ, үнийн дүн жилээс жилд өсөж 2022 онд энэ тоо хэмжээ 521.4 тонн, үнийн дүн 31.8 сая ам, доллар болсон байна.

Дэлхийн 29 орноос БИБ худалдан авсан ба 2021-2022 оны БИБ-ний импорт 2020 оныхоос хоёр дахин өссөн байна. Энэ нь КОВИД цар тахлын дараа хүмүүс эрүүл мэндийн байдалдаа илүү анхаарал тавьж эхэлсэн болон эмч, эрүүл мэндийн байгууллагын заавар зөвлөмжтэй холбоотой байж болох юм.

Манай улсын Нөхөд ХХК, Сауп ХХК, МК интернейшнл ХХК, Форенхербал трейд, ХХК зэрэг долоон компани 2020-2023 онд хар ямааны бэлдмэл, адууны бэлдмэл, барагшууны цэвэршүүлж өтгөрүүлсэн бэлдмэл, амин дэмийн ханд зэрэг нэр төрлийн 102,8 тонн БИБ-ийг 746,4 мянган ам. доллароор АНУ, ОХУ, Өмнөд солонгос, Киргиз, Польш зэрэг оруудад экспортолсон байна. Экспортын тоо хэмжээ 2020 онд 4,2 тонн байсан бол 2021 онд 13,0 тонн, 2022 онд 32,4 тонн, 2023 оны эхний 9 сард 53,1 тонн буюу 2020 оныхоос бараг 13 дахин их болсон байна.

Хүснэгт 55. Монгол Улсад импортлогдсон БИБ-ийн хэмжээ /тн/, үнийн дүн /мян.ам.доллар/

2020		2021		2022		2023 I-IX сар	
Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн
384.8	14481.5	740.7	30382.1	521.4	31780.0	374.2	15041.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

2020		2021		2022		2023 I-IX сар	
Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн
4.3	27.4	13.0	90.7	32.4	257.1	53.1	371.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

Үндэсний статистикийн хорооны импортын мэдээлэлд тухайн биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүн нь малын гаралтай дотор мах, дайвар бүтээгдэхүүн дээр суурилсан эсэх тухай мэдээлэл одоогоор байхгүй байна.

Монгол Улсаас 2022 онд БНСУ-д 14,640.00 ам.долларын үнэ бүхий адууны ясны бэлдмэл 1.561 тн, 2,160.00 ам.долларын үнэ бүхий 0.234 тн хар ямааны бэлдмэл тус тус экспортолсон байна. 2020, 2021, 2023 онуудад экспорт хийгдээгүй байна.

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 тоот тушаалаар батлагдсан “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам”-д: “БИБ” гэдэгт хүний бие махбодын хэвийн үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай шимт бодис, илчлэгийг нөхөх үйлчлэл бүхий бүтээгдэхүүн хамаарах бөгөөд БИБ-нийг хүний өвчнийг эмчлэх, оношлох зорилгоор хэрэглэхгүй, БИБ-ний бүртгэл, өөрчлөлт, сунгалт, бүртгэлээс хасах асуудлыг ХЭЗ-ийн Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөл (цаашид “БИБСЗ” гэх) шийдвэрлэнэ гэжээ. БИБ бүртгүүлэгч нь тухайн үйлдвэрлэгч, эсхүл түүнийг Монгол Улсад төлөөлөх албан ёсны эрхтэй хуулийн этгээд байна. /Энэ заалтыг ЭМС-ын 2023 оны А/176 дугаар тушаалаар нэмсэн/ гэж тус тус заажээ.

Монгол улсад биологийн идэвхт бүтээгдэхүүний зах зээл төрийн зохицуулалттай байдаг бөгөөд импортын болон дотоодын үйлдвэрлэлийн БИБ-ийг заавал улсын бүртгэлд бүртгүүлсэн байхыг шаарддаг. Бүртгэлийн үйл ажиллагааг “Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” хийдэг ба одоогоор 3400 гаруй БИБ бүртгэгдсэн байна.

Үндэсний 27 үйлдвэр давхардсан тоогоор 170 нэр төрлийн БИБ бүртгүүлжээ. Эдгээр бүтээгдэхүүнээс 91 бүтээгдэхүүний хугацаа дуусч хасагдсан, үйлдвэрлэгч нь тодорхойгүй 77 бүтээгдэхүүн байна. Дээр дурьдагдсан БИБ үйлдвэрлэгч дотоодын 27 компанийн 25 нь ургамлын гаралтай түүхий эдээр амин дэм болон эрдсийн бэлдмэл үйлдвэрлэж байгаа бол харин Монэнзим ХХК, МК Интернейшнел ХХК, Монхимо ХХК, САУП ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг шинэ технологиор боловсруулан биологийн идэвхт бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Хатан сүйх ХХК компани үхрийн тулгуур яснаас кальцаар баялаг “Өтгөрүүлсэн шөл” гарган авч мөн дотоод, гадаадын зах зээлд гаргадаг боловч БИБ-ний бүртгэлд бүртгэгдээгүй байна.

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн (ШУТИС) Үйлдвэрлэлийн Технологийн Сургуульн (ҮТС), Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн САМО институт, гадаадын зарим лабораторитой хамтран малын боловсруулсан дотор маханд суурилан биологийн идэвхт бодисын агууламжийг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн судалгаа цөөнгүй хийсэн байдаг. Эдгээр судалгааны дүнд: дотор махан шөлний бэлдмэл, хатаасан дотор мах, дотор махны уургийн гидролизат, гемотоген үйлдвэрлэх технологи боловсруулжээ.





Түүнчлэн туршилт-судалгааны дүнд боловсруулсан технологийн горимоор бэлтгэсэн хатаасан уушги, дэлүү, гүзээ, цоохор сархинаг, салбан сархинагийн, эрүүл мэндийг дэмжих үйлдлийг тогтоох судалгааг Эм судлалын хүрээлэнтэй хамтран гүйцэтгэжээ.



Дээрх судалгааны ажлын үр дүнгийн тайлангууд Шинжлэх ухаан технологийн санд бүртгэлтэй байгаа бөгөөд хэрэв эдгээр судалгааны дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлбэл одоогоор ашиглаж чадахгүй байгаа малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний асар их нөөцийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлж байгаа төдийгүй жил бүр импортоор авч байгаа 30.0 гаруй сая ам. долларын импортын БИБ-нийг дотоодын бүтээгдэхүүнээр орлуулах боломжтой юм.

БҮЛЭГ 8. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ДОТОР МАХ, ДАЙВРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН PESTLE ШИНЖИЛГЭЭ

8.1. Давуу талууд



Хүснэгт 57. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын зах зээлийн PESTLE шинжилгээгээр гарсан давуу талын үнэлэмж





	<p>Улс төрийн орчны давуу тал:</p> <ul style="list-style-type: none"> Олон улсын байгууллагуудтай олон талын хамтын ажиллагаатай байдаг нь улс төрийн хувьд том давуу тал болох юм. Ингэснээр олон улсын стандарт, гэрээг дагаж мөрдөх амлалт хүлээсэн нь Монгол Улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортод, түүний дотор малын мах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортод шууд болон шууд бусаар нөлөөлөх юм. ХАА-н салбарын мэргэжилтнүүд ОУ-ын байгууллагаас мэргэжлийн зөвлөгөө авах, түршлага солилцох, мэдлэг үр чадвараа байнга дээшлүүлэх боломжтой байна. Тухайлбал, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (WOAH), Дэлхийн худалдааны байгууллага (WTO), Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO)-тай байнгын хамтын ажиллагаатай, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн байна.
	<p>Эдийн засгийн орчны давуу тал</p> <ul style="list-style-type: none"> Хүнсний дотор мах, дайврын дэлхийн хамгийн том хэрэглэгч буюу эрэлт ихтэй зах зээлд хамгийн ойр байршилтай. Бэлчээрийн мал аж ахуйгаас мах, дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр дотоодын хэрэглээг бүрэн хангах чадвартай. Малын арьс шир болон мал төхөөрөхөд дагалдан гарах бусад дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой.
	<p>Нийгэм-соёлын орчны давуу тал</p> <ul style="list-style-type: none"> Нүүдлийн мал аж ахуйн соёл, уламжлал олон мянган жилийн турш хадгалагдан өвлөгдөж ирсэн. Үүнийгээ дагаад амьтны дотор мах, дайвар бүтээгдэхүүнд хандах соёлын хандлага төлөвшсөн ба ялангуяа сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн хоолны дэглэм, сонголтоос шалтгаалж дотор махыг хүнсэндээ хэрэглэх хандлага нэмэгдэж байгаа. Хүүхэд байхаасаа байгаль, малтай ойрхон өсдөг болохоор мал, амьтныг хайрлах сэтгэл зүйтэй.
	<p>Техник-технологийн орчны давуу тал:</p> <ul style="list-style-type: none"> Уламжлалт технологийн өргөн мэдлэгтэй. Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах технологийн дэвшлийг ашиглан малын маханд дотор махыг нэгтгэх замаар бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зардлыг бууруулах судалгааны ажлууд идэвхтэй хийгдэж байгаа.

	<ul style="list-style-type: none"> Энэ нь үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, инновацийг бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулна.
	<p>Хүрээлэн буй орчны давуу тал:</p> <ul style="list-style-type: none"> Цаг уурын нөхцөлд тэсвэртэй, газар нутгийнхаа онцлогт дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг адгуулах өргөн уудам нутаг бэлчээртэй. Өргөн уудам бэлчээр нутгийнхаа ачаар хангалттай олон тооны, олон төрөл, зүйлийн мал сүргийг өсгөн үржүүлж, хүн амынхаа мах, сүүний хэрэгцээг хямд үнэтэй бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, хүнсний баталгаат байдлыг нөхцөлдүүлэн, хараат бус байх үндсийг бүрдүүлж өгч байна.
	<p>Хууль эрх зүйн орчны давуу тал:</p> <ul style="list-style-type: none"> Монгол Улсын төрөөс малын мах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний бэлтгэл, үйлдвэрлэл, хэрэглээ, экспортод гаргахтай холбоотой олон хууль, хөтөлбөр, стандарт, эрх зүйн бичиг баримтууд гарсан байна. Тухайлбал, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Хүнсний тухай хууль”, “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль” гэх мэт хуулиуд, “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”, Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандартад нийцүүлэн 2022 оны байдлаар 6 стандартыг Монгол Улсын үндэсний стандартаар батлуулаад байна.

8.2. Сул тал

Хүснэгт 58. PESTLE шинжилгээний үр дүнгээр гарсан сул талын үнэлэмж

	<p>Улс төрийн орчны сул тал:</p> <ul style="list-style-type: none"> Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөрүүдийн үялдаа холбоо сул, тодорхойгүй байна. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой эрх зүйн орчин бүрдээгүй байна. Мал аж ахуйн бэлчээр ашиглалттай холбоотой ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй. Дотор мах, дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, экспортын мэдээллийн нэгдсэн бүртгэл, тогтолцоо байхгүй, HS 0206 олон улсын кодын ангиллыг 16 оронтойгоор ашигладаг хэрэглээ нэвтрээгүй байна. Анхдагч үйлдвэрлэлээс хүнсний малыг зах зээлд борлуулах тогтолцоо бүрдээгүй, албан бус сектор буюу “ченж”-үүд энэ үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд үүнд төрийн зохицуулалт байхгүй байна. Монгол Улсад худалдааны хууль тогтоомж байхгүйгээс хүнсний дотор мах, дайврын бөөний болон жижиглэнгийн худалдаа ямар нэг хяналт, зохицуулалтгүйгээр явагддаг бөгөөд хүнсний дотор мах, дайврын ашиглалт, хэрэглээний талаар шаардлагатай тоон мэдээлэл, өгөгдөл төрд байхгүй байна.
	<p>Эдийн засгийн орчны сул тал</p> <ul style="list-style-type: none"> Уул уурхайгаас хэт хамаарал бүхий эдийн засгийн бүтэцтэй, экспорт, импортын хувьд ганц зах зээлээс хараат байдал өндөр. Энэ нь валютын ханшийн хэлбэлзэл, инфляц зэрэгт хүчтэй нөлөөлснөөр мах, дайвар бүтээгдэхүүний бэлтгэл, нийлүүлэлт, үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд орлогын хэлбэлзэлд хүргэж хүн амын худалдан авах чадварыг бууруулдаг. Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ хөгжөөгүй, институци байхгүй, өртгийн сүлжээ сул, өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудал дэмжлэггүй байна.
	Нийгэм-соёлын орчны сул тал

	<ul style="list-style-type: none"> Малын ашиг шимийн гарц буурч байгаатай холбоотойгоор бэлчээрийн мал аж ахуй эрхлэх сонирхолтой залуу үеийнхний тоо жилээс жилд буурч байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ихсэх хандлагатай байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоог цөөрүүлж хөдөлмөрийн бүтээмжийг бууруулах магадлалтай.
	<p>Техник-технологийн орчны сул тал:</p> <ul style="list-style-type: none"> Нийт мах бэлтгэлийн 90-ээс дээш хувийг үйлдвэрийн бус аргаар төхөөрч байгаа бөгөөд энэ нь мах, ялангуяа хүнсний дотор мах, дайврын цэвэр, аюулгүй байдал хангагдахгүй байх гол нөхцөл болж байна. Олон тооны малыг нэг дор бөөнөөр нь төхөөрч байгаа нөхцөлд хүнсний дотор мах, дайврыг цэвэрлэхэд их хэмжээний халуун, хүйтэн ус шаардагдах бөгөөд задгай талбайд малыг гар аргаар төхөөрч байгаа нөхцөлд гэдэс дотрыг угааж цэвэрлэх ажиллагаа стандартын дагуу хийгдэх боломжгүй юм. Үүнээс шалтгаалж дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг шууд хаягдал болгож, энэ нь эргээд хүрээлэн буй орчны асуудал үүсгэж байна. Ариун цэвэр, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, гарал үүсэл нь тодорхойгүй, баталгаагүй дотор мах, дайврыг хэрэглэгчид худалдан авахаас татгалзаж байгаа бөгөөд дотор мах, дайврын хэрэглээ хангалтгүй байх гол нөхцөл нь энэ болж байна.
	<p>Хүрээлэн буй орчны сул тал:</p> <ul style="list-style-type: none"> Бэлчээр ашиглах, хамгаалах харилцааны эрх зүйн орчны зохицуулалтыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага үүссээр байна. Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг тогтвортой явуулах татаас, урамшууллын бодлогын шалгуурыг тодорхой болгон хэрэгжүүлэх шаардлагатай байна.
	<p>Хууль эрх зүйн орчны сул тал:</p> <ul style="list-style-type: none"> Малын тоо толгойн хэт их өсөлт, бэлчээрийн даацын хэтрэлт, доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн хүчтэй нөлөө нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг бууруулж зардлыг өсгөж байдаг. Гэвч эдгээр асуудлыг зохицуулахад чиглэсэн хууль эрх зүйн орчин байхгүй байна.

8.3. Гадаад орчны хүчин зүйлийн талаарх дүн шинжилгээ

Дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээлд үзүүлэх үлс төр, эдийн засаг, нийгэм-соёл, техник-технологи, хууль эрх зүй, хүрээлэн буй орчны гадаад орчны нөлөөллийн дүн шинжилгээ хийлээ.

8.3.1. Боломжууд

8.3.1.1. Улс төрийн боломж: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар нь олон улсын гэрээнд нэгдэн оролцох нь хамтын ажиллагаа, худалдааг дэмжиж, илүү өргөн зах зээлд нэвтрэх боломжийг олгодог.

8.3.1.2. Эдийн засгийн боломж: Дэлхийн зах зээлд, ялангуяа ази тивд малын мах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсээр байна. Тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа энэ хэрэгцээг хангахын тулд янз бүрийн шинэ бүтээгдэхүүн гарч ирж байна. Малын махыг орлуулах бүтээгдэхүүн санал болгох замаар махны хэрэглээг бууруулахыг эрмэлзэж байна гэсэн үг. Үүнийг дагаад малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг төрөлжүүлснээр зах зээл өргөжиж экспортын хэмжээ нэмэгдэнэ. Дэлхийн хүн ам органик хүнсний бүтээгдэхүүнд ихээхэн анхаарлаа хандуулж байгаа бөгөөд бэлчээрийн монгол малын мах экологийн цэвэр маханд тооцогддог.

8.3.1.3. Нийгэм-соёлын орчны боломж: Хэрэглэгчийн зан үйлийн чиг хандлага, дадал зуршил нь Монголын хөдөө аж ахуйн салбарт нийгмийн боломжийг бий болгож байна. Нийгмийн эрүүл мэндийн

боловсрол дээшилж хүнсний бүтээгдэхүүнийг цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүнээр орлуулах хүсэл, хандлагад нийцүүлэн бүтээгдэхүүнийг санал болгосноор дэлхийн зах зээлийн шинэ сегментүүдэд нэвтрэх боломжтой.

8.3.1.4. Техник-технологийн орчны боломж: Малын дотор мах, дайвраас кератин болон коллагеныг цэврээр ялгаж авахад технологийн хөгжүүлэлт, инновацыг нэвтрүүлэх боломжтой. Ингэснээр дотор маханд суурилсан биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг цахим худалдааны платформоор дамжуулан дэлхийн өнцөг булан бүрд борлуулах бүрэн боломжтой. Тухайлбал, экспортлогч нь Хятадын холбогдох цахим платформуудаас (cross-border-commerce) зөвшөөрөл авсан бол Tmall Global, JD.com, WeChat, Baidu гэх мэт хайлтын системийг ашиглаж болно.

8.3.1.5. Хууль эрх зүйн орчны боломж: Олон улсын зах зээлд малын гоц халдварт өвчнөөр тайван бүс нутгаас бэлтгэсэн, эрүүл малын мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх ерөнхий шаардлага тавигддаг тул мал, амьтны эрүүл мэндийн хувьд ижил түвшинд байгаа орнуудтай эхний ээлжид хууль эрх зүйн гадаад орчныг бүрдүүлэх боломжтой. Энэ нь худалдааг хөнгөвчлөх төдийгүй олон улсын чанар, аюулгүй байдлын стандартад нийцэж байгааг баталгаажуулдаг.

8.3.1.6. Хүрээлэн буй орчны боломж: Газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх, ногоон эдийн засгийн зарчмыг баримтлах, үйлдвэрлэлийн ухаалаг системийг хөгжүүлэх зэрэг нь үйл ажиллагааны зардал болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хоёуланг нь бууруулах боломжтой.

8.3.2. Аюул занал

8.3.2.1. Улс төрийн аюул занал: Бүс нутгийн геополитикийн тогтворгүй байдал ялангуяа түлш, шатахууны импортын ОХУ-аас хараат байдал нь зах зээлийн тогтворгүй байдлыг үүсгэж салбарын урт хугацааны төлөвлөлт, хөрөнгө оруулалтад эрсдэл учруулж болзошгүй.

8.3.2.2. Эдийн засгийн аюул занал: Эдийн засгийн онцлох хоёр аюулд хурдацтай хотжилт болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган, зуд, үер зэрэг нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд саад учруулж байна. Мөн дэлхийн улс орнуудын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нь иргэдийн худалдан авах чадварыг бууруулж байна.

8.3.2.3. Нийгмийн аюул занал: Эрүүл ахуйн шаардлага хангаагүй мах, дотор мах, дайвар нийлүүлэгдэж хүн амын эрүүл мэнд болон хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх аюултай. Өсөн нэмэгдэж буй хүн амын хэрэгцээг хангахуйц тогтвортой, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсээр хангах нь төвөгтэй асуудлуудын нэг юм.

8.3.2.4. Техник-технологийн орчны аюул занал: Малын эрүүл мэндийн үйлчилгээний хяналтын систем хөгжөөгүй, мал болон түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хөдөлгөөнийг мөшгөх бүртгэл, мэдээллийн ухаалаг систем нэвтрээгүй. Мөн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх технологийн бодлогын шинэчлэлийн эрх зүйн орчин бүрдээгүй байна.

8.3.2.5. Хууль эрх зүйн орчны аюул занал: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зохицуулалтууд нь шинэ стандарт нэвтрүүлж, хүлэмжийн хийг бууруулахыг, хөдөө аж ахуйн салбарт тэдгээрийг дагаж мөрдөхийг шаардах болно. Энэ нь салбарын үйл ажиллагаанд захиргааны ачаалал, зардлыг нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг бууруулж болзошгүй.

8.3.2.6. Хүрээлэн буй орчны аюул занал: Дулаарал, хэт халалт, хэт хүйтэн, хуурайшлын улмаас бэлчээр доройтон цөлжих, бэлчээрийн ургамлын ургац буурснаар малын тэжээл хомсдох, бэлчээрлэлт саатах, тарга тэвээрэг дутуу авах, улмаар малын амьдын жин буурах, үхэл, хорогдол ихсэх эрсдэлтэй. Сүүлийн

жилүүдэд малын халдварт өвчний гаралт нэмэгдэж зарим өвчин эмгэг дахин сэргэн дэгдэх, тархах эрсдэл өндөр болсон. Хүснэгт 48-д бүтэцлэгдсэн SWOT/PESTLE шинжилгээ болон тодорхойлсон хүчин зүйлсийн иж бүрэн хураангуйг харуулав.

Хүснэгт 59. Монгол улсын дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээлийн SWOT/PESTLE шинжилгээний нэгдсэн дүн

PESTLE/SWOT	ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛ/INTERNAL	
	Давуу тал/Strengths	Сул тал/Weakness
Улс төр	SP1 Олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа SP2 Салбарын мэргэжилтнүүдийн байнгын мэргэжил дээшлүүлэлт	PW1 Төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо сул PW2 Нэгж дээр хэрэгждэггүй
Эдийн засаг	EcS1 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн хамгийн том хэрэглэгч буюу эрэлттэй зах зээлтэй хамгийн ойр байршил EcS2 Үйлдвэрлэлийн нөөц их	EcW1 Хэт 1 хамаарал бүхий эдийн засгийн бүтэцтэй, экспорт, импортын хувьд ганц зах зээлээс хараат байдал өндөр. EcW2 Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ мүү
Нийгэм	SS1 Хүн амын хэрэглээний соёлын хандлага төлөвшсөн	SW1 Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх сонирхолтой залуу малчны тооны бууралт SW2 Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн
Технологи	TS1 Уламжлалт технологийн өргөн мэдлэгтэй	TW1 Малыг үйлдвэрлэлийн аргаар бараг төхөөрдөггүй. TW2 Хөлдөөх, дулааны аргаар боловсруулах технологи сул
Хууль эрх зүй	LS1 Хууль эрх зүйн орчны дэмжлэг сайн	LW1 Үйлдвэрлэгчийн татаас, урамшууллын бодлогын шалгуур тодорхой бус
Хүрээлэн буй орчин	ES1 Газар зүйн болон байгалийн олон янзын бүстэй.	EW1 Уур амьсгалын өөрчлөлт хүчтэй явагдаж байгаа
PESTLE/SWOT	Гадаад хүчин зүйл/External	
	Боломж/Opportunities	Аюул занал/Threats
Улс төр	PO1 Олон улсын гэрээнд нэгдэх	PT1 Бүс нутгийн геополитикийн тогтворгүй байдал
Эдийн засаг	EO1 Зах зээлийн эрэлтийн тасралтгүй байдал EO2 Дотор мах, дайвар бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаа	ET1 Хотжилт нэмэгдэж байгаа ET2 Цаг агаарын эрс тэс үзэгдлийн улмаас орлогын хэлбэлзэл үүсч байгаа
Нийгэм	SO1 Хэрэглэгчийн зан үйл ба хандлага	ST1 Хүнсний аюулгүй байдал
Технологи	TO1 Технологийн интеграцчилал бүхий шилэн өртгийн сүлжээ TO2 Үйлдвэрлэлийн үр ашгийг хангахын тулд өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт	TT1 Кибер-аюулгүй байдлын эрсдэл TT2 Технологи болон өгөгдлийн хамаарал
Хууль эрх зүй	LO1 Олон улсын стандартад уялдуулах	LT1 Уур амьсгалын зохицуулалт
Хүрээлэн буй орчин	EO1 Байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх	ET1 Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн буй орчны доройтол, бохирдол

БҮЛЭГ 9. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ҮР ДҮН, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

9.1. Судалгаанаас гарсан үр дүн

9.1.1. Дотор махны үйлдвэрлэл, нөөц, дотоод зах зээлийн нийлүүлэлтийн хэмжээ (нэр төрлөөр), хэтийн төлөв

2023 оны байдлаар дотор мах, дайвар түүхий эдийн нийт нөөцийн 50.8%-ийг хонины, 27.7%-ийг ямааны, 18.1%-ийг үхрийн, 3.3%-ийг адууны дотор мах, дайвар эзэлж байна. 2023 онд нийт нөөцийн 11.3%-ийг үйлдвэрийн аргаар, 14.3%-ийг уламжлалт аргаар бэлтгэж зах зээлд нийлүүлсэн бол үлдэх 74.4%-ийг ямар нэг байдлаар ашиглаагүй/хаягдал болгожээ.

2019-2023 оны статистик мэдээллийг суурь болгож 2030 он хүртэлх хугацаанд бэлтгэх дотор махны боломжит нөөцийн харьцааг тооцоход үхрийн дотор махны хэмжээ 20% орчим нэмэгдэх, адууных 60%, бог малынх 6.5% орчим буурах төлөвтэй байна. Бог малын дотор мах, дайврын нийлүүлэлтийн хэмжээ буурах хандлагатай байгаа ч нийт нөөцөд давамгайлсан (75%) хэвээр байх болно.

Судалгааны багаас хийсэн хэмжилтийн дүнгээр үйлдвэрт төхөөрсөн адууны гулууз махны жингийн 18.7 %-тай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд (цусыг оролцуулалгүй) гарсан бол үхрийнх 26.2%, хониных 34.4%, ямааных 32.3% байна. Уламжлалт аргаар бэлтгэсэн адууны дайвар бүтээгдэхүүний гарц гулуузны жингийн 17%-ийг эзэлж байгаа бол үхрийн 29.3%, ямааных 52.3%, хониных 61.6% байна.

Бусад судлаачдын янз бүрийн цаг үед хийсэн хэмжилтүүдийг өөрсдийн хэмжилтийн дүнтэй нэгтгэн дундчилж тооцоход нас гүйцсэн нэг толгой адуунаас 70 орчим кг буюу амьдын жингийн 35, гулуузын жингийн 45 орчим хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гарахаар байна. Үүнээс 20 орчим хувийг нь хүнсний зориулалтаар ашиглах боломжтой. Хэрэв цусыг авч хүнсний зориулалтаар ашиглабал дээрх үзүүлэлт 3 – 5 хувиар өснө. Тооцоогоор нэг үхрээс 60 гаруй кг буюу дундаж амьдын жингийн 25, гулуузын жингийн 40 гаруй хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гарч байна. Үүнээс 70 орчим хувийг нь хүнсний зориулалтаар боловсруулж ашиглах боломжтой. Үүн дээр цусыг нэмвэл энэ хэмжээ 80%-д хүрнэ. Нэг толгой хониноос амьдын жингийн 45%, гулуузын жингийн 90 орчим хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гарахаар байгаагаас 68 хувийг хүнсний зориулалтаар ашиглах боломжтой. Нэг толгой ямаанаас амьдын жингийн 30%, гулуузын жингийн 60 гаруй хувьтай тэнцэх хэмжээний дотор мах, дайвар түүхий эд гарахаас 90 хувийг хүнсний зориулалтаар ашиглах боломжтой байна.

Бид 4 төрлийн малын хүнсний дотор мах, дайврын нийт нөөцийн ашиглалтыг тооцож үзэхэд, манай улс 2019-2023 онд хүнсэнд хэрэгцээлсэн 4 төрлийн малаас жилд 222.5-324.3 мянган тонн дотор мах, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой байснаас малчин өрхийн дотоодод хэрэгцээлсэн 4 төрлийн малаас гарах 37.2 мянган тонн дотор мах, дайварыг малчид, хөдөөгийн болон орон нутгийн хэрэглэгчид бүрэн хэрэгцээлсэн гэж тооцвол цаана нь 185.3-287.1 мянган тонн дотор мах, дайвар гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэгдэх боломжтой байжээ.

Энэхүү боломжит нөөцөөс экспортод гаргасан 1.7 мянган тн, хөдөөгийн хэрэглэгчдийн хэрэгцээлсэн 37.2 мянган тн, Улаанбаатар хотын захуудаар борлуулагдаж буй 1.2 мянган тонн, нийт 40.1

мянган тонн дотор мах, дайврыг хасахад ойролцоогоор 182.4-284.2 мянган тонн дотор мах, дайвар хэрэглээгүй хаягдсан байж болзошгүй. Энэ нь нийт нөөцийн 82-87.6 хувьтай тэнцэж байна.

Элэг, уушги, бөөр, зүрх, гүзээ, адууны умс, хитайг судалгаанд хамрагдсан бүх хүнсний зах ямар нэг хэмжээгээр жижиглэн борлуулж байна. Борлогдож байгаа дотор мах, дайвраас бүх төрлийн малын хэл (1 кг нь 15000-19500₮), зүрх (1 кг нь 6000-20500₮), үхрийн гүзээ (1 кг нь 4500-8500₮), адууны умс, хитай (1 кг нь 4500-9500₮) хамгийн өндөр үнэтэй борлогддог байна. Үхрийн бөөр, уушгийг хүмүүс голчлон нохойн хоолонд зориулан худалдан авдаг ажээ.

Өнөөгийн байдлаар богийн өлөн гэдэс, бод, богийн элэг, зүрх, бөөр, гүзээ, сархинаг зах зээлд борлуулалт сайтай байгаа бол хонины сүүл, умс, хятай, уушги дунд зэргийн борлуулалттай, толгой, шийр, дотор өөх, жонго борлуулалт муутай байна. Цаашдаа бод, богийн өлөн гэдэс, элэг, гүзээ, хонины сүүл, толгой, шийрний борлуулалтын хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа бол умс, хятай, уушги, бөөр, зүрх, дотор өөх, жонгоны борлуулалтын өсөлт муу байхаар байна.

9.1.2. Дотор маханд суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрөл, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон нийтийн хоол үйлдвэрлэлийн одоогийн байдал, хэтийн төлөв

Хатан сүйх импэкс ХХК, Хүн-Од ХХК, Мах маркет ХХК, Трасттрейд ХХК, Очирдагинас ХХК, Хиам, консервын үйлдвэр ХХК зэрэг үйлдвэр, аж ахуйн нэгж дотор мах, дайвраар хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод зах зээлд худалдаалж байна. Дээрх компаниудаас гадна малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг хагас боловсруулж худалдаалдаг хувь хүн, аж ахуйн нэгжүүд ч байна. Эдгээр нь хонины хуйхалсан толгой, шийр, элэг сэмж, бөөр, зүрх, үхрийн хуйхалсан шийр зэргийг захиалгаар хүргэж өгдөг байна.

Нэр бүхий үйлдвэрүүд нийтдээ 500 гаруй тн дотор махан бүтээгдэхүүн жилдээ үйлдвэрлэдэг байна. Үйлдвэрүүдээс гадна жижиг цехүүд мөн дотор махан бүтээгдэхүүн бага хэмжээгээр зах зээлд нийлүүлдэг. Дотор махан бүтээгдэхүүний гарц түүхий эдийн жингийн 60 орчим хувь хэмээн тооцвол 1000 орчим тн дотор мах боловсруулдаг байх тооцоо гарч байна. Гэхдээ үйлдвэрлэлд үхрийн элэг, зүрх, гүзээ голлон ашиглагддаг бөгөөд нөөцийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа богийн дотор мах, дайврын ашиглалт хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд төхөөрсөн малын арьс, ширний 53%-ийг шууд борлуулж, үлдэх хэсгийг хаягдалд тооцох, эсвэл малаа төхөөрүүлсэн хүмүүст буцаан өгдөг байна. Малын толгойн ашиглалт дунджаар 56 хувь, шийр 35 хувь, дотор мах, гэдэсний ашиглалт 59 хувь байна. Цус, төхөөрөлтийн явцад гарч байгаа хүнсний бус хаягдал, ясны ашиглалт хамгийн бага (4-14%) байна. Борлуулалтын хувьд хамгийн өндөр хувийг хонины өлөн гэдэс (79%) эзэлж байгаа бол бараг ашиглалтгүй байгаа дайврын тоонд малын цус (4%) тооцогдож байна. Үхрийн өлөн гэдэсний ашиглалт 27% байгаа бол үлдэх хэсэг нь ашиглагддаггүй байна.

Хүнсний зориулалтын дотор мах, дайврын борлуулалт дөрвөн төрлийн малын дундаж үзүүлэлтээр 59 хувьтай байгаа нь үйлдвэрийн аргаар мал төхөөрдөг үйлдвэрүүдийн хувьд чамлалттай үзүүлэлт юм. Мал төхөөрөх үеийн хүнсний бус хаягдлын борлуулалт 8 хувь байхад, шуллагааны хаягдлын борлуулалт 23 хувьтай байгаа нь хэдийгээр багахан хувийг эзэлж байгаа хэдий ч цаашид хүнсний бус хаягдлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэл тавигдаж буйг харуулж байна.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 1129 ресторанаас 358-ыг, 1107 гуанз, цайны газраас 466-г судалгаанд хамруулсан, судалгаанд хамрагдсан рестораны 35 буюу 9.7 хувь, гуанз, цайны газрын 26

буюу 5.5 хувь нь малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр 12 нэр төрлийн хоол, 11 төрлийн зууш, салат хийж нийтэд үйлчилдэг байна. Эдгээр ресторан 92,3 тн, гуанз, цайны газар 93,3 тн, нийт 185,6 тн дотор мах, дайврыг жилдээ хэрэглэдэг гэсэн тойм судалгаа, дүн мэдээ гарч байна.

Судалгаанд хамрагдсан нийт рестораны 9.7%, гуанз цайны газрын 5.5 хувь нь дотор мах, дайвараар хоол хийж үйлчилж байгааг нийслэлийн хэмжээний нийт ресторан, гуанз цайны газрын тоонд шилжүүлж тооцвол 110 ресторан, 61 гуанз, цайны газар төрөл бүрийн дотор мах, дайвараар халуун хоол, хүйтэн зууш хийж нийтэд үйлчилдэг байх магадлалтай бөгөөд нийт дүнгээр 620 тн дотор мах, дайврыг нийтийн хоолны үйлчилгээнд ашигладаг байж болох тооцоо гарч байна. Нийтийн хоол үйлдвэрлэлд хамгийн их ашиглагддаг дотор мах нь гүзээ, сархинаг, хэл, таван цул байна.

9.1.3. Дотор махны зах зээлийн багтаамж, түүний өөрчлөлт, хэрэглэгчдийн сонголт, зах зээлийн сегментчилэл, ирээдүйн чиг хандлага

Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын нийт нөөц 2023 оны үнээр тооцвол 167.3 сая ам.доллороор үнэлэгдэж байгаа бөгөөд үүний 9.4 хувь буюу 14.1 сая ам.долларын үнэ бүхий дотор мах, дайвар түүхий эдийг дотоодын зах зээлд борлуулах багтаамжтай байна. Дотоод зах зээлийн хэрэгцээ 2030 он хүртэлх хугацаанд 10.5 %-иар өсөх боломжтой.

Монгол Улсын дотор мах, дайврын зах зээлийг үндсэнд нь 25-55 насныхан (62.6%) бүрдүүлж байна. Хот, суурин газарт амьдардаг гэр бүлийн хувьд хоол, хүнсний хэрэглээг зохицуулж, шийдэхэд эмэгтэйчүүд голлох үүрэгтэй болох нь судалгаанаас харагдсан. Дотор мах, дайврыг хүн амын 31.4 % нь сар бүр, 59.6% нь улиралд нэг юм уу, жилд 1-2 удаа хэрэглэдэг бол харин 4 орчим хувь нь дотор махыг огт хэрэглэдэггүй байна. Хүүхэд, өсвөр насныхны хэрэглээ нийлээд 10 орчим хувь байгаа нь энэ насныханд чиглэсэн сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, тэдний таашаалд нийцсэн амт, чанартай шинэ бүтээгдэхүүнийг бий болгох шаардлага байгаа нь харагдаж байна. Хүмүүс дотор махыг орлогын түшингээс үл хамааран хэрэглэдэг байна.

Дотор махыг хааяа болон эсвэл огт хэрэглэдэггүй гэсэн хариулт өгсөн хүмүүс шалтгаанаа “дотор махыг гэртээ цэвэрлэж, боловсруулахад төвөгтэй, эсвэл эрүүл ахуйн аюулгүй байдал нь баталгаагүй, шинэлэг байдал нь эргэлзээтэй” гэжээ. Хэрэглэгчдийн дийлэнх буюу 61.9% өөрсдөө харж төхөөрүүлсэн малынхаа гэдэс, дотрыг хэрэглэдэг бол 24.3% нь захаас, үлдэх хэсэг нь нийтийн хоолны үйлчилгээнээс хоол авч иддэг байна.

Дотор махны талаарх мэдээллийг хэрэглэгчид ихэнхдээ гэр бүлийн уламжлалаас (78.9%), үлдэх хэсэг нь интернэт, нийгмийн сүлжээ(22.8%), ном, сонин, сэтгүүл (14.8%)-ээс авдаг байна.

Асуулгад оролцсон хүмүүсийн 76.8% нь үйлдвэрийн аргаар боловсруулсан дотор мах худалдаж авдаггүй гэжээ. Энэ нь үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан дотор мах зах зээлд маш бага (23.2%) хэмжээтэй нийлүүлэгдэж байгааг харуулж байна. Гэтэл хэрэглэгчдийн 90 гаруй хувь нь цэвэр, шинэ дотор махыг түүхийгээр нь худалдан авах сонирхолтой байна.

Улаанбаатар хотод зарагдаж байгаа малын дотор мах, дайвар түүхий эдийн хамгийн их борлуулалт хийдэг газар өнөөдрийн байдлаар Хүчит шонхор зах юм. Бусад супер маркет, жижиг зах, дэлгүүрүүд гол төлөв Хүчит шонхор захаас татан авалтаа хийдэг ажээ. Бидний явуулсан нэг агшины судалгаагаар Хүчит шонхор зах дээр долоо хоногт ойролцоогоор 3500 кг үхрийн дотор мах, дайвар түүхий эд, 15750 кг бог малын дотор мах, дайвар түүхий эд, 3500 кг адууны дотор мах, дайвар түүхий эд борлогддог байна.

Уламжлалтай холбоотойгоор дотор махыг зах зээлээс түүхийгээр нь авч өөрсдөө болгож хэрэглэх сонирхол хэрэглэгчдийн дунд нийтлэг байна. Ялангуяа хаврын улиралд харшаа, ядаргаагаа арилгахын тулд таван цулын шөл уух, яргүй идсэн ямааны шөл, хонины шинэ махны шөл уух гэх мэт хэрэглээ, дадал зуршил одоо ч үргэлжилж байна.

9.1.4. Дотор махны боловсруулалт, хэрэглээг сайжруулахад нөлөөлж буй хүчин зүйлс, боломж

Монгол Улсын дотор мах, дайвар бүтээгдэхүүний стандартын ангилал олон улсын ангиллаас нилээд зөрүүтэй байна. Олон улсын ангиллаар, юуны өмнө малаас гарч байгаа бүх дотор мах, дайврыг ашиглалтын байдлаар нь хүнсэнд хэрэглэдэг, хүнсэнд хэрэглэдэггүй, хяагдал гэж 3 ангилдаг байна. Хүнсэнд хэрэглэдэг дайврыг улаан, цагаан, бараан гэж 3 ангилдаг бол хүнсэнд хэрэглэдэггүй дайврыг дахин боловсруулдаг, хяагдал болгодог гэж хоёр хуваадаг.

Хэрэглэгчдийн тал хувь нь эрүүл мэндээ дэмжих зорилгоор дотор мах, дайврыг хэрэглэдэг болсон байна. Үлдсэн хэсэг нь гэр бүлийн уламжлалын дагуу, эсвэл дуртай учраас хэрэглэдэг аж. Дотор махыг бүхлээр нь чанаж идэхээс гадна асуумж судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнх нь амталсан хоол хийж иддэг гэсэн нь шинэлэг хандлага юм. Мөн бусад хоолны хольц болгон ашигладаг хэрэглээ бий болсон байна.

Судалгаанд оролцогчдын 1/3-ээс дээш хувь нь дотор махны ашиглалтыг сайжруулахын тулд үйлдвэрлэлийн аргаар боловсруулж зах зээлд нийлүүлэхийг санал болгосон бол хадгалах хугацааг уртасгах, хатаах, хөлдөөх, өртөг нэмсэн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах цэгийг хүртээмжтэй болгох талаар саналууд гаргажээ.

Дотор мах, дайврыг хүнснээс бусад зориулалтаар ашиглах талаар үйлдвэрлэл хөгжсөн орнуудын туршлагыг судлах, тэдний зохицуулалтын талаарх онцлогийг ойлгох нь дотор мах, дайврын ашиглалт, зах зээлийг тэлэхэд чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. 2021 онд гэрийн тэжээвэр амьтны хоол ба мал амьтны тэжээлийн бэлдцийн олон улсын худалдаа 40.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх жилээс 17.8 хувиар өссөн байна. Энэ төрлийн бүтээгдэхүүн дэлхийн нийт худалдаанд 0.19 хувийг эзэлж, худалдааны эрэмбээр 110-р байранд оржээ.

Олон улсын худалдаанд гэрийн тэжээвэр амьтны хоолны 50.3 хувийг 20.6 тэрбум ам.долларын худалдааны эргэлттэй муур, нохойн хоол эзэлж байгаа бол, 49.7 хувь буюу 20.3 тэрбум ам.долларын худалдааны эргэлтийг гэрийн мал, амьтны тэжээлийн бэлдэц эзэлж байна.

9.1.5. Өмнөд Солонгос, Хятад, Ойрх дорнодын орнуудын дотор махны хэрэглээний зан үйл, эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн байдал

Дотор мах, дайвар бүтээгдэхүүний дэлхийн нийт үйлдвэрлэлийн мэдээ хомс боловч дэлхийн махны салбараас жилд ойролцоогоор 150 сая тонн дайвар бүтээгдэхүүн гардаг тухай мэдээлэл байна.

HS 0206 ангиллын дотор махны зах зээлийн нийт хэмжээ 2022 онд 9.32 тэрбум ам. долларт хүрч дэлхийн хамгийн их худалдаалагдсан 1218 барааны 400-д бичигдэж дэлхийн нийт худалдааны 0.039% болсон байна. Дэлхийн дотор махны зах зээлийн 49.83 хувийг (4.64 тэрбум ам. доллар) үхрийн дотор мах, 47.79 хувийг (4.45 тэрбум ам. доллар) гахайн дотор мах, 2.38 хувийг бусад төрлийн амьтдын (хонь, ямаа, адуу, илжиг, луус, одой морь зэрэг) дотор мах (220 сая ам. доллар) эзэлсэн байна.

Монгол Улсын хувьд дотор махны экспортын сонирхож байгаа зах зээлийн орнууд нь дэлхийн хамгийн том импортлогч болох манай урд хөрш БНХАУ(2.72 тэрбум ам. доллар), улс төр, эдийн засгийн

хувьд сайн харилцаатай Япон (1.02 тэрбум ам. доллар), БНСУ (337.0 сая ам. доллар), Хонг Конг (439.0 сая ам. доллар), Вьетнам (171 сая ам. доллар), хойд хөрш ОХУ (151.0 сая ам. доллар), мөн сонирхож болох зах зээл Филиппин (399,0 сая ам. доллар, энэ улс дотор махны экспорт бараг хийдэггүй), Индонез (167,0 сая ам. доллар) зэрэг орнууд байна.

Персийн булангийн орнуудын хувьд 2022 онд 60.0 сая ам.долларын импорт хийжээ. Эдгээр орнуудын гол түншүүд нь далайн тээвэр хийх боломжтой, амьд мал болон шинэ эсвэл сэврээсэн мах нийлүүлдэг Бразил, Австрали, Шинэ Зеланд улсууд байгаагаас гадна бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, савлах үйл ажиллагаанд “халал” тогтолцоо нэвтрүүлсэн байхыг шаарддаг.

БНХАУ-ын гаалийн мэдээллээр тус улс 2021 онд 2309.10 кодтой гэрийн тэжээвэр амьтны хоол 17.6 мянган тонныг импортолж, худалдан авалтын дүн 114 сая ам.долларт хүрсэн. 2019 оны байдлаар Солонгос улсад 8.6 сая гэрийн тэжээмэл амьтан (2.6 сая муур, 6 сая нохой) бүртгэгдсэн бөгөөд 2019 он хүртэлх таван жилийн өсөлтийн хурд жилд 8 хувь, нохойн тоо толгой жилд 4 хувь байжээ. Евро мониторын мэдээлснээр Солонгосын муурны хүнсний зах зээл 2025 он гэхэд 550.9 сая ам.долларын борлуулалт хийх төлөвтэй, дараагийн 6 жилд жилд дунджаар 6% өснө.

Японы гэрийн тэжээвэр амьтдын хоолны ангилал 5-10 жилийн өмнөхөөс илүү нарийн шаардлагатай болсон байна. Тиймээс, том уутанд савласан, эдийн засгийн хувьд хэмнэлттэй уламжлалт бүтээгдэхүүн гэхээс илүү шинэ, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг урьдал болгож буй тул хэрэглэгчдийн төрөл бүрийн эрэлт хэрэгцээг хангахын тулд нэгж үнэ цэнэ нь ч өндөр байна.

9.1.6. Монгол малын дотор махны өрсөлдөх чадварын үнэлгээ, зорилтот зах зээлд экспортлох боломж

Хүнсний дотор мах, дайвар бүтээгдэхүүний зах зээл нь инновац, төрөлжилтийг тасралтгүй удирддаг гол тоглогчидтой учир ширүүн өрсөлддөгөөрөө онцгойрдог байна. Эдгээр салбарын тэргүүлэгчид завгүй амьдралын хэв маягийн дунд оршиж буй орчин үеийн хэрэглэгчдийн тав тухтай, цаг хугацаа хэмнэх, идэхэд бэлэн сонголтуудыг илүүд үздэгтэй уялдуулан хиам, паште, махан бөмбөлөг зэрэг боловсруулсан махан бүтээгдэхүүнд дотор мах, дайврыг нэгтгэх чиг хандлагыг ашиглаж байна.

Хэрэглээний хувьд боловсруулсан дотор мах, дайврын сегмент хамгийн их хувийг эзэлж байна. Боловсруулалтын явцад дотор махыг янз бүрийн хэлбэрт шилжүүлж, улмаар боловсруулсан махан бүтээгдэхүүнд нэгтгэх нь түүний амт чанарыг дээшлүүлэх боломжтой юм. Энэхүү интеграци нь бүтээгдэхүүнд өвөрмөц амт, шим тэжээлийн баялаг байдлыг бий болгож, шинэлэг, тансаг амтыг эрэлхийлж буй хэрэглэгчдийн сонирхлыг татах болжээ.

БНХАУ, Солонгос, Япон зэрэг орны зах зээлд одоогоор хөргөсөн, хөлдөөсөн хамгийн бага боловсруулалттай дотор мах, дайврыг экспортлох мал эмнэлгийн нөхцөл манай улсын хувьд бүрдээгүй байна. Харин эдгээр орнуудад боловсруулсан дотор мах, дайвар экспортлох боломжтойгоос гадна гэрийн тэжээвэр амьтадын хоол нийлүүлэх боломж байна. Гэхдээ гэрийн тэжээвэр амьтадын хоолны импорт хийхдээ эдгээр орнууд олон янзын тусгай нөхцөл, шаардлагууд тавьдаг гэдгийг анхаарах ёстой.

Ерөнхийдөө дотор мах, дайврын олон улсын зах зээл дээр гахай, үхрийн дотор мах, дайвар үнэмлэхүй их хувийг эзэлж байгааг дээр дурдсан. Монгол Улсын тухайд гахайн мах, дотор мах, дайврыг өөрөө импортлогч улс гэдгээс гадна үхрийн дотор мах, дайврыг экспортлоход мал эмнэлгийн нөхцөл байдал олон асуудалтай тулгарсан хэвээр байна. Мөн бог малын дотор мах, дайврын олон улсын зах зээлийн багтаамж бага бөгөөд уламжлалт экспортлогч нар бидний сонирхлын бүсэд гол тоглолтыг явуулж байна.

Энэ нөхцөлд манай улсын хувьд адууны дотор мах, дайврын экспортыг нэн тэргүүнд дэмжихэд анхаарахын зэрэгцээ үхэр, бог малын дотор мах, дайврын боловсруулалтыг сайжруулж, онилсон зах зээлд онцгой чанарын шинэ бүтээгдэхүүн гаргах, эсвэл дотооддоо боловсруулж, бэлэн болон хагас бэлэн бүтээгдэхүүний хэлбэрт шилжүүлж экспортлох, дотоод зах зээлээ өргөжүүлэх, төрөлжүүлэх, хүнсний бус зориулалтаар дотор мах, дайврын ашиглалтыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Бидний ирээдүйн гол стратеги бол кератин болон коллагеныг дотор мах, дайвраас цэврээр нь гаргаж авах асуудал бөгөөд энэ хоёр төрлийн үургийн эрэлт хэрэгцээ олон улсын зах зээл дээр улам бүр өсөн нэмэгдэж байна. Үүний тулд технологи хөгжүүлэлт, инновацыг гол болгож, энэ чиглэл дэх хамгийн сүүлийн үеийн технологи, шинжлэх ухааны ололт, мэдлэг, мэдээллийг ашиглах шаардлагатай.

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар нь олон улсын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрт нэгдэн орсноор хамтын ажиллагаа, худалдааг дэмжиж, илүү өргөн зах зээлд нэвтрэх боломжийг олгож байна. Дэлхийн зах зээлд, ялангуяа ази тивд малын мах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсээр байна. Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг төрөлжүүлснээр зах зээл өргөжиж экспортын хэмжээ нэмэгдэнэ. Дэлхийн хүн ам органик хүнсний бүтээгдэхүүнд ихээхэн анхаарлаа хандуулж байгаа нөхцөлд бэлчээрийн монгол малын дотор мах, дайвар нь экологийн цэвэр бүтээгдэхүүнд тооцогдож, өрсөлдөх чадвар нь өсөх магадлалтай байна.

Хэрэглэгчийн зан үйлийн чиг хандлага, дадал зуршил нь Монголын хөдөө аж ахуйн салбарт нийгмийн дэмжлэг авах боломжийг бий болгож байна. Нийтийн эрүүл мэндийн боловсрол дээшилж зөвхөн байгалийн гаралтай, эрүүл хүнс хэрэглэх хүсэл, хандлагад нийцсэн бүтээгдэхүүнийг санал болгосноор дэлхийн зах зээлийн шинэ сегментүүдэд нэвтрэх боломж олох юм.

9.1.7. Дотоодын зах зээл дээрх хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглээ

Монгол Улсад импортлогдсон БИБ-ний тоо хэмжээ, үнийн дүн жилээс жилд өсөж, 2022 онд энэ тоо хэмжээ 521.4 тонн, үнийн дүн 31.8 сая ам, доллар болсон байна. Дэлхийн 29 орноос БИБ худалдан авсан ба 2021-2022 оны БИБ-ний импорт 2020 оныхоос хоёр дахин өсжээ.

Асуумжид оролцогчдын 50 гаруй хувь нь хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэдэг гэсэн нь дотоодод ийм төрлийн бүтээгдэхүүний зах зээл бэлэн байгааг харуулж байна. Тэр тусмаа, Монголд үйлдвэрлэсэн ийм бүтээгдэхүүнийг хэрэглэхэд ихэнх хэрэглэгч бэлэн байна.

Үндэсний 27 үйлдвэр давхардсан тоогоор 170 нэр төрлийн БИБ бүртгүүлжээ. Эдгээр бүтээгдэхүүнээс 91 бүтээгдэхүүний хугацаа дуусаж хасагдсан, үйлдвэрлэгч нь тодорхойгүй 77 бүтээгдэхүүн байна. Үндэсний үйлдвэрүүд голчлон ургамлын гаралтай амин дэм С бүхий төрөл бүрийн бэлдмэл, ходоод, бөөр, цөс, элэг, уушгины цай, төрөл бүрийн жимсний үрэл, Алтайн барагшууны ханд зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

ургамлын Монэнзим ХХК, МК Интернейшнел ХХК, Монхимо ХХК, САУП ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг шинэ технологиор боловсруулан биологийн идэвхт бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Манай судлаач, эрдэмтэд (ШУТИС, САМО институт) малын боловсруулсан дотор маханд суурилан биологийн идэвхт бодисын агууламжийг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулж, зарим нэрийн туршилтын бүтээгдэхүүний эрүүл мэндийг дэмжих үйлдлийг тогтоох судалгааг гүйцэтгэжээ.

Хэрэв эдгээр судалгааны дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлбэл одоогоор ашиглаж чадахгүй байгаа малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний асар их нөөцийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлж байгаа төдийгүй жил бүр импортоор авч байгаа 30.0 гаруй сая ам. долларын импортын БИБ-нийг дотоодын бүтээгдэхүүнээр орлуулах боломжтой юм.

9.1.8. Дотор мах, дайврын зах зээлийн судалгаанд хийсэн PESTLE-SWOT шинжилгээ

Бүс нутгийн геополитикийн тогтворгүй байдал ялангуяа түлш, шатахууны импортын хараат байдал нь зах зээлийн тогтворгүй байдлыг үүсгэж салбарын урт хугацааны төлөвлөлт, хөрөнгө оруулалтад эрсдэл учруулж болзошгүй юм. Төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо сул, хэрэгжилт хангалтгүй байна.

Эдийн засгийн онцлох хоёр гол аюулд хурдацтай явагдаж буй хотжилт болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган, зуд, үер зэрэг нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд бэрхшээл учруулж байна. Нэг салбараас хэт хамаарал бүхий эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй, экспорт, импортын хувьд ганц зах зээлээс хараат байдал өндөртэйгөөс гадна малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ муу хөгжсөн.

Эрүүл ахуйн шаардлага хангаагүй мах, дотор мах, дайвар зах зээлд нийлүүлэгдэж хүн амын эрүүл мэнд болон хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх сонирхолтой залуу малчны тоо буурч байгаа, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг нь дотор мах, дайврын үйлдвэрлэл, боловсруулалт, нийлүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Малын эрүүл мэндийн үйлчилгээний хяналтын систем хөгжөөгүй, мал болон түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хөдөлгөөнийг мөшгөх бүртгэл, мэдээллийн ухаалаг систем нэвтрээгүй. Мөн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх технологийн бодлогын шинэчлэлийн эрх зүйн орчин бүрдээгүй байна. Малыг үйлдвэрлэлийн аргаар бараг төхөөрдөггүй, хөлдөөх, дулааны аргаар дотор мах, дайврыг боловсруулах технологи сул хөгжсөн.

Мал төхөөрөх, мах боловсруулах салбарын үйлдвэрлэгчдэд чиглэсэн засгийн газрын татаас, урамшууллын бодлого, түүний шалгуур тодорхой бус байна.

Уур амьсгалын өөрчлөлт хүчтэй явагдаж, хэт халалт, хэт хүйтэн, хуурайшлын улмаас бэлчээр доройтон цөлжих, бэлчээрийн ургамлын ургац буурснаар малын тэжээл хомсдох, бэлчээрлэлт саатах, мал тарга тэвээрэг дутуу авах, улмаар малын амьдын жин буурах, үхэл, хорогдол ихсэх эрсдэл ихсэх хандлагатай байна.

9.2. Дүгнэлт

Монгол Улсын хүнсний дотор мах, дайвар түүхий эдийн өртгийн сүлжээ хангалтгүй судлагдсан, энэ талаарх тоо баримт, мэдээлэл туйлын хомс байна. Манай дотоодын зах зээлийн тухайд дотор мах, дайврын гарал үүсэл тодорхойгүй байх, өнгө үзэмж доогуур, шинэлэг байдалд хэрэглэгчийн итгэл муу байдгаас зах зээл дээрх борлуулалт, түгээлтийг сааруулдаг байна.

Хүнсний дотор мах, дайврын гарцын талаар үндэсний лавлагаа бий болгох зайлшгүй шаардлагатай. Цаашид хүнсний дотор мах, дайврын гарцыг нарийн зөв тогтоож, нөөцийн хэмжээг үнэн зөв үнэлдэг байх, төхөөрч буй малын “хошуунаас сүүл” хүртэлх бүх зүйлийг боловсруулж, бүрэн дүүрэн

ашигладаг болохын тулд “дотор мах, дайвар болон дагалдах түүхий эдийн гарц”-ыг 4 төрлийн мал тус бүр дээр хэмжих нэгдсэн арга зүйг нарийн боловсруулж, намрын мах бэлтгэлийн явцад үйлдвэрүүд дээр жил бүр хэмжилт хийлгэж, дүнг нэгтгэн авч боловсруулалт хийдэг болох шаардлагатай байна.

Дотор мах, дайврын ангиллын үндэсний стандартыг олон улсын нийтлэг чиг хандлага, зарчимд нийцүүлэн өөрчлөх, HS системийн 16 орон хүртэлх кодоор дотор мах, дайврын үйлдвэрлэл, нийлүүлэлтийг бүртгэж, мэдээлдэг болох хэрэгтэй байна.

Дотор мах, дайвар түүхий эдийг хүн амын дийлэнх нь ямар нэг хэмжээгээр хэрэглэдэг нь судалгаанаас харагдсан бөгөөд хэрэглэгчдийн дийлэнх нь дотор махыг тогтвортой хэрэглэдэг гэж дүгнэж болохоор байна. Гагцхүү түүнийг хэрэглэхийн эрүүл мэндийн ач тусын талаарх мэдлэг, мэдээллийг ахиулах шаардлагатай.

Хүн амын дундах дотор махны хэрэглээ багатай хүмүүс бараг бүгдээрээ дотор махны ариун цэвэр, аюулгүй байдал, өнгө үзэмж, шинэлэг байдалд эргэлздэг учраас худалдан авахаас татгалзаж байгааг онцгойлон анхаарч, зах зээлд нийлүүлэх дотор мах, дайврын гарал үүслийг тодорхой болгох, малыг технологийн дагуу үйлдвэрийн аргаар төхөөрч, гэдэс, дотор мах, дайврын ариун цэвэр, аюулгүй байдлыг баталгаатай хангуулж байж зах зээлд гаргадаг “ханган нийлүүлэлт-хяналтын найдвартай тогтолцоо”-г бий болгох хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Өнөөдрийн байдлаар үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан дотор махны хэрэглээ хэрэглэгчдийн дунд маш хязгаарлагдмал байгаа бөгөөд бүтээгдэхүүний савлагаа, өнгө үзэмжийг сайжруулахын зэрэгцээ нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн нөхцөлд хэрэглээ нэмэгдэх нь цаг хугацааны асуудал гэдэг нь асуумж судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас харагдаж байна.

Юуны өмнө Улаанбаатар хотын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл болон нийлүүлэлт, түгээлтийн сүлжээг сайжруулах арга хэмжээ авахын зэрэгцээ Эрдэнэт, Дархан хот, аймгийн төвүүд, томоохон сум, суурины төвүүдэд дотор мах, дайвар бүтээгдэхүүн борлуулдаг зах зээлийн нийлүүлэлтийн сүлжээ үүсгэх талаар анхаарууштай.

Дотор махны хэрэглээг нэмэгдүүлэн түүгээр дамжуулан дотор махны шим тэжээлийг бие организмд өгөх зорилгоор эмнэлэг сувиллын 544 хоолны газар, сургуулийн 1600, дотуур байрны 283, МСҮТ, их дээд сургуулийн 86 цайны газар, цэргийн ангийн 35, хорих ангийн 18 цайны газарт 7 хоногт нэгээс доошгүй удаа дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр амт шим сайтай хоолоор үйлчилж байх тухай зохицуулалтыг зохих хууль, дүрэм, зааварт нэмэлтээр оруулан дотор махны сурталчилгаа, хэрэглээг төрөөс манлайлан дэмжүүштэй байна.

Дотор маханд суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон нийтийн хоол үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар төрийн бодлого тодорхойгүй, салбарын стратеги байхгүй байна. Дотор мах, дайврын ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд дотор махыг тураг махтай нэгтгэх, хагас бэлэн бэлдэц, шууд хэрэглэгдэх бэлэн бүтээгдэхүүний технологийг нутагшуулах, шинэчлэх, энэ талаар гарч байгаа инновацыг дэмжин хөгжүүлэх, дотоод зах зээлийг идэвхжүүлэх, гадаад зах зээлийг тэлэх бодлого хэрэгжүүлэх, эрэлтийг өсгөх, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалт, менежментийг сайжруулах шаардлагатай.

Малын өлөн гэдэсний экспорт болон гэрийн тэжээвэр амьтадын хоол үйлдвэрлэн экспортолж байгаа цөөн тооны хэдхэн мах боловсруулах үйлдвэрийг эс тооцвол гадаад зах зээл дэх нэвтрэлт хангалтгүй байна. Цаашид гадаад зах зээлд нэвтрэх үйл ажиллагааг хүчтэй явуулах, одоо байгаа экспортын зах зээл дээрх байр сууриа бататгаж хадгалах, бүтээгдэхүүний хөгжүүлэлт, төрөлжүүлэлт, брэнд хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх, мал төхөөрөх үйлдвэрийг түшиглэн дотор мах, дайвар түүхий эд

боловсруулдаг жижиг, дунд үйлдвэрийн кластер үүсгэн хөгжүүлэх зэрэг арга хэмжээг Засгийн газрын бодлого, манлайллын дор дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүн амын шим тэжээлийн дутлыг нөхөх, ашиглахгүй хаягдал болж байгаа малын дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг технологийн өндөр түвшинд боловсруулан импортыг орлох БИБ болон зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар Засгийн газраас эсвэл Олон Улсын байгууллагатай хамтарсан тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Манай улсын хувьд аль ч төрлийн дотор мах, дайврыг их хэмжээгээр тасралтгүй экспортлох боломж, нийлүүлэлтийн чадавх байхгүй юм. Энэ тохиолдолд зах зээлийн судалгааг нарийн нягт явуулсны үндсэн дээр тухайн зах зээл дээрх тусгай эрэлт хэрэгцээтэй “niche” зах зээл буюу онилсон хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүнийг бага хэмжээгээр, тасалдалтайгаар нийлүүлдэг байх нь илүү зохимжтой. Ийнхүү бага хэмжээгээр экспорт хийх нь бүтээгдэхүүний чанарт илүү анхаарах боломж олгохын зэрэгцээ төлбөр тооцоо харьцангуй богино хугацаанд хийгдэх, эргэлтийг хурдасгах давуу талтай юм.

Дотор махны ашиглалтыг сайжруулах, экспортлоход чухал нөлөө үзүүлэх өөр нэг хүчин зүйл нь дотор мах, дайврын физик, химийн шинж чанар, аюулгүйн үзүүлэлт, хэрэглээний онцлогийг зөв ойлгох, зөв технологи сонгох, дэвшилтэт арга барилд суралцах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Дайвар бүтээгдэхүүнийг ихэвчлэн техникийн зориулалттайгаар ашиглах хандлага давамгайлж байгаа бөгөөд эдгээрийн дотроос кератин, коллаген уураг онцгой чухал түүхий эд юм.

Хүнсний дотор махны хувьд дэлхийн худалдааны багаахан хувийг эзэлдэг боловч манай орны хувьд авч үзэх юм бол дэлхийн хамгийн том импортлогч нь манай үрд хөрш БНХАУ(2.72 тэрбум ам. доллар), улс төр, эдийн засгийн хувьд сайн харилцаатай Япон (1.02 тэрбум ам. доллар), БНСУ (337.0 сая ам. доллар), Хонг Конг (439.0 сая ам. доллар), Вьетнам (171 сая ам. доллар), хойд хөрш ОХУ (151.0 сая ам. доллар), мөн сонирхож болох зах зээл Филиппин (399,0 сая ам. доллар, энэ улс дотор махны экспорт бараг хийдэггүй), Индонез (167,0 сая ам. доллар) зэрэг орнууд байна.

Газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх, байгальд ээлтэй технологи нэвтрүүлж, ногоон эдийн засгийн зарчмыг баримтлах, үйлдвэрлэлийн ухаалаг системийг хөгжүүлэх нь ирээдүйд үйл ажиллагааны зардал болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хоёуланд нь харилцан үялдаатай шийдвэрлэх чухал ач холбогдолтой.

Бүс нутгийн геополитикийн тогтворгүй байдал ялангуяа түлш, шатахууны импортын хараат байдал нь зах зээлийн тогтворгүй байдлыг үүсгэж салбарын урт хугацааны төлөвлөлт, хөрөнгө оруулалтад эрсдэл учруулж болзошгүй байгааг бүх түвшинд тооцож, анхааралдаа авахыг шардаж байна.

9.3. Зөвлөмж

9.3.1. Дотор махны дотоод зах зээл дээрх хэрэглээг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх талаар өгөх зөвлөмж

Дотор махны дотоод зах зээл дээрх хэрэглээг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх талаар дараах зөвлөмжийг санал болгож байна:

1/ Дотор мах, дайврыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулж зах зээлд нийлүүлдэг эрх зүй, эдийн засгийн зохицуулалт хийхийг судалгааны баг зөвлөж байна. Дотор махны боловсруулалтыг сайжруулах, ариун цэвэр, аюулгүй байдлыг хангуулахын тулд малыг ил задгай орчинд гараар төхөөрдөг хоцрогдсон практикийг халж, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг орон

даяар нэг мөр мөрдүүлж хэвшүүлэх, нийтийн зах зээлд нийлүүлэгдэж байгаа тураг мах, дотор мах, дайврын 70-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж, нийлүүлдэг болох шаардлагатай.

2/ Үйлдвэрийн аргаар бэлтгэж боловсруулсан дотор махны нэр төрөл, савлагааг уламжлалт хэрэглээнд нийцүүлэн, таван цулын шөлний бэлдэц, шавай, зайдас, олгойд хийсэн хиам, гүзээнд хийсэн чанахад бэлэн толгой шийр, дэлүүнд чихсэн хонины сүүл, бод, богийн чихсэн гургалдай зэрэг уламжлалт болон шинэ хэлбэр, нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн сонирхол татахуйц байдлаар цэвэр, үзэмжтэй, сав, баглаа боодолтойгоор зах зээлд нийлүүлдэг болох талаар үйлдвэрлэгчид санал санаачилга гаргаж, шинэ технологи, инновац нэвтрүүлэх хэрэгтэйг зөвлөө.

3/ Дотор махны эрүүл мэндийн ач холбогдол болон түүнийг бэлтгэх, боловсруулах, хэрэглэх арга, хоолны жор, технологийн талаар хүүхэд, залуучуудын дунд явуулах сургалт, сурталчилгааны ажлыг бодлогоор дэмжих шаардлагатай.

4/ Малчид, фермерүүдийн хувьд тусгай захиалгын дагуу өөрийн хэрэглэгчдэд уламжлалт аргаар бэлтгэсэн цувдай, дотор мах, дайврыг хүргэлтээр болон он-лайн худалдаагаар ханган нийлүүлдэг байж болох бөгөөд үүнд хоршоо, мэргэжлийн холбоо, нэрийн барааны дэлгүүрүүд санаачилга гарган хамтран ажиллах боломжтой.

5/ Нийтийн хоолны салбар дотор мах, дайврын хэрэглээг нэмэгдүүлэхэд гол үүрэгтэй оролцогч болох нь бидний судалгаа, олон улсын хэрэглээний практикаас харагдаж байна. Иймд нийтийн хоолны цэсэд дотор мах, дайвраар хийсэн хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, энэ чиглэлд хийх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх нь салбарын хөгжил, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд тустай төдийгүй, нийгмийн хариуцлага сайжруулах нэг алхам болох учиртай.

6/ Хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд чиглэсэн зорилготой сургалт, сурталчилгаа явуулдаг болох, хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, хэрэглээний түвшинг ахиулах, зах зээлийг тэлэх талаар төрөөс явуулах бодлогыг тодорхой болгох, эдгээртэй холбогдуулан тусгайлсан судалгаа явуулах шаардлага байгаа нь илэрхий байна.

9.3.2. Монгол малын дотор махыг зорилтот зах зээлд экспортлох талаар өгөх зөвлөмж

1/ Адууны дотор мах, дайврын экспортыг нэн тэргүүнд дэмжих, үхэр, бог малын дотор мах, дайврын боловсруулалтыг сайжруулж, онилсон зах зээлд онцгой чанарын шинэ бүтээгдэхүүн гаргах, эсвэл дотооддоо боловсруулж, бэлэн болон хагас бэлэн бүтээгдэхүүний хэлбэрт шилжүүлж, хүнсний бэлэн бүтээгдэхүүн, эсвэл гэрийн тэжээвэр амьтадын хоол хэлбэрээр экспортлохыг хичээх;

2/ Кератин болон коллагеныг дотор мах, дайвраас цэврээр нь гаргаж авах асуудалд онцгойлон анхаарах, энэ чиглэлд технологи хөгжүүлэлт, инновацыг гол болгож, хамгийн сүүлийн үеийн технологи, шинжлэх ухааны ололт, мэдлэг, мэдээллийг түгээх, ашиглах асуудал дээр сургалт, судалгааны байгууллагуудын хүч, анхаарлыг төвлөрүүлэхийг зөвлөж байна.

9.3.3. Дотоодын зах зээл дээрх дотор маханд суурилсан хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар өгөх зөвлөмж

1/ Дотор маханд суурилсан эрүүл мэндийг дэмжих зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар шинжлэх ухааны судалгааг нэмэгдүүлэх, дэлхий дахинд ашиглагдаж байгаа тэргүүний дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах арга хэмжээг төрөөс бодлогоор дэмжин зохицуулах

2/ Эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах боломжтой орц, түүхий эдийн нөөц болон бэлэн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, эрх зүй, санхүү, хөрөнгө оруулалтын тааламжтай орчин бүрдүүлэх замаар юуны өмнө дотоодын үйлдвэрлэлийг дэмжих иж бүрэн арга хэмжээ авах

3/ Улсын хэмжээнд гарч байгаа шинэлэг үүсгэл, санаачилгын хүрээнд дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр хийдэг хоолны соёлыг дэлгэрүүлэхээс гадна дотор махны ашиг тусыг нийгэмд сурталчилж болохоор байна. Иймэрхүү арга хэмжээг дотоод, гадаадын аялал жуулчлалын бүс болох Хөвсгөл, Хэнтий, Архангай, Дорноговь, Баян-Өлгий зэрэг аймгуудад эрчимтэй зохион байгуулахын зэрэгцээ жил бүрийн 10 сарын 24-нд зохиогддог “Дэлхийн дотор махны өдөр”-ийг ч бас манай улсад тэмдэглэж хэвшүүлэх нь зүйтэй байна.

4/ Энэ бүлэгт дурдагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл нь мал төхөөрөх үйлдвэрүүдийг түшиглэсэн мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, хүнсний дотор мах, дайвар боловсруулах үйлдвэрлэл, мах бэлтгэлийн бусад дайвар, хаягдал боловсруулах үйлдвэрлэл, биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нарын хоршилт үүсгэсэн “кластер” тогтолцоог Улаанбаатар хот болон орон нутагт үүсгэн байгуулах явдал бөгөөд энэхүү санаачилгыг манлайлан зохион байгуулахыг Засгийн газарт зөвлөмж болгож байна.

5/ Цаашид хүнсний дотор мах, дайварын гарцыг нарийн зөв тогтоож, нөөцийн хэмжээг үнэн зөв үнэлдэг байх, төхөөрч буй малын “хошуунаас сүүл” хүртэлх бүх зүйлийг боловсруулж, бүрэн дүүрэн ашигладаг болохын тулд “дотор мах, дайвар болон дагалдах түүхий эдийн гарц”-ыг 4 төрлийн мал тус бүр дээр хэмжих нэгдсэн арга зүйг нарийн боловсруулж, намрын мах бэлтгэлийн явцад үйлдвэрүүд дээр жил бүр хэмжилт хийлгэж, дүнг нэгтгэн авч боловсруулалт хийдэг болох шаардлагатай байна.

6/ Дотоодын хэрэглэгчдэд дотор махны хүнс тэжээлийн үнэт чанарын талаар нэгдсэн журмаар сурталчлах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, аюулгүй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь мэдлэг, дадлага олгох сургалтын нэгдсэн платформ үүсгэх нь дотор мах, дайвар түүхий эдийн борлуулалтыг идэвхжүүлэх арга зам юм.

7/ Цаашид дотор мах, дайвар бүтээгдэхүүний хоол, хүнсний хэрэглээ, хэрэгцээг томоохон их, дээд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, цэргийн анги, хорих ангиуд зэрэг хоолны газруудыг хамруулан томоохон хэмжээний судалгаа хийж жилд улсын хэмжээнд хэрэглэгдэх дотор мах, дайвар бүтээгдэхүүний тоо хэмжээг гаргах, цаашид экспортлох боломжийг судлах шаардлагатай байна. Ялангуяа хүнсний хэрэглээнд адууны дайвар бүтээгдэхүүнийг (үмс, хятай, каз гэх мэт) монголчууд нэлээдгүй хэрэглэдэг мөртөө ресторан, гуанз цайны газрын хоолны цэсэд адууны дайвар бүтээгдэхүүний нэр төрөл бараг байхгүй байна.

8/ Дотор махны ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэхэд БНХАУ-тай дайвар бүтээгдэхүүний мал эмнэлэг ариун цэврийн протоколыг тохирох шаардлагатай байна. Гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэлд илүү анхаарч энэ чиглэлийн импортлогч компаниудтай холбоо харилцаа тогтоох шаардлага байна.

БҮЛЭГ 10. МОНГОЛ УЛСЫН ДОТОР МАХ, ДАЙВАР ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАГВАР

10.1. Зах зээлийн хүрээ (сегментчилэл)

Хүснэгт 60. Монгол Улсын дотор мах, дайврын зах зээлийн сегментчиллийг бүлэглэсэн бүдүүвч

Эх үүсвэр	Нийлүүлэлтийн хүрээ	Боловсруулалтын хүрээ	Хэрэглээний хүрээ	Түгээлтийн хүрээ
Үхэр	Ченж	Уламжлалт аргаар	Шинээр нь, хөргөсөн	Жижиглэн худалдаа
Адуу	Бөөний худалдаа	Үйлдвэрт боловсруулсан	Хөлдөөж хадгалсан	Нийтийн хоол
Хонь	Он-лайн худалдаа		Хагас бэлэн бүтээгдэхүүн	
ямаа	Захиалгат хүргэлт		Эцсийн бэлэн бүтээгдэхүүн	

Дээрх хүснэгтэд манай улсын дотор мах, дайврын зах зээлийн сегментчиллийг бүлэглэсэн болно.

Хүснэгт 61. Эх үүсвэрээр ангилсан дотор мах, дайврын ашиглах нөөцийн хэмжээ, 2024-2030 оны төсөөлөл (биет жин тн; үнэ мян.ам.долл)

Үзүүлэлт		2024	2025	2026	2027	2028	2029	2030
үхэр	жин	54063.7	55858	56603.4	51575.7	53055.4	54260.9	3378.0
	үнэ	50279.2	51947.9	52641.2	47965.4	49341.5	50462.6	3141.5
үхэр	жин	3236.6	3175.2	3277.6	3112.2	3079.1	8207.3	49447.3
	үнэ	1942	1905.1	1966.6	1867.3	1847.5	4924.4	29668.4
хонь	жин	118511	112785.1	109592.4	106592.4	105424.4	103576.3	89239.9
	үнэ	68736.4	65415.4	63563.6	61823.6	61146.2	60074.3	51759.1
ямаа	жин	71956.6	67495.7	67860.7	65699.4	64355.9	60953	69786.6
	үнэ	41734.8	39147.5	39359.2	38105.7	37326.4	35352.7	40476.2
Бүгд	жин	247767.9	239314	237334.1	226979.7	225914.8	226997.5	211851.8
	үнэ	162692.4	158415.9	157530.6	149762	149661.6	150814	125045.2

Нэг тонн дотор мах, дайврын үнэ (2023 он)			
үхэр	адуу	хонь	ямаа
\$930	\$600	\$580	\$580

Дээрх хүснэгтэд манай судалгааны багаас эх үүсвэрээр ангилсан дотор мах, дайврын нөөцийн хэмжээг 2024-2030 он хүртэл төсөөлж тооцоолсон болно.

Хүснэгт 62. Боловсруулах боломжит дотор мах, дайврын хэмжээний талаарх төсөөлөл, биет жин: тн-оор

Боловсруулалтын түвшин	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Нийт нөөцийн хэмжээ	247767.9	239314	237334.1	226979.7	225914.8	226997.5	211851.8
Үйлдвэрийн аргаар бэлтгэх	44598.2	59828.5	78320.3	90791.9	108439.1	127118.6	137331.2
Уламжлалт аргаар бэлтгэх	32209.8	28717.7	28480.1	27237.6	27109.8	27239.7	25803.2
Үйлдвэрт боловсруулсан дотор махны эзлэх хувь	18	25	33	40	48	56	64.8
Ашиглалтгүй хаягдсан	170960	150768	130534	108950	90366	72639	48717

Ашиглалтын хувь	31	37	45	52	60	68	77
-----------------	----	----	----	----	----	----	----

Дээрх хүснэгтээс харахад 2024-2030 он хүртэл боловсруулах боломжтой дотор мах, дайврын хэмжээний талаар судалгааны багаас тооцсон тооцоогоор ашиглалт жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 63. Монгол Улсын дотор мах, дайврын хэрэглээний хүрэн дэх бүлэглэл ба зах зээлд нийлүүлэх дотор мах, дайврын тоо хэмжээний талаарх төсөөлөл

Үзүүлэлт	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Нийт нөөцийн хэмжээ, тн	247767.9	239314	237334.1	226979.7	225914.8	226997.5	211851.8
Хөлдөөж хадгалан хэрэглэх	18789	16752	16613.4	15888.6	15814	15889.8	15051.9
Шинээр нь хэрэглэх	13420.8	11965.7	11866.7	11349	11295.8	11349.9	10751.3
Хагас бэлэн бүтээгдэхүүн	25438.8	27400	30300	30600	32000	35000	40000
Эцсийн бэлэн бүтээгдэхүүн	17000	18300	20200	20600	25000	27000	29000
Гэрийн тэжээвэр амьтны хоол	500.0	550.0	600.0	650.0	700.0	750.0	800.0
Экспорт	1700.0	13600	27200	38800	50700	65000	67500
Дүн	44598.2	59828.5	78320.3	90791.9	108439.1	127118.6	137331.2

Судалгааны багаас тооцож гаргасан дээрх хүснэгтээс харахад дотор мах дайврыг сайтар цэвэрлэж шинээр, хөлдөөсөн байдлаар, хагас бэлэн бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүн, гэрийн тэжээвэр амьтны хоол, экспорт зэрэг зах зээлийн хэрэглээнд тохируулан гаргах боломж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 64. Түгээлтийн сувгууд дахь борлуулалтын орлогын талаарх төсөөлөл (мян. ам.долл.)


Үзүүлэлт	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Жижиглэн худалдаа-80%	59122	58938	62552	62123	66616	70678	75084
Нийтийн хоолны худалдаа 20%	9755	9725	10321	10250	10992	11662	12390
Борлуулалтын нийт дүн	68877	68663	72873	72373	77068	82340	87474

Судалгааны багаас тооцож гаргасан дээрх хүснэгтээс харахад дотор мах дайвар бүтээгдэхүүнийг борлуулахдаа жижиглэн худалгаагаар 80 хувийг нийтийн хоолны худалгаагаар 20 хувийг борлуулна гэж тооцоход жил ирэх тусам борлуулалтын орлого нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

10.2. Дотор мах, дайврын нийлүүлэлт, ашиглалт, хэрэглээний ерөнхий зураглал

Дүрслэл 4-д мал, амьтныг “толгойноос сүүл хүртэл ашиглах” үзэл санааны дагуу мал төхөөрөлтийн явцад гаргах бүх дотор мах, дайвар, бусад хаягдлыг боловсруулж, өртөг шингээн бүтээгдэхүүн болгон ашиглах ерөнхий бүдүүвчийг зураглаж харууллаа.

Одоогоор манай үйлдвэрүүд элэг, зүрх, хэл, уушги, дэлүү, ходоод, гэдэс, гүзээ, хэрхнэг, сархинаг зэрэг хүнсний дотор мах, толгой, яс, өөх зэрэг дайврыг ямар нэг хэмжээгээр зах зээлд нийлүүлж байгаа хэдий ч цагаан хоолой, шийр, бүлчирхай, цус, эвэр, туруу, сэвс, гэдэс дотрын агуулагдахуун, хээл, дэлэн, чив, сэлдээ болон цэвэрлэгээний өвдөл цөвдөл хаягдал зэргийг огт ашиглахгүй байгаа билээ.



Эх сурвалж: Судалгааны багийн гаргасан зураглал

Дүрслэл 4. Дотор мах, дайврын нийлүүлэлт, ашиглалтын хэлхээний ерөнхий бүдүүвч

Мөн богтос, хүзүү, шаант зэрэг гулууз махны ангилал зэрэглэлд ордоггүй зүйлүүдийг дайврын ангилалд оруулж тооцож байгааг зурагт тусгаж харуулахыг хичээлээ.

Цаашид Монгол Улсын дотор мах, дайвар түүхий эдийн үндэсний стандартад энэ мэт өөрчлөлтийг оруулж, үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалтын шатанд аль болох өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нөөцийг хаягдалгүй ашиглах, байгаль орчны бохирдлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дотор мах, дайврын нийлүүлэлт, ашиглалт, хэрэглээний ерөнхий зураглалыг судалгааны баг дүрслэл 4-д зохиомжлон харуулахыг хичээв. Энэ нь дэлхий бусад орнуудад баримталж байгаа нийтлэг зарчим, схемтэй нийцэж байгаа болно.

10.3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын гадаад болон дотоод зах зээл, өртгийн сүлжээг хөгжүүлэх дунд хугацааны стратегийн төлөвлөгөө

Стратегийн зорилт 1. Монгол улсын хүнсний дотор мах, дайврын өртгийн сүлжээг хөгжүүлэх

Үнэ цэнийг олж авах: Үр ашгийг дээшлүүлэх замаар илүү их үнэ цэнийг бий болгох		
Үйл ажиллагааны хувилбар	Хэрэгжүүлэх арга зам	Үйл ажиллагааны зорилт

<p>Мал аж ахуйн маркетингийг сайжруулж, зуучлагчдын тоог цөөрүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Малын дуудлага худалдаа явуулдаг болох, үр дүн, үр нөлөөг сайжруулах; -Малын худалдааны дижитал платформыг хөгжүүлэх; - Мал аж ахуйн маркетингийн хувийн хэвшлийн нэгжүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - Малчид болон мал төхөөрөх газар/мах боловсруулах үйлдвэрийн хооронд урт хугацааны гэрээт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - Зуучлагчд (Ченж)-ын статусыг албажуулах. 	<p>Малчдыг худалдан авагчидтай холбох, мал, мах болон малын дайвар бүтээгдэхүүний худалдаа хийх худалдааны цахим платформыг хөгжүүлэх;</p> <p>Малын маркетингийн хувийн хэвшлийн аж ахуй (ММАА / PLMU) хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>Орон нутагт малын дуудлага худалдааг дэмжин хөгжүүлэх;</p> <p>Албан ёсны гэрээнд үндэслэгдсэн хамтын ажиллагааны ашиг тусын талаар малчид, худалдаачид, мал төхөөрөх, мах боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийг хамарсан сургалт, олон нийтийн сурталчилгааны ажлыг зохион байгуулах;</p> <p>Малыг зах зээлд борлуулах ажлыг хамтын ажиллагааны гэрээнд үндэслэсэн шударга харилцаанд оруулахад чиглэгдсэн эрх зүй, эдийн засгийн таатай бүрдүүлэх, үүнд малчдыг чадавхжуулах зорилгоор гэрээний менежментийн чиглэлээр сургалт явуулах;</p> <p>Малчид, малын худалдаачид болон мал төхөөрөх үйлдвэрүүдийн хооронд харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ зохион явуулах;</p> <p>Талуудын хариуцлага, үнэ, чанарын стандарт, маргаан шийдвэрлэх арга зам зэрэг асуудлуудыг тодорхой заасан гэрээ хэлэлцээрийн эх загвар боловсруулах, гарын авлага гаргах зэргээр дэмжлэг үзүүлэх;</p> <p>Албан ёсны гэрээт харилцаанд оролцож буй малчдын хоршоо, бүлгүүдэд санхүүгийн урамшуулал, буцалтгүй тусламж, татаас, зээлийн хөнгөлөлт зэргийг санал болгох.</p>
<p>Үнэ цэнийг бүтээх: Зах зээлийн нэвтрэлтийг сайжруулах</p>		
<p>Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, дотор мах, дайврыг боловсруулах шинэлэг технологийг нэвтрүүлэх</p>	<p>Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, дотор мах оруулсан хиам, нөөшилсөн мах, хатаасан мах, бэлэн хоол зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгохын тулд операторуудыг солих, шинэ технологи, тоног төхөөрөмжтэй болоход нь туслах.</p>	<p>Үйлдвэрлэлийн байгууламжаа шинэчлэх замаар олон улсын стандарт болон шинэ технологи нэвтрүүлсэн мал төхөөрөх газар, мах боловсруулах үйлдвэрүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, бага хүүтэй зээл олгох, техникийн туслалцаа үзүүлэх замаар дотор мах, дайврын салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих;</p> <p>Мах боловсруулах төслүүдийн эрэлт хэрэгцээнд тохирсон зээлийн хөтөлбөр боловсруулах, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж санхүүжилтийг хялбар хүртэх боломжийг эрэлхийлэх;</p> <p>Боломжит хөрөнгө оруулагчдад зориулан дотор мах, дайвар боловсруулах байгууламжийг үр дүнтэй төлөвлөх, зураг төсөл боловсруулах, удирдан зохион байгуулах чадавхаа бэхжүүлэхэд нь тусламж үзүүлэх;</p> <p>Төр-хувийн хэвлийн түншлэлд үндэслэн дотор мах, дайвар боловсруулах төслүүдэд хийх хамтарсан хөрөнгө оруулалтыг дэмжих.</p>
<p>Мэргэшсэн ажилчдын хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>Дотор мах, дайврын боловсруулалт, сав баглаа боодлыг олон улсын жишигт хүргэн сайжруулах, нэмүү өртөг шингээх чиглэлээр дотор мах, дайврын салбарын ажилтан,</p>	<p>Мал төхөөрөх газрын ажилчид, хүнсний технологич, инженер-техникийн ажилчид, бизнес, менежментийн мэргэжилтнүүдийн үр чадварыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагад үнэлгээ хийж, мах боловсруулах болон дотор мах, дайвар боловсруулах технологийн чиглэлээр МСҮТ-</p>

	<p>мэргэжилтнүүдийг тусгайлан сургах байнгын курсууд ажиллуулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>үүдийг оролцуулан үр чадварыг сайжруулах иж бүрэн цогц хөтөлбөр боловсруулах; Өнөөгийн болон ирээдүйн үр чадварын шаардлагыг тодорхойлох зорилгоор салбарын оролцогч талуудтай (жишээлбэл, мах боловсруулах үйлдвэрүүд, мал төхөөрөх газар, мэргэжлийн холбоо) хамтран эрэлт хэрэгцээний үнэлгээ хийх; Ажлын байран дээрх сургалт, семинарт зориулан олон улсын байгууллага, мэргэжилтэн, сайн дурын зөвлөхүүдтэй хамтран ажиллах; Маж боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дээр цалинтай дадлагажих, дагалдангаар ажил хийх, ажилд зүүчлэх нөхцөлийн хангах.</p>
<p>Зорилтот зах зээлийн талаарх үндэсний лавлагаа мэдээллийн сантай болох, хүртээмжийг сайжруулах</p>	<p>- Мах, махан бүтээгдэхүүн, дотор мах, дайврын олон улсын зах зээлийн талаарх мэдээллийг цаг алдалгүй хангадаг үндэсний цахим мэдээллийн нэгдсэн платформ (лавлах)-ыг хөгжүүлэх; - МҮХАҮТ, ММХ, Мал аж ахуйн судалгааны хүрээлэнгийн дэргэд мах, дотор мах, дайврын зах зээлийн судалгааны төрөлжсөн нэгжүүдийг байгуулах</p>	<p>Төрөл бүрийн махан бүтээгдэхүүний үнэ, эрэлтийн чиг хандлага, ханган нийлүүлэлтийн түвшин, зах зээлийн хэлбэлзэл зэргийг хамруулсан зах зээлийн бодит цагийн мэдээлэл; Хэрэглэгчийн сонголтууд, шинээр гарч ирж буй чиг хандлагууд зэргийг хамруулсан зах зээлийн дүн шинжилгээ; Холбоо барих мэдээлэл болон зах зээлийн зорилтуудыг нь тусгасан мал төхөөрөх газрууд, боловсруулах үйлдвэрүүд, мах импортлогч, экспортлогч компаниудын нэгдсэн лавлах; Зорилтот зах зээлүүдэд зориулсан чанарын стандартууд, гэрчилгээнүүд, нийцлийн хүрээнд тавигддаг шаардлагууд, түгээлтийн суваг зэргийн талаарх мэдээлэл; Импорт/экспортын эрх зүйн зохицуулалт, тариф, худалдааны гэрээ хэлэлцээрүүдийн хураангуй дүгнэлтүүд; Мах, дотор мах, дайвар боловсруулах, чанарын хяналт, хүнсний аюулгүй байдал, салбарын шилдэг арга туршлага зэрэгтэй холбоотой сургалтын материал, нөөц эх үүсвэрийн хүртээмж; Зах зээлд нэвтрэх гарын авлагыг боловсруулах: Зохицуулалтын хэрэгцээ, шаардлага, соёлын асуудал, түгээлтийн сувгууд зэрэг тодорхой зах зээлд нэвтрэх зааварчилгаа; МҮХАҮТ, ММХ, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дэргэд маркетингийн судалгааны төрөлжсөн нэгжүүдийг байгуулж, тэдгээрийн хамтын ажиллагаа, үялдааг хангах.</p>

Стратегийн зорилт 2. Монгол Улсын хүнсний дотор мах, дайвраар хийсэн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн сурталчилгааг хүчтэй болгох, үндэсний брэнд хөгжүүлэх

Үйл ажиллагааны хувилбар	Хэрэгжүүлэх арга зам	Үйл ажиллагааны зорилт
Гадаад зах зээл дээрх үйл ажиллагааг идэвхжүүлэх	Дотор мах, дайвар боловсруулах үйлдвэрүүдийг олон улсын үзэсгэлэн	Зорилтот зах зээлийн улсад зохиогдож байгаа олон улсын 2-оос доошгүй томоохон худалдааны болон хүнсний үзэсгэлэнд дотор мах, дайвар боловсруулах компаниудыг

	худалдаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэх.	Засгийн газар, эсвэл олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр оролцуулах. ажлыг баталгаажуулах
	Дипломат болон худалдааны төлөөлөгчийн газрын ажилтнууд Монгол Улсын хүнсний дотор мах, дайвраар хийсэн махан бүтээгдэхүүн, ГТА-ны хоолны брэнд, худалдааг сурталчлах тодорхой үүрэгтэй болгох	Хилийн чанадад суугаа дипломат болон худалдааны төлөөлөгчийн газрын ажилтнуудыг дотор мах, дайвраар хийсэн үндэсний брэнд, хоёр талын мал эмнэлгийн гэрээ/протоколын чиглэлээр сургаж, чадавхжуулах.
Монгол малын дотор мах, дайвраар хийсэн бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах	Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын өвөрмөц шинж чанар, онцлогийг харуулахын тулд брэнд, маркетингийн стратеги хэрэгжүүлэх;	Монгол малын дотор мах, дайвраар хийсэн бүтээгдэхүүний үндэсний брэндийн өвөрмөц стратегийг боловсруулж сурталчлах; Дотор мах, дайврын ил тод ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгохын тулд хэрэглэгчдэд гарал үүсэл, үйлдвэрлэл, боловсруулалтын талаарх мэдээллийг харуулдаг, фермээс зоогийн ширээ хүртэлх бүх зам мөрийг нь QR кодоор мөшгөн хянах боломжийг олгох; Монгол малын дотор мах, дайврын өвөрмөц шинж чанарыг дотоод, гадаадын хэрэглэгчдэд таниулах зорилтот маркетингийн кампанит ажил өрнүүлэх.
Монгол Улсын хүнсний дотор мах, дайвраар хийсэн бүтээгдэхүүний үндэсний брэндийн өвөрмөц стратегийг боловсруулж сурталчлах	Брэндийн онцлогийг тодорхойлсон байна -Чанарын стандарт, гэрчилгээг чанд дагаж мөрдөх Зорилтот маркетингийн кампанит ажил боловсруулах	Монгол Улсын хүнсний дотор махны үйлдвэрлэлийн мөн чанарыг шингээж, байгалийн гаралтай, өндөр чанартай, уламжлалт соёлын баялаг шинж чанарыг агуулсан өвөрмөц брэндийг боловсруулан гаргах. Үүний тулд брэндийн хүчтэй өгүүлэмжийг найруулж сэтгэл татам сав баглаа боодол зохиох шаардлагатай. Бүтээгдэхүүний нэгэн жигд чанар, аюулгүй байдлыг хэвийн түвшинд байлгах, хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд органик ба халал чанарын стандартууд, гэрчилгээнүүдийн нөхцөлийг дагаж мөрдөж ажиллах; Ил тод ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгохын тулд хэрэглэгчдэд гарал үүсэл, үйлдвэрлэл, боловсруулалтын талаарх мэдээллийг харуулдаг, фермээс зоогийн ширээ хүртэлх бүх зам мөрийг нь QR кодоор мөшгөн хянах боломжийг олгох; Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын өвөрмөц шинж чанарыг дотоод, гадаадын хэрэглэгчдэд харуулах, зорилтот маркетингийн кампанит ажил өрнүүлэх.

Стратегийн зорилт 3. Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын чанар, аюулгүй байдлын баталгааг бий болгох

Үйл ажиллагааны хувилбар	Хэрэгжүүлэх арга зам	Үйл ажиллагааны зорилт
Чанарын дэд бүтцийн тогтолцоог худалдан авагчдын шаардлагад нийцүүлэн бэхжүүлэх	Мах, Махан бүтээгдэхүүн, дайварт тавих импортлогч орнуудын шаардлагад үндэсний стандартын шаардлагуудыг нийцүүлэх, тэр дотроо ISO/ IEC 17025 стандартын дагуу итгэмжлүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх	Мах, махан бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдалд тавигддаг олон улсын зохих стандартуудыг судлах. Үүнд БНХАУ, ОХУ, Казахстан, Узбекистан, Персийн булан, Арабын хамтын ажиллагааны зөвлөлийн орнууд (GCC), Европын Холбоо, Япон, Өмнөд Солонгос зэрэг гол зах зээлүүдэд ашиглагддаг чанарын чухал үзүүлэлтүүдийг судлах;
Олон улсын стандартад нийцүүлэн дотор мах, дайвар бүтээгдэхүүний үндэсний стандартын үзүүлэлтүүдийг эргэн харж, шинэчлэх.	2025 он гэхэд дотор мах болон дайвар бүтээгдэхүүний үндэсний стандартын техникийн шинэчилсэн заалтуудыг мөрдөж эхлэх	Стандартын шинэ үзүүлэлтүүдийг дотор мах, дайвар боловсруулдаг үйлдвэрүүд, экспортлогчид болон төрийн байгууллагуудад түгээх.
Лалын шашинтнуудын зах зээлд зориулан Халал сертификатыг хөгжүүлэх	2025 оны эцэс гэхэд Монгол улсын Халал Гэрчилгээжүүлэлт болон Халал стандарт батлагдсан байх; 2025 оны эцэс гэхэд наад зах нь Халал баталгаажуулалтын 1 байгууллагыг олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн байх.	Иран болон Персийн булан, Арабын хамтын ажиллагааны зөвлөлийн (GCC)-ийн орнуудыг хамруулсан Мусульманчуудын зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хүнсний дотор мах, дайврын боловсруулалтад нэвтрүүлснээр Халал гэрчилгээ, болон Халал стандартын хөгжлийг хурдасгах; Халалыг магадлан итгэмжилдэг олон улсын байгууллагуудтай гэрээ, эсвэл арилцан ойлголцлын санамж бичиг байгуулах замаар Монгол Улсын Халал баталгаажуулалтын байгууллагуудыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг хангах; Халал стандартаар бэлтгэсэн, хүнсний шинэ болон хөлдөөсөн дотор мах, дайвар, эсвэл тэдээрийг оролцуулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалган нягтлах байцаагчдыг сургаж бэлтгэх; MNS Халал хүнсэнд тавигдах ерөнхий шаардлагын стандартыг боловсруулах ажлыг эрчимжүүлэх, Халал гэрчилгээний төсөлд олон нийтийн саналыг авах ажлыг шуурхайлуулах.
Дотоодын зах зээлд аюулгүй дотор мах, дайвар нийлүүлэх боломжийг хангах	- Мал төхөөрөх газар, дотор мах, дайвар боловсруулах компаниудад хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүштай мөрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	НАССР, ISO22000, GMP гэрчилгээнүүдийг олгож байгаа тохирлын үнэлгээний байгууллагуудыг баталгаажуулалтын журамд нийцэн ажиллаж байгаа эсэхэд үнэлгээ хийх, чадавхыг бэхжүүлэх.

Төгсөв.

А. Дотоод эх сурвалж

1. “Адуу судлал 50 жилд” МААЭШХ-ийн 50 жилийн ойд зориулсан эмхэтгэл, УБ, Мөнхийн үсэг ХХК, 2011 он;
2. Алтангэрэл Д. Монгол хонь, ямааны амьдын жингийн улирлын хөдлөл зүй, Мал аж ахуйн шинжлэл эмхэтгэл, 2014 он;
3. Алтангэрэл Д. Үхрийн мах, сүүг үйлдвэрлэхэд анхаарах зүйл, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 1, 1986 он;
4. Бадамханд Г. Адууны мах, махан бүтээгдэхүүний чанарын зарим судалгаа, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бүтээл, № 35, 2013 он;
5. Бадамханд Л. Дотор махны шинж чанар, найрлага, боловсруулах технологи, УБ, Хөх Монгол Принтинг ХХК-д хэвлэсэн,он;
6. Балдандаш Л., Нямаа Я. Монгол хонины махны нөөцийг нэмэгдүүлэх боломж, УБ, ШУАХ, 1978 он;
7. Батдорж Д. Хангай, орхон, монгол үүлдрийн хонины өсөлт хөгжилт, махан ашиг шим, Мал аж ахуйн шинжлэл эмхэтгэл, 2014 он;
8. Бат-Эрдэнэ Т. Монгол үүлдрийн сарлаг, УБ, 2002 он;
9. Баясгалан Н. Хурганы өсөлтөд улирлын хамаарал, Хөдөө аж ахуй сэтгүүл, №1, 1980 он;
10. Биологийн идэвхит хүнсний нэмэлт (БИХН)-ийн экспорт, импортын статистик үзүүлэлт 2020, 2021, 2022, 2023 (ҮСХ);
11. ГЕГ, ХХААХҮЯ-ны махны экспортын мэдээлэл;
12. Гомбодорж Ж. Халимаг үхрийг оновчтой ашиглах асуудалд, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 3, 1990 он;
13. Гончиг Д. Орчин үеийн үхрийн аж ахуй, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны цуврал, боть № 3, 1983 он;
14. Гончиг Д. Үхрийн махан ашиг шим, түүний чанарын тухай, УБ, ШУА-ийн хэвлэх, 1979 он;
15. Гончигжав З. Мах-өөхний хэвшлийн үзэмчин хонь, УБ, УХГ, 1990 он;
16. Гончигжав З. Хонины аж ахуй, Улаанбаатар, Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэр, 1980 он;
17. Дамдинсүрэн Л. “Монгол улсын хүнсний аж үйлдвэрийн түүхэн замнал, хөгжлийн ирээдүй”, УБ, 2010 он;
18. Дамдинсүрэн Л., “Хүнсний нөөц, хангамжийн суурь үзүүлэлтүүдийн үндэслэл”, Хүн ба хүнс сэтгүүл, №2, 2020 он;
19. Дамдинсүрэн Л., Алимаа Ж., Батуева “Бэлчээрийн малын гаралтай БИХНБ, бэлдмэл үйлдвэрлэлийн асуудалд” Хүн ба хүнс сэтгүүл №4, 2012 он;
20. Дамдинсүрэн Л., Сэлэнгэ Ц. “Бэлчээрийн Монгол малын махны хэрэглээний шинж чанар, онцлог” УБ, 2011 он;
21. Дэмбэрэл Ш. Бакей А. Хонины махан ашиг шим ба экспортыг нэмэгдүүлэх боломж, Бага хурлын хэлэлцүүлгийн эмхэтгэл, 2018 он;
22. Дугаржав С. Үхрийн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга Хөдөө аж ахуй сэтгүүл, №1 1987 он;
23. Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл <https://lawforum.parliament.mn/project/157/>
24. Зөвшөөрлийн тухай хууль (<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530780109311>)
25. Лхагважав Э., Д. Намсрай Ямааны махны ашиг шим, Хөдөө аж ахуй сэтгүүл, №1, 1980 он
26. Малын тооны статистик үзүүлэлт 2022 (ҮСХ);
27. Лхагвасүрэн С. Махны үйлдвэрлэл, экспортонд тавигдах технологи, эрүүл ахуйн шаардлага, мал эмнэлгийн хяналт, 2016 он

28. Малын дотор мах, дайвар бүтээгдэхүүний экспорт, импортын статистик үзүүлэлт 2020, 2021, 2022, 2023 (ҮСХ);
29. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт, Засгийн газрын 2022 оны 6-р сарын 8-ны 224-р тогтоолын хавсралт;
30. МЭЕГ-ын Мал эмнэлгийн нэгдсэн систем;
31. Монголд махны үйлдвэрлэл үүсэж хөгжсөн он цагийн бичээс, Монголын Махны Холбоо, УБ, 2012 он;
32. Минжигдорж Б., Самбуу Г. Монгол хонь, 20 боть цуврал, боть № 9, 2012 он;
33. Минжигдорж Б. “Монгол хонийг махны чиглэлээр сонгон үржүүлэх онол, арга зүйн үндэс” диссертаци, 1996 он;
34. Минжигдорж Б. Монгол хонины өсөлт, махан ашиг шим, УБ, Армийн хэвлэх үйлдвэр, 1977 он;
35. Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар, мах, дайвар бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ 2023 он
36. Монгол улсын стандарт MNS 6648 : 2016 Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага <https://estandard.gov.mn/standard>
37. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, хүнсэнд хэрэглэсэн малын тоо төрлөөр 2023 он
38. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, дотор мах дайвар бүтээгдэхүүний экспорт импортын тоон мэдээлэл, сүүлийн 4 жилээр, 2023 он
39. Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудал судалгааны тайлан 2016-2017 (ЭМЯ, НЭМХ)
40. Мягмарсүрэн “Малын гаралтай БИХН-ий бодисын түүхий эдийн судалгаа”, Хүн ба хүнс сэтгүүл, №1, 2018 он;
41. Наваанчимэд Н. Махны үхрийн аж ахуйн эрдэм шинжилгээний ажлын дүн, тоймоос Хөдөө аж ахуй сэтгүүл, №2 1983 он;
42. Редактор Лхагва Л., “Хүнс судлал-50” Монгол Улсын Хүнсний аж үйлдвэрийн салбарын ууган эрдэм шинжилгээний байгууллага: 50 жил цомог, Улаанбаатар, Мөнхийн үсэг ХХК-д хэвлэсэн, 2022 он;
43. Надмид Н. Ямааны аж ахуй, Улаанбаатар, Адмон принтинг, 2019 он;
44. Нэргүй Д. Бордсон бярууны махан ашиг шим, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 4, 1990 он;
45. Рэгдэл Д., Энхтүяа Б. Бэлчээрийн монгол малын мах, Улаанбаатар, Соёмбо Принтинг, 2012 он;
46. Сайполда Т. Адуу судлал, УБ, Соёмбо Принтинг, 2019 он;
47. Самданжамц Д., Сайполда Т. Монгол адуу, “Монголын бэлчээрийн мал аж ахуй” 20 боть цуврал, боть № 7, 2011 он;
48. Сайполда Т. Монгол адууг махлаг шинжээр нь сонгон үржүүлсэн туршлагын дүн, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бүтээл, № 35, 2013 он;
49. Самбуу Г. Төлөгний таргалах чадвар, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 1, 1982 он;
50. Самданжамц Д. Адууны аж ахуйн ашиг шим, өсгөх хэтийн төлөв, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 1, 1988 он;
51. САМО Институт, “Дотор маханд суурилсан шинэ бүтээгдэхүүн-Эрдэс-1 бэлдмэл”, Хүн ба хүнс сэтгүүл, №2, 2012 он;
52. Сосоржав Ж. нар “Малын хишиг, Мах махан бүтээгдэхүүн” гарын авлага, УБ, 2016 он;
53. Сэлэнгэ Ц., “БИХНБ -ний зах зээлийн судалгааны тойм”, Хүн ба хүнс сэтгүүл, №3, 2017 он;
54. “Үхэр, сарлаг судлал 50 жилд” МААЭШХ-ийн 50 жилийн ойд зориулсан эмхэтгэл, УБ, Мөнхийн үсэг ХХК, 2011 он;

55. ҮСХ-ны 2020 оны статистикийн мэдээлэл. “Улсын хэмжээнд нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо, үйлчилгээний төрлөөр” хүснэгт
56. “Хонь судлал 50 жилд” МААЭШХ-ийн 50 жилийн ойд зориулсан эмхэтгэл, УБ, Мөнхийн үсэг ХХК, 2011 он;
57. Хүнсний зориулалттай дотор мах, дайвар түүхий эд болон тэдгээрийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MMS 1023 : 2007 стандарт;
58. Цэвээнжав Д. БНМАУ-д Зоотехникийн алба хөгжсөн нь, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 2, 1983 он;
59. Цэрэнсодном Д., Дашгүнсэн Ц. Ямаан сүрэг, эрдэм шинжилгээний бүтээлүүд, Даланзадгад, Говийн мэдээ сонины хэвлэх үйлдвэр, 1978 он;
60. Чадраабал Г. Хонь судлалаар хөлөглөсөн нэгэн жарны бичиг, УБ, 2013 он;
61. Шархүү С. Нутгийн ямааны жингийн хөдлөл зүйг насчилан судалсан дүнгээс Хөдөө аж ахуй сэтгүүл, №2 1982 он;
62. Эм, эмийн түүхий эд, биологийн идэхит бүтээгдэхүүнийг бүртгэх журам [Эрх зүйн акт дэлгэрэнгүй \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)
63. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэгчийн баримт материалд тавигдах шаардлага [cc300cccec3e0a2c06cc450ab961b2343ca5116d.pdf \(moh.gov.mn\)](http://cc300cccec3e0a2c06cc450ab961b2343ca5116d.pdf)
64. Энхтуяа Б., Майзул Б., Атарбаясгалан Н. Монголын бэлчээрийн бог малын мах, Улаанбаатар, “Линограф” хэвлэх үйлдвэр, 2023 он;
65. Энхтуяа Б. нар “Бэлчээрийн монгол малын махны чанарын судалгаа”-ны тайлан, УБ, 2021 он;
66. Энхтуяа Б. нар “Малын дотор маханд суурилсан биологийн идэвхит нэмэлт хүнс үйлдвэрлэх технологийн судалгаа”, ШУТ-ийн төслийн тайлан, I боть, УБ, 2015 он;
67. Энхтуяа Л. “Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи” УБ, 2023 он;
68. Эрдэнэцогт Н. Монгол хурганы жингийн хөдлөл зүй, Хөдөө аж ахуй сэтгүүл, № 2, 1980 он
69. Эрүүл мэндийн тухай хууль (<https://legalinfo.mn/mn/detail/49>)
70. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэгчийн баримт материалд тавигдах шаардлага [cc300cccec3e0a2c06cc450ab961b2343ca5116d.pdf \(moh.gov.mn\)](http://cc300cccec3e0a2c06cc450ab961b2343ca5116d.pdf)
71. “Ямаа судлал 50 жилд” МААЭШХ-ийн 50 жилийн ойд зориулсан эмхэтгэл, УБ, Мөнхийн үсэг ХХК, 2011 он.
72. <http://data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=106746> Шинжлэх ухаан технологийн сан: “Малын дотор маханд суурилсан биологийн идэвхит нэмэлт хүнс үйлдвэрлэх технологийн судалгаа”
73. <http://www.data.stf.gov.mn/Project/ProjectViewPublic.aspx?id=109528> Шинжлэх ухаан технологийн сан: “Малын дайвар бүтээгдэхүүнд суурилсан биологийн идэвхит нэмэлт хүнс үйлдвэрлэх технологийн судалгаа” [Хөдөө аж ахуйн \(ХАА\) шинжлэх ухаан](#)
74. <https://mofa.gov.mn/branch/huns/616facfe73bc4a5fc70f222d> Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа

Б. Гадаад эх сурвалж

1. AM Mullen and C A´ lvarez, Offal: Types and Composition, Teagasc Food Research Centre, Ashtown, Dublin, Ireland, 2016 Elsevier Ltd.
2. Henk W.Hoogenkamp, A fast forward history of meat processing
3. [Ru-Ren Li](#), [Qun-Li Yu](#),* [Ling Han](#), and [Hui Cao](#), Nutritional Characteristics and Active Components in Liver from Wagyu×Qinchuan Cattle, Published online 2014 Apr 30.

4. [Wioletta Biel, Ewa Czerniawska-Piątkowska, and Alicja Kowalczyk, Offal Chemical Composition from Veal, Beef, and Lamb Maintained in Organic Production Systems, PMID: 31357430, Animals \(Basel\), 2019 Aug;](#)
5. Florek M., Litwińczuk Z., Skąłeczki P., Kędzierska-Matysek M., Grodzicki T. Chemical composition and inherent properties of offal from calves maintained under two production systems. Meat Sci. 2012;90:402–409. doi: 10.1016/j.meatsci.2011.08.007. [[PubMed](#)] [[CrossRef](#)] [[Google Scholar](#)]
6. <https://www.precedenceresearch.com/nutritional-supplements-market>
7. <https://oec.world/en/profile/hs/edibleoffal?yearSelector1=2022&yearSelector2=2022&yearSelector5=2021&yearSelector4=2020>
8. <https://oec.world/en/profile/hs/edibleoffal?yearSelector1=2020&yearSelector2=2021&yearSelector5=2021&yearSelector4=2021>
9. <https://dzen.ru/a/YBrycVcfeQaywjEa>
10. <https://www.sperresearch.com/report-store/china-nutritional-supplement-market.aspx>
11. [Negative population growth and population ageing in China | China Population and Development Studies \(springer.com\)](#)
12. [Vitamins & Minerals - China | Statista Market Forecast](#)
13. <https://marketingtochina.com/market-vitamins-health-supplements-china/>
14. <https://as-pacific.com/blog/category-vse-o-biznese-s-kitaem/transgranichnaya-elektronnaya-kommerciya-v-kitae/>
15. Korea Health Functional Food Association, designed by Daxue Consulting, Top health functional foods produced in South Korea in 2022
16. <https://www.artixio.com/post/nutraceutical-regulation-and-registration-in-south-korea-mfds>
17. Korea market brief -Pet food USDA Foreign Agriculture Service, Agriculture Trade Office (ATO)
18. Global Agriculture Information Network, USDA Foreign Agriculture Service Feb 03, 2021
19. Collagen global market report <https://www.thebusinessresearchcompany.com/report/collagen-global-market-report>
20. <https://www.polarismarketresearch.com/industry-analysis/edible-offal-market>
21. Observatory of Economic Complexity 2022
22. Global Agriculture Information Network, USDA Foreign Agriculture Service May 13, 2022, Report no CH2022-0060
23. Global Agriculture Information Network, USDA Foreign Agriculture Service Feb 10, 2023, Report no CH2023-0019
24. Европын парламент, Европын Зөвлөлийн 2009 оны 10-р сарын 21-ний өдрийн 1069/2009 (EC) журам
25. <https://www.insca.org/>

ХАВСРАЛТ

Хавсралт хүснэгт 1. Адууны дотор мах, дайврын хэмжилт хийх анхан шатны бүртгэлийн маягтын загвар-1. Хэмжилт, бүртгэлийг гүйцэтгэх багийн зохион байгуулалт

Адууны дайвар	Байгууллагын нэр:	ПРЕКОМ ХХК	Мал эмнэлгийн гэрчилгээний дугаар №:	5380913	Удирдсан менежер	М.Нэргүй, Б.Ууганцэцэг
	Үйлдвэрийн нэр:	Адууны дотор мах, дайвар боловсруулах үйлдвэр		537031	Малын эмч	Ч.Гаваадагва
	Түүхий эдийн нэр:	Адууны дотор мах, бусад дайвар		5380315	Төслийн ажилтан	Гоёцэцэг, Отгонбаяр
	Зориулалт:	ГТАХоол үйлдвэрлэх зорилгоор дулааны аргаар боловсруулах			Ажилласан цаг	4

Хавсралт хүснэгт 2. Адууны дотор мах, дайврын хэмжилт хийх анхан шатны бүртгэлийн маягтын загвар-2. Төхөөрч буй малын амьд жин, гулуузын жин, гарц, цэвэр махны гарц гэх мэт ерөнхий үзүүлэлтийн талаарх бүртгэлийн загвар

№	Үзүүлэлтүүд	Х/нэгж	2023-11-18		
1	Адууны дугаар	A1-A9	A-1	A-2	A-3
2	Малын толгойн тоо	1-16	1	1	1
3	Амьдын жин	кг	285	368	248.9
4	Гулуузын жин	кг	136.0	176.0	117.0
5	Гулуузын гарц (а.ж-ээс)	%	47.7	47.8	47.0
6	Шулсан махны жин	кг	99.3	129.2	84.2

Хавсралт хүснэгт 3. Адууны дотор мах, дайврын хэмжилт хийсэн анхан шатны бүртгэлийн маягтын загвар-3. Төхөөрч буй малын 1, 2, 3, 4, 5 (а; б) дугаар ангиллын дотор мах, дайвар тус бүрийн биет жингийн үзүүлэлтийг бүртгэх маягтын загвар

Ангилал	№	Дотор эрхтэний нэр	х/н	Адуу-1		Адуу-2		Адуу-3 гэх мэт	
				Бохир жин	Цэвэр жин	Бохир жин	Цэвэр жин	Бохир жин	Цэвэр жин
1-р ангилал Дотор мах	1	Элэг	кг	3.40	3.34	4.50	4.41	3.20	3.21
	2	Зүрх	кг	2.20	1.26	3.00	1.57	2.10	1.19
	3	Уушги	кг	2.30	1.94	2.60	2.18	2.00	1.65
	4	Бөөр	кг	1.20	0.72	1.70	0.81	2.30	0.78
	5	Дэлүү	кг	1.50	0.90	1.50	0.91	0.90	0.82
Дэд дүн			кг	10.60	8.15	13.30	9.88	10.50	7.64
2-р ангилал	6	Бүдүүн гэдэс	кг	19.00	13.53	21.00	16.81	23.00	10.84
	7	Нарийн гэдэс	кг	6.00	4.10	7.82	4.50	4.92	4.20

Дотор гэдэс									
Дэд дүн			кг	25.00	17.63	28.82	21.31	27.92	15.04
3-р ангилал Толгой	8	Чих	кг	0.25	0.08	0.30	0.09	0.33	0.10
	9	Хэл	кг	1.78	0.68	1.83	0.77	1.35	0.53
	10	Толгойн мах	кг	2.19	1.12	2.56	1.31	1.79	0.92
	11	Уруул	кг	0.27	0.14	0.37	0.15	0.31	0.17
Дэд дүн			кг	4.48	2.01	5.05	2.31	3.77	1.71
4-р ангиллын дайвар	12	Өрцний мах	кг	1.60	1.45	1.70	1.51	1.10	0.97
	13	Шөрмөс	кг	0.45	0.26	0.50	0.29	0.40	0.25
	14	Мөгөөрсөн хоолой	кг	0.41	0.23	0.38	0.28	0.33	0.24
	15	Годон	кг	0.29	0.26	0.31	0.30	0.41	0.37
	16	Сэлдээ	кг	0.40	0.26	0.47	0.29	0.49	0.30
	17	Хүнсний өөх	кг	0.63		0.70		0.50	
	18	Сүвээ, далангийн өөх	кг	2.60		2.90		1.90	
Дэд дүн			кг	6.38	2.46	6.96	2.66	5.13	2.12
1-4-р ангиллын нийт дүн			кг	46.46	30.24	54.13	36.15	47.31	26.49
5 (а) ангилал	19	Арьс	кг	16.2	16.2	20.15	20.15	12.6	12.6
5(а) ангиллын дүн			кг	16.20	16.20	20.15	20.15	12.60	12.60
5 (b) ангилал Хүнсний бус дайврын хаягдал	20	Ходоод	кг	0.40		0.54		0.36	
	21	Шийр (шөрмөсгүй)	кг	7.20		8.10		7.34	
	22	Толгойны арьс	кг	1.71		3.33		1.95	
	23	Цус	кг	18.9		21		18	
	24	Дотор махны хаягдал	кг	6.06		11.11		4.71	
	25	Толгойны яс	кг	7.74		10.18		8.36	
	26	Гэдэсний хаягдал	кг	35.50		53.00		30.00	
	27	Шуллагааны хаягдал яс, кг		31.40		38.72		24.60	
	28	Шуллагааны хаягдал	кг		12.56	16.00		9.80	
5(а), 5(b) ангиллын нийт дүн			кг	121.47	161.98		105.12		

Хавсралт хүснэгт 4. Адууны дотор мах, дайврын хэмжилт хийсэн анхан шатны бүртгэлийн маягтын загвар-4. Төхөөрч буй малын дотор мах, дайврын гарцын нэгдсэн дүнгийн маягтын загвар

№	Үзүүлэлтүүд	Х/нэгж	Бүгд	Дундаж
---	-------------	--------	------	--------

1	Адууны дугаар		код	A1-A16			
2	Малын толгойн тоо		1-16	16			
3	Амьдын жин		кг	5,053.90	315.87		
4	Гулуузны жин		кг	2,416.60	151.04		
5	Гулуузын гарц (а.ж-ээс)		%	47.82	47.82		
6	Шулсан махны жин		кг	1,757.14	109.82		
Дотор мах, дайврын ангилал	№	Дотор мах, дайврын нэр	Хэмжих нэгж	Бохир жин	Цэвэр жин	Бохир жин	Цэвэр жин
1-р ангилал Дотор мах	1	Элэг	кг	68.59	65.62	4.29	4.10
	2	Зүрх	кг	38.60	21.46	2.41	1.34
	3	Уушги	кг	40.40	31.36	2.53	1.96
	4	Бөөр	кг	23.40	14.72	1.46	0.92
	5	Дэлүү	кг	16.15	14.07	1.01	0.88
Дэд дүн			кг	187.14	147.22	11.70	9.20
2-р ангилал Дотор гэдэс	6	Бүдүүн гэдэс	кг	332.00	229.22	20.75	14.33
	7	Нарийн гэдэс	кг	103.20	70.37	6.45	4.40
Дэд дүн			кг	435.20	299.58	27.20	18.72
3-р ангилал Толгой	8	Чих	кг	4.69	1.38	0.29	0.09
	9	Хэл	кг	26.35	10.18	1.65	0.64
	10	Толгойн мах	кг	31.04	17.84	1.94	1.11
	11	Уруул	кг	4.74	2.48	0.30	0.16
Дэд дүн				66.82	31.87	4.18	1.99
4-р ангиллын дайвар	12	Өрцний мах	кг	25.33	20.49	1.58	1.28
	13	Шөрмөс	кг	7.39	4.67	0.46	0.29
	14	Мөгөөрсөн хоолой	кг	7.33	4.55	0.46	0.28
	15	Годон	кг	5.84	4.97	0.36	0.31
	16	Чив	кг	7.81	4.90	0.49	0.31
	17	Хүнсний өөх	кг	11.15	0.00	0.70	0.00
	18	Сүвээ, далангийн өөх	кг	40.61	0.00	2.54	0.00
Дэд дүн			кг	105.44	39.57	6.59	2.47
1-4-р ангиллын нийт дүн			кг	794.60	518.23	49.66	32.39

5 (a) ангилал	19	Арьс	кг	284.25	284.25	17.77	17.77
Дэд дүн			кг	284.25	284.25	17.77	17.77
5 (b) ангилал Хүнсний бус дайврын хаягдал	20	Ходоод	кг	6.96	0.00	0.44	0.00
	21	Шийр (шөрмөсгүй)		117.37	0.00	7.34	0.00
	22	Толгойны арьс		30.42	0.00	1.90	0.00
	23	Цус	кг	280.40	0.00	17.53	0.00
	24	Дотор махны хаягдал		81.91	0.00	5.12	0.00
	25	Толгойны яс		149.49	0.00	9.34	0.00
	26	Гэдэсний ялгадас		773.10	0.00	48.32	0.00
	27	Шуллагааны хаягдал яс		550.12	0.00	34.38	0.00
	28	Шуллагааны хаягдал		209.01	0.00	13.06	0.00
5(a), 5(b) ангиллын нийт дүн			кг	2,198.78	0.00	137.42	0.00

-----oOo-----